



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ



ҮНДСЭН
ХУУЛЬТ ЁС
САН

ГЭМТ ХЭРГИЙН ОЛОН УЛСЫН АНГИЛАЛТАЙ ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙГ НИЙЦҮҮЛЭХ БОЛОМЖ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2020 он

ННА 67.408
ДАА 345
Ц - 939



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ



ҮНДСЭН
ХУУЛЬТ ЁС
САН

ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИКИЙН ОЛОН УЛСЫН АНГИЛЛЫГ ҮНДСЭНИЙ СТАТИСТИКТАЙ НИЙЦҮҮЛЭХ БОЛОМЖ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Судалгааны багийн ахлагч:

М.ЦЭДЭВСҮРЭН, ШЕЗ-ийн ШСМСХ-ийн судлаач-багш,
Үндсэн хуульт ёс сангийн судлаач, магистр

Судлаачид:

Т.ЗОЛБОО, МУИС-ийн ХЗС-ийн НЭЗТ-ийн багш,
Үндсэн хуульт ёс сангийн судлаач, магистр

Б.БАТБАЯР, МУИС-ийн ХЗС-ийн НЭЗТ-ийн багш,
Үндсэн хуульт ёс сангийн судлаач, магистр

Зөвлөх:

Ж.ЭРДЭНЭБУЛГАН, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн захирал,
профессор, хууль зүйн доктор

Судалгааны хүрээнд гаргасан дүгнэлт, санал нь зөвхөн судлаачдын үзэл бодол бөгөөд Нээлттэй Нийгэм Форум болон бусад байгууллагын албан ёсны байр суурийг шууд илэрхийлэхгүй болно.

© Нээлттэй Нийгэм Форум, 2020

“Би Си Ай” ХХК-д эхийг бэлтгэж, хэвлэв.

ISBN 978-9919-9645-3-5

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГ	5
УДИРТГАЛ.....	6
ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИКИЙН ОЛОН УЛСЫН АНГИЛЛЫН ТУХАЙ ТОЙМ МЭДЭЭЛЭЛ.....	11
МОНГОЛ УЛС ДАХЬ ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИКИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТОЙМ	22
НЭГ. ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИКИЙН ОЛОН УЛСЫН 01 ДҮГЭЭР АНГИЛАЛ.....	29
1.1. ГХСОУА-ЫН 01 ДҮГЭЭР АНГИЛЛЫН АГУУЛГА.....	29
1.2. ГХСОУА БА ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ДАХЬ ГЭМТ ХЭРГИЙГ ДҮЙЦҮҮЛСЭН ХУВИЛБАР, ТҮҮНИЙГ НӨХӨХ АСУУДАЛ.....	32
1.2.1. Бүрэн хэмжээнд дүйцүүлж болох гэмт хэрэг.....	38
1.2.2. Хэсэгчлэн дүйцүүлж болох гэмт хэрэг.....	40
1.2.3. Бусад асуудал.....	42
1.3. ХЭСГИЙН ДҮГНЭЛТ.....	46
ХОЁР. ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИКИЙН ОЛОН УЛСЫН 02 ДУГААР АНГИЛАЛ.....	48
2.1. ГХСОУ-ЫН 02 ДУГААР АНГИЛЛЫН АГУУЛГА.....	48
2.2. ГХСОУА БА ЭХ ДАХЬ ГЭМТ ХЭРГИЙГ ДҮЙЦҮҮЛСЭН ХУВИЛБАР, ТҮҮНИЙГ НӨХӨХ АСУУДАЛ.....	56
2.2.1. Бүрэн хэмжээнд дүйцүүлж болох гэмт хэрэг.....	69
2.2.2. Зарим хэсгээр дүйцүүлж болох гэмт хэрэг.....	73
2.2.3. Бусад асуудал.....	76
2.3. ХЭСГИЙН ДҮГНЭЛТ.....	79

ГУРАВ. ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИКИЙН ОЛОН УЛСЫН 03 ДУГААР АНГИЛАЛ	80
3.1. ГХСОУА-ЫН 03 ДУГААР АНГИЛЛЫН АГУУЛГА	80
3.2. ГХСОУА БА ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ДАХЬ ГЭМТ ХЭРГИЙГ ДҮЙЦҮҮЛСЭН ХУВИЛБАР, ТҮҮНИЙГ НӨХӨХ АСУУДАЛ	84
3.2.1. Бүрэн хэмжээнд дүйцүүлж болох гэмт хэрэг	89
3.2.2. Зарим хэсгээр дүйцүүлж болох гэмт хэрэг	93
3.2.3. Бусад асуудал	94
3.3. ХЭСГИЙН ДҮГНЭЛТ	97
 ДҮГНЭЛТ	 100
 САНАЛ, ЗӨВЛӨМЖ	 107
 ХАВСРАЛТ 1	 109
 ХАВСРАЛТ 2	 121
 ХАВСРАЛТ 3	 157
 НОМ ЗҮЙ	 178

ТОВЧИЛСОН ҮГ

АТГ	Авлигатай тэмцэх газар
ХТМБТГ	Хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх газар
ГХСОУА	Гэмт хэргийн статистикийн олон улсын ангилал
ГХЦН	Гэмт хэргийн цагаан ном
ГХЧХС	Гэмт хэргийн чиг хандлагын судалгаа
МУ	Монгол Улс
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХЗШУ	Хууль зүйн шинжлэх ухаан
ЦБ	Цагдаагийн байгууллага
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ШБ	Шүүх байгууллага
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ЭХ	Эрүүгийн хууль
ЭХХША	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа
ЭЭЗ	Эрүүгийн эрх зүй

УДИРТГАЛ

Гэмт хэргийн статистикийн мэдээллийг Монгол Улсын Статистикийн тухай хуульд заасны дагуу хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагууд улирал болон хагас, бүтэн жилээр нэгтгэн хүргүүлснийг Үндэсний статистикийн хороо (ҮСХ) олон нийтэд түгээдэг. Мөн жил бүр Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газар (ГХМБТГ)-т гэмт хэргийн чиг хандлагын судалгааг хүргүүлдэг ажээ. Тиймээс хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагууд гэмт хэргийн статистикийн мэдээлэлд тулгуурлан аливаа судалгаа гаргахдаа нэгдсэн ойлголт, арга зүйг баримтлах нь зохистой юм.

Хэдий тийм боловч статистик мэдээлэл, дүйцүүлэх үзүүлэлтийг дээрх байгууллагууд нэгдсэн нэг ойлголтоор бус өөр өөрийн ойлголтоор гаргах, ихэнх үзүүлэлтийг нөхөхгүй орхих асуудлууд практикт тулгарч байна. Энэ нь НҮБ-ын тухайн судалгаанд хамаарах үзүүлэлт манай улсын хууль сахиулах, хуулийн байгууллагаас гаргаж буй статистикийн аль үзүүлэлттэй дүйцэх талаар хангалттай хэмжээний мэдээлэл, гарын авлага, нэгдсэн стандарт, жишиг болохуйц загвар байхгүйтэй холбоотой. Нөгөөтээгүүр Монгол Улс гэмт хэргийн статистикт зориулсан олон улсын ангиллыг үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлээгүй, үндэсний хэмжээнд хэрхэн нийцүүлж мөрдөх эх сурвалжийг боловсруулж, мөрдүүлээгүй байна.

ҮСХ нь “Гэмт хэрэг, шүүхийн статистикийн үзүүлэлт тооцох аргачлал”-ыг хуулийн байгууллагуудын алба хаагчдын санал, шүүмжийг тусган боловсруулж, 2018 онд анх баталж, мөрдүүлснээр энэ чиглэлийн мэдээлэл, нэгдсэн ойлголт авах боломж нээгдсэн. Гэвч энэ аргачлалаар шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах үйл ажиллагаанд холбогдох зарим нэр томъёо, агуулгыг тодорхойлсноос бус НҮБ-ын судалгаа болон Гэмт хэргийн статистикийн олон улсын ангилал (ГХСОУА)-ын үзүүлэлтэд Эрүүгийн хуулийн гэмт хэргийн зүйл ангийг хэрхэн дүйцүүлэх тухай зааврыг хараахан багтаагаагүй. Иймд тухайн байгууллагаас

гарч буй гэмт хэргийн статистик үзүүлэлтийг НҮБ-ын судалгаа болон ГХСОУА-ын үзүүлэлттэй дүйцэх боломжтой эсэхийг судлах зайлшгүй шаардлагатай. Нөгөө талаар, тухайн сэдэв нь Улсын Их Хурал (УИХ)-ын 2017 оны 38 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын статистикийн салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 2.6.1.11-д “гэмт хэргийн олон улсын ангиллыг үндэсний онцлогт тохируулан боловсруулж, мөрдүүлэх” гэсэн зорилтыг хэрэгжүүлэхэд зайлшгүй хийгдэх шаардлагатай ажлын нэг билээ. Тэрчлэн тухайн сэдвийн хувьд дагнасан судалгааны ажил хийгдээгүй, зөвхөн ГХСОУА-ыг ном, бүтээл, судалгааны тайланд дэд сэдэв, тайлангийн хэмжээнд дурдаж, хөндөгджээ.

Иймд ГХСОУА-ын үзүүлэлт (задаргаа)-ийн агуулгыг бүх талаас нь сайтар ойлгож, монгол хэлээр түүний нэр томъёог зөв тодорхойлох, Монгол Улс дахь гэмт хэргийн статистикийн агуулгыг мөн сайтар ойлгох, тэдгээрийг хооронд нь зөв нийцүүлэх боломжийг ГХСОУА-ын 01-11 дүгээр түвшний ангилал (задаргаа)-ын хүрээнд оновчтой тодорхойлон харуулах дагнасан судалгаа шаардлагатай байна.

Дээр дурдсан нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагыг үндэслэн бид “Гэмт хэргийн статистикийн олон улсын ангиллыг үндэсний статистиктай нийцүүлэх боломж” сэдвээр ГХСОУА-ын 11 үзүүлэлтийн тухай ерөнхий ойлголт, үүний дотор 01-03 дугаар ангилалд хамаарах бүх түвшний ангиллын задаргааг нарийвчлан дурдаж, эдгээр үзүүлэлтийг манай улсын гэмт хэргийн статистикийн үзүүлэлттэй хэрхэн нийцүүлж нөхөх боломжтой болохыг судалж гаргахыг зорьсон болно. Улмаар тухайн нэгдсэн арга зүйг холбогдох байгууллагууд эх сурвалж (заавар) болгон ашиглах шаардлагатай бөгөөд ГХСОУА болон манай улсын гэмт хэргийн статистикийн үзүүлэлт хоорондын нийцлийг хэрхэн хангах боломж байна вэ, хуулийн байгууллага дахь статистик, дүн бүртгэл хариуцсан алба хаагчдыг энэ чиглэлээрх нэгдсэн арга зүйгээр хангах орон зайг хэрхэн нөхөж болох вэ? зэрэг асуултын хүрээнд гарц, шийдэл дутагдсаар байна.

Энэхүү асуудлыг судлаачид санаачлан судалж, нийцүүлэх боломжийг эрэлхийлснээр олон улсын судалгаануудад дурдсан ГХСОУА-д хамаарах үзүүлэлтүүдийг “гардаггүй, энэ төрлийн мэдээлэл байхгүй” гэж үзэж байгаа зарим үзүүлэлтийн хувьд нөхөх боломжийг, харин огт нөхөх боломжгүй буюу манай улсад тухайн төрлийн үзүүлэлт бүртгэгддэггүй, нөхөгддөггүй бол тэдгээрийг олж тогтоох, хооронд нь ялган зааглах, олон улсын аливаа судалгааг хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын зүгээс нэгдсэн стандарт, арга зүйгээр нэг ижил ойлголт, агуулгын түвшинд тодорхойлж, үнэн зөв нөхөх (гаргах) боломжийг судалгааны үндсэн дээр дэвшүүлэн харуулах нөхцөл бүрдэх юм.

Ингэснээр практик байгууллагуудад ҮСХ-оос англи хэлээр хүргүүлдэг олон улсын судалгааг гаргахдаа хуулийн байгууллагын статистик хариуцсан албан хаагчдын зүгээс ойлгохгүй байх, ийм үзүүлэлт гардаггүй гэж нөхөх, үзүүлэлтийг харилцан адилгүй агуулгаар ойлгож нөхөж ирсэн уламжлал цаашид давтагдахаас урьдчилан сэргийлэх, үндэсний хэмжээний гэмт хэргийн үзүүлэлтээ олон улсын хэмжээнд үнэн зөв тархааж, судалгааг нэгдсэн стандарт, арга зүйгээр нөхөхөд харгалзан үзэх эх сурвалжийн нэг болгон ашиглах боломжтой.

Тус судалгаа нь хууль сахиулах, хуулийн байгууллагын үйл ажиллагааг хамарсан, өргөн хүрээний асуудал тул судалгааны үр дүн гарсны дараа холбогдох бүх талыг оролцуулсан хэлэлцүүлэг өрнүүлэх, тэдний саналыг сонсох, шаардлагатай тохиолдолд судалгааны үр дүнд саналыг тусгах нь зайлшгүй хийх ёстой ажлын нэг юм. ГХСОУА нь дотроо 11 төрлийн ангилалтай бөгөөд энэ удаад 01-03 дугаар түвшний ангилал буюу манай улсын тухайд түлхүү үйлдэгддэг, хүнд хор уршигтай гэмт хэрэгт хамаарах үзүүлэлтийг сонгон судаллаа. Эхний ээлжид 01-03 дугаар түвшний ангиллыг авч үзэн, туршилтаар хэрэглүүлсний үндсэн дээр бий болсон туршлага, мэдлэгтээ тулгуурлан үлдсэн түвшний ангиллыг үргэлжлүүлэн судалж тогтоосноор Монгол Улс нь ГХСОУА-ын бүх үзүүлэлтэд мэдээ, тайлангаа бүрэн хүргүүлэх боломжтой болно.

Энэ судалгааны үндсэн зорилго бол ГХСОУА-ын бүх түвшинд хамаарах үзүүлэлтийг нарийвчлан судалж, эдгээр үзүүлэлтийг манай улсын гэмт хэргийн статистикийн ямар үзүүлэлтээр хэрхэн нийцүүлж нөхөх боломжтой болохыг тодорхойлоход оршино. Энэ удаагийн судалгаанд ГХСОУА-ын эхний 3 түвшний ангиллыг сонгон авч судаллаа.

Судалгааны ажлын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

- ГХСОУА-д хамаарах 11 төрлийн ангиллыг тоймлон харуулах (04-11 дүгээр ангиллын хувьд энэ удаагийн судалгаанд судлагдаагүй тул 11 төрлийн ангиллыг тоймлон дурдана);
- Монгол Улс дахь гэмт хэргийн статистикийн өнөөгийн ангилал, нөхцөл байдлыг харуулах (албан ёсны болон захиргааны статистикийн батлагдсан маягт, цагдаагийн болон шүүх байгууллагын хэмжээнд бүртгэгдэж, нөхөгдөж буй бусад маягт, мэдээллийн төрлийг судлан, өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлно);
- 01-03 дугаар түвшний ангилал, түцний задаргаа ангиллыг нэг бүрчлэн задалж, үндэсний гэмт хэргийн статистикийн үзүүлэлттэй нийцүүлсэн хувилбарыг харуулах (ангилал, түүний задаргаа нэг бүр үндэсний гэмт хэргийн статистикийн ямар үзүүлэлттэй нийцэж байгааг хүснэгтээр харьцуулан харуулж, холбогдох тайлбарыг тусгана);
- Агуулга бүхэлдээ эсхүл зарим талаараа нийцэж байгаа болон нийцэх боломжгүй ангилал, үзүүлэлтийг ялган харуулж, зарим ангилал, үзүүлэлтийн нэр томъёог монгол хэлээр оноож харуулна (хуулийн байгууллагын алба хаагчид тухайн судалгааг гаргахад ойлгомжтой тодорхой болж, тогтсон нэг нэр томъёо, стандартаар мэдээллийг нөхнө);
- Судалгааны үр дүнг 2020 оны 9-10 дугаар сард цагдаагийн болон шүүх байгууллагад туршиж хэрэглүүлэх

(туршилтын үр дүнг тайланд дурдахгүй, дараагийн ангиллыг хийхэд ашиглана, мөн дараагийн судалгааны үр дүнд энэ талаар танилцуулах боломжтой¹).

Тус судалгааны ажилд ГХСОУА-ын ерөнхий мэдээлэл, цагдаагийн болон шүүх байгууллагын статистикийн ангилал, үзүүлэлтийн талаарх мэдээлэл, ГХСОУА-ын 01-03 дугаар ангилал, түүнд хамаарах үзүүлэлт бүрийг Монгол Улс дахь гэмт хэргийн үзүүлэлттэй харьцуулсан мэдээлэл, агуулга бүхэлдээ нийцэж байгаа, зарим талаараа нийцэж байгаа, нийцэх боломжгүй байгаа ангилал, үзүүлэлтийг ялгаж харуулсан мэдээлэл зэргийг багтаасан бөгөөд манай улсад хэрэглэгддэггүй үзүүлэлтийн хувьд практик байгууллагуудын зүгээс шинээр боловсруулах, өөрчлөх шаардлагатай мэдээллийн маягт, үзүүлэлтийг тайлангийн хавсралт хүснэгтээр тодорхойлон гаргахыг хичээсэн.

Судалгааны ажлыг баримт материал цуглуулж, түүнийг шинжлэн судлах, задлан шинжилж, нэгтгэн дүгнэх ба хэл зүй, үгийн сангийн арга, харьцуулан судлах, статистик шинжилгээ хийх зэрэг арга, арга зүйг ашиглан гүйцэтгэв.

“Гэмт хэргийн статистикийн олон улсын ангиллыг үндэсний статистиктай нийцүүлэх боломж”-ийг судлах нь шинжлэх ухаан, практикийн чухал ач холбогдолтой. Үндэсний хөтөлбөрт тусгагдсан, зайлшгүй судлах шаардлагатай байгаа энэхүү асуудлыг олж харж, судалгааны төсөл зарласан Нээлттэй Нийгэм Форумын хамт олонд болон мэдээлэл харамгүй солилцсон практик байгууллагын алба хаагчдад талархал илэрхийлэхийн ялдамд энэ судалгаа нь Монгол Улс дахь гэмт хэргийн статистикийг хөгжүүлэх, боловсронгуй болгох чиглэлд онцгой хувь нэмэр оруулна хэмээн найдаж байна.

ҮНДСЭН ХУУЛЬТ ЁС сан

¹ Тус судалгааны баг нь ГХСОУА-ын зөвхөн 01-03 дугаар ангиллыг нийцүүлэх хувилбарыг боловсруулаад зогсохгүй, цаашид 04-11 дүгээр ангилалд багтах бүх ангиллын цогц судалгааг үргэлжлүүлэн судлах төлөвлөгөөтэй байгаа болно.

ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИКИЙН ОЛОН УЛСЫН АНГИЛЛЫН ТУХАЙ ТОЙМ МЭДЭЭЛЭЛ

Гэмт хэргийн статистикийн олон улсын ангилал (ГХСОУА) нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ойлголт, тодорхойлолт, зарчимд суурилсан, гэмт хэргийн статистикийн олон улсын харьцуулалт, уялдаа холбоог сайжруулах, олон улсын болон үндэсний хэмжээнд дүн шинжилгээ хийх чадавхыг сайжруулах зорилготой.² Гэмт үйлдлийг тодорхой шалгуураар ангилах нь ихээхэн ач холбогдолтой болохыг бүр 1950-иад оны үед цохон тэмдэглэж байсан³ бөгөөд гэмт хэргийн ангиллын анхны төслийг 2012 онд баталсан байна.⁴ Үүний тулд олон улс орны эрүүгийн хууль тогтоомжийг судалж тодорхой шалгуур үзүүлэлт гаргах замаар боловсруулжээ. Мөн НҮБ-ын ГХМБТГ, Европын эдийн засгийн комисс хамтран гэмт хэргийн статистикт зориулсан олон улсын ангиллыг боловсруулж, 2015 онд нийтэд түгээжээ. Улмаар уг ангиллыг 2016 оноос үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр гэмт хэргийн статистикийн бүх асуулга, үзүүлэлтийг тус ангиллын дагуу боловсруулах болсон байна. НҮБ-ын гишүүн улс, олон улсын байгууллага, шинжээчдийн хамтын идэвхтэй оролцоо, хичээл зүтгэлээр боловсруулсан ГХСОУА-ыг 2015 оны 3 дугаар сард НҮБ-ын ГХМБТГ-аас эрхлэн монгол хэлнээ орчуулан⁵ гаргажээ.

² Гэмт хэргийн статистикийн олон улсын ангилал (ГХСОУА). Хувилбар 1.0. 2015 оны 3 дугаар сар. НҮБ-ын ГХМБТГ-аас боловсруулав. Үндсэн баримт бичгийг хөрвүүлсэн НҮБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газар.

³ United Nations Economic and Social Council. Social Commission. Criminal Statistics: Recommendations of the Secretary-General (8 January 1951). E/CN.5/233.

⁴ United Nations Economic Commission for Europe. Conference of European Statisticians. Report of the UNODC/UNECE Task Force on Crime Classification to the Conference of European Statisticians. 2011. Available: www.unodc.org/documents/data-and-analysis/statistics/crime/Report_crime_classification_2012.pdf. United Nations Economic Commission for Europe. Conference of European Statisticians. Report of the Conference of European Statisticians Sixtieth plenary session (6-8 June 2012). ECE/CES/83.

⁵ Энэхүү хувилбар нь англи хэлнээс хөрвүүлсэн анхны эх байх бөгөөд цаашид гарын авлагын агуулгыг сайжруулах, хуульчилсан нэр томъёог ашиглах, улмаар гарын авлага хэрэглээнд нэвтрэхэд бидний энэхүү судалгааны ажил тодорхой хувь нэмрээ оруулна гэдэгт найдаж байна.

ГХСОУА-ын зорилго нь хууль сахиулах, шүүх эрх мэдлийн зэрэг өөр өөр байгууллагын статистик мэдээллийг системтэй бэлтгэж, харьцуулах үндэс суурийг бий болгох⁶ бөгөөд энэ нь улс орнуудын гэмт хэргийн статистик мэдээллийн харьцуулалт хийгээд ойлголт, тодорхойлолт, мэдээллийг системтэйгээр нэгтгэх, дүн шинжилгээ хийх, тэдгээрийг дэлхий нийтэд түгээх, улмаар үүндээ тулгуурлан тухайн улс орны гэмт хэргийн түвшний өөрчлөлтийг үнэлэх, цаашид хэрэгжүүлэх аливаа бодлого, хөтөлбөртөө тусгах зэрэгт нь нэн чухал ач холбогдолтой.

ГХСОУА-ЫН ОНЦЛОГ ШИНЖҮҮД

ГХСОУА-ын 1-р түвшний 01-03 дугаар ангиллыг судлах явцад уг ангилалд дараах онцлог шинжүүд байгаа нь ажиглагдсан. Үүнд:

- Хохирол, хор уршгаар нь ангилан ялгасан тул гэмт хэргийн улмаас хүний амь нас хохирсон эсэх, эсхүл эрүүл мэнд, эрх чөлөөнд хохирол учирсан эсэх, бэлгийн хохирол учирсан эсэх гэх зэргээр ерөнхийд нь 11 төрөлд ангилжээ.
- Гэмт хэргийн үйлдэл тус бүр өөр өөр ангилалд хамаарч байна. Эрүүгийн хууль (ЭХ)-д заасан нэг зүйл, түүн дотроо хэд хэдэн үйлдэлтэй гэмт хэргийн үйлдэл тус бүр өөр өөр ангилалд хамаарахаар байна. Тухайлбал, МУ-ын ЭХ-ийн 27.10 дугаар зүйлийн 27.10.1 болон 27.10.2 дахь хэсэг нь 02 ангиллын 02063, 02072 гэсэн 3 дугаар түвшний, харин 27.10.3 болон 27.10.4 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас хохирогч “нас барсан” үр дагавар учирсан бол 01 ангиллын 0103 гэсэн 2 дугаар түвшний ангилалд тус тус хамаарч нөхөгдөхөөр байна.
- Гэмт хэргийн холбогдогч, хохирогчийн хамаарлаас шалтгаалан ангилсан байна. Тухайлбал, зарим гэмт хэргийн үзүүлэлт 3 болон 4 дүгээр түвшний ангиллуудад задрахдаа

⁶ Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном - 2017. УБ, 2018. 60 дахь тал

тухайн үйлдлийн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй хүмүүсийн хамаарлаар тодорхойлогдох тохиолдол байна. Жишээлбэл, 02021 ангилал болох Насанд хүрээгүй хүүхдийг хулгайлах тохиолдол эцэг, эх, гэр бүлийн бусад гишүүн, асран хамгаалагч, өөр бусад байдлаар хүүхэд хулгайлах гэсэн задаргаагаар тоолж нөхөхөөр байхад манай улсын тухайд зөвхөн хүүхэд хулгайлах гэмт хэргийн тоог л нөхөхөөр байдаг. Мөн 0210 дугаар ангилал нь Ялгаварлан гадуурхах бөгөөд тэр нь дотроо Хувь хүнийг ялгаварлан гадуурхах, Хэсэг бүлгээр нь ялгаварлан гадуурхах гэж ангилагджээ.⁷

- Улс орон бүрийн ЭХ-ийн системчлэл, бүтэц, гэмт хэргийн төрөл харилцан адилгүй тул тухайн түвшний ангилал бүрийн төгсгөлд тусдаа ангилж нэрлээгүй үлдсэн гэмт хэрэг, түүнд хамаарах үйлдэл, эс үйлдэхүй, үр дагавар, хэм хэмжээний нөхцөлд хамаарах ангиллыг багтаасан байна. Энэ шинжээс харахад ГХСОУА нь аль нэг улсын ЭХ-д тус ангилалд хамаарахгүй үлдэж хоцрох, дүйцэхгүй байх гэмт хэрэг гаргахгүйгээр системчлэгджээ. Тухайлбал, 2-4 дүгээр түвшний ангиллын дугаарын хамгийн сүүлийн орон “9”-ийн тоогоор төгссөн тохиолдлууд бүгд “бусад” гэмт хэргийн агуулгыг өөртөө хамааруулсан, харин 1 дүгээр түвшин дотроо 11 дүгээр ангилал нь 01-10 дугаар ангилалдаа хамаараагүй Монгол Улс (МУ)-ын ЭХ-д үлдсэн “бусад” гэмт хэргийг хамаарсан агуулгатай байна.
- Зөвхөн МУ-ын ЭХ-д гэмт хэрэгт тооцсон үйлдэл, эс үйлдэхүй нь ГХСОУА-д хамаарна. Өөрөөр хэлбэл, эрх зүйн зөрчлийн бусад төрөл, хэлбэр энэхүү ангилалд хамаарахгүй. Тухайлбал, МУ-ын ЭХ-ийн 12.4 дүгээр зүйлд заасан гэмт

⁷ Цэдэвсүрэн М. Гэмт хэргийн статистикийн олон улсын ангиллыг үндэсний онцлогт нийцүүлэх зарим асуудал. ЭРХ ЗҮЙ/NUM LAW REVIEW, 2019 №3 (47), 93-115 дахь талаас дэлгэрүүлж үзнэ үү.

хэрэг нь 2015 оны МУ-ын ЭХ-ийн шинэчилсэн найруулга батлагдах үед гэмт хэрэгт тооцогдож, хуульчлагдсан хэдий ч одоо зөрчилд тооцогдож байгаа. Иймд ГХСОУА-ын 03012 буюу Бэлгийн дарамт учруулах ангилалд Зөрчлийн тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг хамааралгүй юм.

ГХСОУА-д дараах 11 төрлийн⁸ ангилал багтаж байна. Үүнд:

1. Хүний аминд хүрсэн болон завдсан хэрэг;
2. Хувь хүнд хохирол, гэмтэл учруулсан, учруулахыг завдсан хэрэг;
3. Бэлгийн шинж чанартай хохирол учруулсан үйлдэл;
4. Хүний эсрэг хүчирхийлэл, сүрдүүлэг бүхий өмчийн эсрэг үйлдэл;
5. Зөвхөн өмчийн эсрэг үйлдэл;
6. Хяналтад байдаг мансууруулах бодис, бэлдмэлтэй холбоотой хууль бус гэмт хэрэг;
7. Залилан, хууран мэхлэх, авлигын хэрэг;
8. Нийтийн хэв журам, эрх мэдлийн эсрэг үйлдэл;
9. Төрийн хамгаалалт, нийгмийн аюулгүй байдлын эсрэг үйлдэл;
10. Байгаль орчны эсрэг үйлдэл;
11. Өөрөөр ангилаагүй бусад гэмт үйлдэл.

Тус судалгаанд ГХСОУА-ын монгол хэлнээ орчуулсан хувилбарыг голлон⁹ ашигласан хэдий ч манай улсын ЭХ дахь нэр томьёо, ойлголт, агуулга, нэршлийг хэрхэн оноох талаар өөрсдийн саналыг мөн тусгасан болно. Уг ангилал нь олон улсад зориулан гаргасан тул манай улсын ЭХ-ийн нэр томьёо, ухагдахуунаас зарим нэг байдлаар зөрөхийн зэрэгцээ, улмаар НҮБ-аас эрхлэн

⁸ Ангиллуудын нэршлийг НҮБ-аас гаргасан дээр дурдсан баримт бичигт буулгасныг хэвээр оруулав.

⁹ Нэр томьёо илэрхий зөрүүтэй буюу лавлан харах шаардлага үүссэн тохиолдолд англи болон герман хэл дээрх эхийг ашигласан болно.

гаргасан ГХСОУА-ын орчуулгад эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны нэр томъёо, ухагдахууныг ашиглаагүйн улмаас давхар зөрүүтэй байдал үүсэж байгааг онцлон тэмдэглэж байна. Тухайлбал, ГХСОУА-д “Category” гэсэн нэр томъёог хэрэглэсэн бөгөөд энэ нь “Ангилал” гэсэн нэршлээр эх хэлнээ орчуулагдан хэрэглэгдэж хэвшжээ. Эрүүгийн эрх зүйд “гэмт хэргийн төрөл”, “гэмт хэргийн ангилал” гэх тусдаа ойлголт хэрэглэгдэж ирсэн бөгөөд манай улсад “гэмт хэргийн төрөл”-д тодорхой төрлийн гэмт хэрэг буюу ЭХ-ийн зүйл тус бүрд хуульчлан заасан гэмт хэргийг, харин “гэмт хэргийн ангилал”-д тодорхой төрлийн гэмт хэргийг үйлдлийн арга, үйлдэх онцлог, түүний улмаас учрах хор уршиг, үр дагаврын зэрэг шинжээр нь хөнгөн, хүнд гэх зэргээр нэрлэн ойлгож, хэвшсэн уламжлалтай. Иймд ГХСОУА гэх нэршлийг МУ-ын хууль зүйн шинжлэх ухаанд хэрэглэж хэвшсэн гэмт хэргийн ангилал гэх нэршилтэй нэг агуулгатай хэмээн адилтган ойлгож болохгүй.

Харин ГХСОУА-д хамаарч байгаа хэр нь МУ-ын ЭХ-д тусаагүй гэмт хэргийн ангиллын бүтэц, агуулга, системчлэлийг судлах замаар ялгаа зөрөөг танин мэдэх, судалгааны эргэлтэд оруулах, улмаар хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах, боловсронгуй болгох санал боловсруулах, МУ-ын ЭХ-ийн системчлэл, бүтэц, агуулгыг эргэн харах ажлыг төлөвлөн зохион байгуулах боломжтой.

ОЛОН УЛСЫН СУДАЛГААНЫ ТОВЧ АГУУЛГА

Энэхүү судалгааны талаар “Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2018” бүтээлд тодорхой тусгасан¹⁰ бөгөөд тэдгээрийг судалгааны тайлангийн агуулгад уялдуулан энэ хэсэгт тоймлон дурдъя.

Дээрх бүтээлд “НҮБ-ын Гэмт хэргийн чиг хандлагын судалгаа. Гэмт хэргийн статистикт зориулсан олон улсын ангилалд

¹⁰ Хамтын бүтээл. Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2018. 315-331 дэх тал

нийцсэн гэмт хэргийн үндэсний ангилал боловсруулж, батлуулж, мөрдүүлээгүй учраас Монгол Улс НҮБ-ын Гэмт хэргийн чиг хандлагын судалгааны 267 үзүүлэлтээс одоогоор 148 үзүүлэлт (55.4 хувь)-ийг гаргаж, хүргүүлж байна”¹¹ хэмээн дурджээ.

Гэмт хэргийн чиг хандлагын судалгаа нь 2017, 2018 оны Цагаан номд орчуулгатайгаа хэвлэгдсэн бөгөөд үүнээс өмнө хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллага энэхүү судалгааг англи хэл дээр хүлээн авч, тоон мэдээллийг нөхөж ирсэн байдаг. Харин тус судалгаа нь Цагаан номд монгол хэл дээр нийтлэгдсэнээр судалгааг ойлгон хэрэглэх боломж нэмэгдсэн. Хэдий тийм боловч орчуулгад мөн л “санаатай аллага”¹², “мэргэжлийн шүүгчид буюу мастерын зэрэгтэй шүүгч”¹³, “санаатай аллагын хохирогч (0101) хөнөөсөн хүнээр” гэх зэрэг нэр томъёог нягтлах, эргэн харах, хууль тогтоомжид заасан нэр томъёотой уялдуулах шаардлага тулгарч байна.

Гэмт хэргийн чиг хандлагын судалгаа нь үндсэн долоон хэсэг, мөн оршил, заавар, тодорхойлолт хэсгүүдээс бүрдсэн. Судалгааны үндсэн долоон хэсгийг 1-7 хүртэлх цифрээр дугаарласан байгааг харуулбал:

1. Санаатай аллага (intentional homicide)
2. Хүчирхийллийн гэмт хэрэг (Violent crime)
3. Бусад гэмт хэрэг (Other crimes)
4. Эрүүгийн эрх зүйн тогтолцоо (Criminal justice system process)

¹¹ Мөн тэнд, 316 дахь тал

¹² Мөн тэнд, 318 дахь тал. 0101 ангилал буюу Санаатай аллага гэх нэршлийг судалгааны багийн зүгээс ЭХ-ийн агуулгад нийцүүлэх замаар судалгааг гаргаж байгаа алба хаагчид илүү ойлгомжтой нэр томъёоны хувилбарыг судалгааны ажилдаа дэвшүүлсэн болно. Энэ талаар Хавсралт 1-ээс дэлгэрүүлж харна уу.

¹³ Англи хэлнээ “Professional judges or magistrates” гэсэн нэр томъёо байх бөгөөд үүний “magistrate” гэх үг нь академич С.Нарангэрэлийн Хууль зүйн англи-монгол эх тольд “шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэгч албан тушаалтан, ... доод шатны шүүхийн шүүгч” гэх агуулгаар буусан байна. Өөрөөр хэлбэл, энэ нь нэг төрлийн шүүгчийг хэлэх нэршил болохоос шүүгчийн эрдмийн зэргийг илэрхийлэх нэр томъёо биш юм.

5. Хорих (Prison)
6. Эрүүгийн эрх зүйн тогтолцоо, хүний нөөц чадавх (Criminal justice system personal & capacity)
7. Хохирогчийн судалгаа (Victimization survey)

Дээрх жагсаалтаас энэхүү тайлангийн агуулгатай уялдуулан санаатай аллага, хүчирхийллийн гэмт хэрэгт хамаарах судалгааг дэлгэрүүлэн авч үзье.

Санаатай аллагын мэдээлэл. 0101 болон 0102 ангилалд хамаарах гэмт хэргийн тоо, 0101 ангилалд хамаарах завдсан гэмт хэргийн тоо, уг ангилалд хамаарах гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн тоо, хохирогч-холбогдогчийн хамаарлаар, хүйсээр хамаарал бүхий хохирогчийн тоо, амь нас хохирсон гэмт хэрэг үйлдэгдсэн байдлаар, хүйсээр үйлдсэн хохирогчийн тоо, амь нас хохироосон арга хэрэгслээр гэмт хэргийн тоо тус тус хамаарах агуулгатай байна. Эдгээр мэдээллийг дараах үзүүлэлтээр илэрхийлжээ.

Гэмт хэргийн чиг хандлагын судалгааны хүснэгтэд дараах агуулга хамаарахаар байна. Үүнд:

- 0.1- хүний амь насыг хохироосон болон хохироохыг завдсан гэмт хэрэг
- 0.0.1- үйлдэл төгссөн гэмт хэргийн тоо (0101)
- 0.0.2- завдсан гэмт хэргийн тоо (0102)
- 0.2- санаатайгаар хүний амь насыг хохироосон гэмт хэргийн хохирогч, хүйсээр (0101)
 - 1.2.1- нийт хохирогчийн тоо
 - 1.2.a- эрэгтэй хохирогчийн тоо
 - 1.2.b- эмэгтэй хохирогчийн тоо
- 1.3- хүний амь насыг хохироосон гэмт хэргийн хохирогч-холбогдогчийн хамаарал, хүйсээр (0101)
 - 1.3.1- дотно харилцаатай хүн болон гэр бүлийн гишүүнийг хохироосон тоо
 - 1.3.1a- эрэгтэй хүний тоо

- 1.3.1b- эмэгтэй хүний тоо
- 1.3.1.1- дотно харилцаатай хүнийг хохироосон тоо
- 1.3.1.1a- эрэгтэй хүний тоо
- 1.3.1.1b- эмэгтэй хүний тоо
- 1.3.1.2- гэр бүлийн гишүүнийг хохироосон тоо
- 1.3.1.2a- эрэгтэй хүний тоо
- 1.3.1.2b- эмэгтэй хүний тоо
- 1.3.2- хохирогчийг таних бусад хүмүүс хохироосон тоо
- 1.3.2a- эрэгтэй хүний тоо
- 1.3.2b- эмэгтэй хүний тоо
- 1.3.3- хохирогчийг танихгүй хүмүүс хохироосон тоо
- 1.3.3a- эрэгтэй хүний тоо
- 1.3.3b- эмэгтэй хүний тоо

- 1.4- амь нас хохироосон нөхцөл байдал, хохирогч хүйсээр (0101)
- 1.4.1.1- Зохион байгуулалттай бүлэг үйлдсэн
- 1.4.1.1a- эрэгтэй хүний тоо
- 1.4.1.1b- эмэгтэй хүний тоо
- 1.4.1.2- Бусад үйлдэгдсэн байдлаар
- 1.4.1.2a- эрэгтэй хүний тоо
- 1.4.1.2b- эмэгтэй хүний тоо
- 1.4.2- Хүн хүнийг алах
- 1.4.2a- эрэгтэй хүний тоо
- 1.4.2b- эмэгтэй хүний тоо
- 1.4.3- Нийгэм-улс төрийн шалтгаанаар амь нас хохироосон
- 1.4.3a- эрэгтэй хүний тоо
- 1.4.3b- эмэгтэй хүний тоо
- 1.4.3.1- Террорист гэмт хэргийн улмаас амь нас хохироосон
- 1.4.3.1a- эрэгтэй хүний тоо
- 1.4.3.1b- эмэгтэй хүний тоо
- 1.4.4- Үйлдэгдсэн байдал тодорхойгүй амь нас хохироосон

- 1.4.4a- эрэгтэй хүний тоо
- 1.4.4b- эмэгтэй хүний тоо
- 1.5- Хүний амь нас хохироосон гэмт хэргийн хохирогч, үйлдсэн арга хэрэгсэл (0101)
 - 1.5.1- галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис хэрэглэж амь нас хохироосон
 - 1.5.1.1- галт зэвсэг хэрэглэж
 - 1.5.2- бусад зэвсэг хэрэглэж
 - 1.5.2.1- хурц иртэй зүйлээр
 - 1.5.3- зэвсэггүйгээр, бусад арга хэрэгслээр
 - 1.5.4- дурдагдаагүй арга хэрэгслээр

Дээрх мэдээллийн агуулгаас харахад Гэмт хэргийн чиг хандлагын судалгааны 1.1 болон түүний задаргаа нь гэмт хэргийн тоог, харин 1.2 болон бусад хэсэг нь хохирогч буюу холбогдогчийн тоог нөхүүлэхээр байх бөгөөд бүх үзүүлэлтийг жилийн үзүүлэлт¹⁴ гэж тэмдэглэсэн байна. Жилийн үзүүлэлтээс гадна солигддог үзүүлэлтүүд¹⁵ бас нэлээд байх бөгөөд тэдгээр нь хохирогч болон холбогдогчийн нас, харьяалал, тодорхой нутаг дэвсгэрт хамаарах хохирогчийн тоо, холбогдогчийн ял шийтгэлийн байдлыг илэрхийлэх агуулгыг багтаасан.

ХҮЧИРХИЙЛЛИЙН ГЭМТ ХЭРГИЙН МЭДЭЭЛЭЛ

Хүчирхийллийн гэмт хэргийн мэдээлэл дотор ГХСОУА-ын 02, 03, 04 дүгээр ангилалд хамаарах зарим задаргаа ангилал багтсан байна. Өөрөөр хэлбэл, хувь хүнд хохирол учруулах, эсхүл хохирол учрах нөхцөл бүрдүүлсэн гэмт хэрэг болон бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт хамаарах ангилал энэхүү мэдээллийн агуулгад багтсан. Эдгээр мэдээллийг дараах үзүүлэлтээр илэрхийлжээ. Үүнд:

¹⁴ Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном - 2018. УБ., 2019. 320 дахь тал

¹⁵ Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном - 2017. УБ., 2018. 44-46 дахь тал

- 2.1- Хувь хүнд хохирол учруулах, хохирол учруулах нөхцөлийг бүрдүүлэх (02)
 - 2.1.1- хүчтэй довтолгооны улмаас хүнд гэмтэл учруулсан гэмт хэргийн тоо (02011)
 - 2.1.2- хүн хулгайлах гэмт хэргийн тоо (020221)
- 2.2- Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг (03)
 - 2.2.1- бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн тоо (0301)
 - 2.2.1.1- хүчиндэх гэмт хэргийн тоо (03011)
 - 2.2.1.2- бэлгийн дарамт учруулах гэмт хэргийн тоо (03012)
 - 2.2.1.3- бэлгийн хүчирхийллийн бусад гэмт хэргийн тоо (03019)
- 2.3- Хүчирхийлэх, айлган сүрдүүлэх зэргээр бусдын эд хөрөнгийг дээрэмдэх¹⁶ (04)
 - 2.3.1- дээрэмдэх гэмт хэргийн тоо (0401)
- 2.6¹⁷- Бэлгийн хүчирхийллийн хохирогч-холбогдогчийн хамаарал, хүйсээр (0301)
 - 2.5.1a- дотно харилцаатай хүн эсвэл гэр бүлийн гишүүн хохироосон гэмт хэргийн эрэгтэй хохирогчийн тоо
 - 2.5.1b- дотно харилцаатай хүн эсвэл гэр бүлийн гишүүн хохироосон гэмт хэргийн эмэгтэй хохирогчийн тоо
 - 2.5.2a- Хохирогчийг таних бусад этгээд хохироосон гэмт хэргийн эрэгтэй хохирогчийн тоо
 - 2.5.2b- Хохирогчийг таних бусад этгээд хохироосон гэмт хэргийн эмэгтэй хохирогчийн тоо
 - 2.5.3a- хохирогчийг танихгүй хүн хохироосон гэмт хэргийн эрэгтэй хохирогч

¹⁶ НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдсан нэр томъёог ашиглав.

¹⁷ Судалгааны энэ хэсгийн дугаарлалтад алдаа гарсан байх магадлалтай. Учир нь судалгааны дараагийн үзүүлэлтийн дугаарлалт нь 2.5:1a байгаа тул дугаарлалт зөрүүтэй харагдаж байна. Мөн солигддог үзүүлэлтийг судлан үзэхэд 2018 онд авсан судалгаанд 2.6, 2.7, 2.8 гэсэн дугаарлалттай үзүүлэлтээр судалгааг авчээ. Иймд жил бүрийн солигддог үзүүлэлтийн дугаарлалттай холбоотой техникийн шинжтэй алдаа гарсан болов уу. Дугаарлалтыг "Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2018" бүтээлийн 322 дахь талаас дэлгэрүүлэн харна уу.

- 2.5.3b- хохирогчийг танихгүй хүн хохироосон гэмт хэргийн эмэгтэй хохирогч
- 2.5.4a- хамаарал тодорхойгүй хүн үйлдсэн гэмт хэргийн эрэгтэй хохирогчийн тоо
- 2.5.4b- хамаарал тодорхойгүй хүн үйлдсэн гэмт хэргийн эмэгтэй хохирогчийн тоо

Судалгаанд дурдагдсан агуулгаас харахад 2.1, 2.2, 2.3-т дурдсан үзүүлэлтээр гэмт хэргийн тоог, харин бусад үзүүлэлтээр хохирогч-холбогдогчийн хамаарлыг харуулах үзүүлэлтийн дагуу холбогдогчийн тоог хүйсээр нь нөхүүлэхээр байна.

Ер нь олон улсын судалгаа нь үндсэн 3 агуулгаас бүрдэж байна гэж хэлж болно. Эхний хэсэгт гэмт хэргийн тоог, дараах хэсэгт дээр дурдсан гэмт хэргийн холбогдогчийн тоо, гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн тоог тус тус нөхөхөөр байна. Хохирогчийн тоог нөхүүлэхдээ хохирогч-холбогдогчийн хоорондын хамаарлыг харуулах агуулга зонхилж, эдгээр үзүүлэлтийг хүйсээр ялган харуулах задаргаа үзүүлэлтийг судалгаанд заавал тусгаж өгсөн байгаа нь анхаарал татаж байна.

МОНГОЛ УЛС ДАХЬ ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИКИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТОЙМ

Олон улсын түвшин дэх гэмт хэргийн статистикийн ангилал, бүтэц, агуулгын талаар судлан үзэхийн өмнө үндэсний хэмжээнд гэмт хэргийн статистикийг боловсруулж, судалгааны эргэлтэд оруулан, олон нийтийг мэдээллээр хангаж байгаа өнөөгийн нөхцөл байдлыг судлах нь чухал байна. Хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллага нь үйл ажиллагааны үр дүнгээ олон нийтэд тоон мэдээллээр дамжуулан мэдээлж ирсэн.

Эрх зүйн зөрчил түүн дотроо гэмт хэрэг нь өөрийн үр дагавар, хор хохирлын шинжээрээ бусад зөрчлөөсөө хамгийн хүнд байх тул нийгэмд энэ төрлийн мэдээллийн эрэлт хэрэгцээ, ач холбогдол хамгийн чухал байр суурь эзэлсээр байна. Гэмт хэргийн тоон мэдээллийг бүртгэх, нэгтгэх, улмаар статистик мэдээлэл болгон боловсруулах ажил тухайн байгууллагын хэмжээнд хийгдэж, нийтэд тархаах үйл ажиллагаа нь ҮСХ-оор дамжин практикт хэрэгжиж хэвшсэн бөгөөд 2016-2018 онд “Гэмт хэргийн статистикийг боловсронгуй болгох нь” сэдэвт шинжлэх ухаан технологийн төсөл хэрэгжиж, үүний дүнд хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын гэмт хэргийн статистикийг нэгтгэн уялдуулах зорилгоор томоохон ажлууд хийгджээ.

Төслийн хүрээнд өрнөсөн олон төрлийн үйл ажиллагааны нэг нь “Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном” эрхлэн гаргах явдал байсан бөгөөд энэхүү ажилд төслийн багийн нийт хамт олон, хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын төлөөлөл идэвх санаачилгатай хамтран ажилласны дүнд Монгол Улсад гэмт хэргийн статистикийг боловсруулах, нөхөх ажлыг эрхлэн хэрэгжүүлдэг байгууллагуудын нэгдсэн статистик мэдээллийг нэг эх сурвалжаас харах, ашиглах, судалгааны эргэлтэд оруулах өргөн боломж нээгдсэн юм.

Иймд энэхүү судалгаанд Монгол Улс дахь гэмт хэргийн статистикийн өнөөгийн нөхцөл байдлыг “Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2018”¹⁸-ыг эх сурвалж болгон түүнд дурдагдсан статистик мэдээлэлд үндэслэн, дараах асуудлын хүрээнд тоймлон хөндье.

1. СТАТИСТИКИЙН БҮТЭЦ

Статистик мэдээлэл нь албан ёсны болон захиргааны гэсэн үндсэн хоёр хэлбэртэй¹⁹ байх бөгөөд ер нь байгууллагын дотоод мэдээллийн санд тухайн байгууллага, түүний үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан статистик мэдээлэл болон боловсруулагдаагүй бусад тоон мэдээлэл бий. Эдгээр нь ихэвчлэн зарим ерөнхий үзүүлэлтийг нарийвчлан задалсан, дэлгэрүүлсэн, түүний шалтгаан нөхцөлийг харуулах, илэрхийлэх зорилготой мэдээлэл эсвэл нийтэд түгээх шаардлагагүй, зөвхөн байгууллага дотоод хэрэгцээндээ ашиглах зорилгоор боловсруулсан ажлын ачаалал, бусад хүчин зүйлийг илэрхийлэх агуулгатай үйл ажиллагааны үе шат бүрийн мэдээлэл байдаг.

“Гэмт хэргийн цагаан ном 2018”-ын хавсралтад дурдсан статистик мэдээллийг судалж үзэхэд, бүтцийг дараах хэлбэрээр тоймлон илэрхийлэх нь илүү ойлгомжтой байна. Үүнд:

1. ЭХ-ийн зүйл, хэсэг, заалтын дүнгээр;
2. Бүртгэсэн-хянасан-шийдвэрлэсэн гэмт хэргийн дүнгээр;
3. Бүртгэсэн-хянасан-шийдвэрлэсэн-ял эдэлж байгаа холбогдогчийн дүнгээр;

¹⁸ Энэхүү бүтээл нь 2019 оны сүүлээр нийтийн хүртээл болсон бөгөөд хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн бүх байгууллагын үйл ажиллагаанд хамаарах статистик мэдээллийг агуулдаг тул 2018 оны мэдээллийг 2019 оны 3 дугаар сараас эхлэн боловсруулж, 2019 оны сүүлээр энэхүү бүтээлд тусган хэвлүүлэх боломж бүрдсэн байна.

¹⁹ Статистикийн тухай хуулийн 5.1 дэх хэсэг.

4. Холбогдогчийн нас, хүйс, нийгмийн байдал, иргэний харьяалал, ял шийтгэлийн төрөл, хохирлын дүнгээр;
5. Хохирогчийн нас, хүйс, нийгмийн байдал, иргэний харьяалал, учирсан хохирлын дүнгээр;
6. Бусад дүнгээр.

Гэмт хэргийн статистикийн бусад статистикаас ялгарах шинж нь дараалсан, эсвэл дахин давтагдсан үе шатаас бүрдсэн, хуулийн хэд хэдэн байгууллагын үйл ажиллагаанд хамаарах ба үзүүлэлт нь **хэрэг, хүн** гэсэн үндсэн хоёр үзүүлэлтээр зэрэгцэн гардагт оршдог. Ялангуяа гэмт хэрэг, мөн ял шийтгүүлсэн хүнд хамаарах мэдээлэл нь Шүүхийн статистик буюу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа (ЭХХША)-ны үр дүнг илэрхийлэх, шийдвэрлэлтийн талаарх хамгийн чухал мэдээллийг агуулж байдаг. Харин ГХСОУА-ын агуулгаас харахад гэмт хэрэгт холбогдогчийн мэдээлэл²⁰ бус гэмт хэргийн тоон мэдээллийг авах агуулгатай байдаг.

2. ҮЗҮҮЛЭЛТИЙН АГУУЛГА

Маягтын мөрөөр. Гэмт хэргийн статистикийн үндсэн агуулга нь өмнө дурдсанчлан гэмт хэргийн статистикийн өөрийн бүтцээс ихээхэн хамаарч ЭХ-ийн зүйл, хэсэг, заалтын дүнгээр илэрхийлэгдэж байна. Тухайлбал, ЭХ-ийн 10 дугаар бүлгийн 10.1 дүгээр зүйл буюу Хүнийг алах гэмт хэргийг жишээ болгон дурдъя. Энэ гэмт хэрэг нь ЭХ-д зүйл болон хуульчлагдаж өөртөө дараах заалт, хэсгийг хамааруулжээ.

10.1 дүгээр зүйл:

10.1.1 дэх хэсэг

10.1.2 дахь хэсэг:

10.1.2.1-10.1.2.14 дэх заалт

²⁰ Холбогдогч эсвэл хохирогч гэх хэргийн тоогоор бус “хүний тоогоор” гарах мэдээлэл нь ОУ-ын судалгаанд голчлон үзүүлэлт болсон.

Гэмт хэргийн статистик мэдээлэл нь ЭХ-ийн зүйлийн дүнгээр хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагаас шууд гарах боломжтой байгаа бол зарим байгууллагын хувьд дээр дурдсан ЭХ-ийн хэсэг, болон заалтад хамаарах дүнгүүд мөн гарах боломжтой, бусад байгууллагын хувьд энэ дүн гарах боломжгүй байна. Иймд хамгийн багаар бодоход хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн нийт байгууллагын хэмжээнд ЭХХША-ны нэгдсэн статистик мэдээллийг ЭХ-ийн зүйл ангиар²¹ илэрхийлэгдэх үзүүлэлтүүдээр дамжуулан авах боломжтой гэж ойлгож болох юм.

Харин цаашид зүйлийн дүнгээр хязгаарлахгүйгээр ЭХ-ийн заалт, хэсэгт хамаарах мэдээллийг бүх байгууллагын хэмжээнд авах боломжийг бүрдүүлэх нь чухал.

Маягтын баганаар. Гэмт хэргийн статистикийн мөрийн дагуух үзүүлэлт нь ЭХ-ийн зүйл, хэсэг, заалтад хамаарах мэдээлэлд харгалзуулан бүртгэгдсэн гэмт хэргээс авхуулаад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тодорхой ажиллагаа, үе шатыг харуулах мэдээллийн агуулгыг илэрхийлж байна. Ийнхүү илэрхийлэхдээ холбогдогчийн нас, хүйс, нийгмийн байдал, оногдуулсан ял шийтгэлийн мэдээлэл нь нийт мэдээллийн зонхилох хувийг эзэлжээ.

3. ГОЛЛОХ МЭДЭЭЛЭЛ

Цагдаагийн болон шүүх байгууллага гэмт хэргийн статистикийн бүтэн жилийн тайлан мэдээгээ нэгтгэн эмхэтгэж, нийтэд түгээдэг. Иймд эдгээр байгууллагын нийтэд түгээдэг мэдээллийн агуулгаар гэмт хэргийн статистикийн голлох мэдээллийг төлөөлүүлэн Хүснэгт 1-д харуулав.

²¹ Монгол Улс дахь Гэмт хэргийн цагаан ном - 2018. УБ., 2019. Хавсралт хэсгийн зүйлээр харуулах статистик мэдээллийн хэсгээс дэлгэрүүлж харна уу.

*Хүснэгт 1. Цагдаагийн болон шүүх байгууллагын гэмт хэргийн
статистикийн голлох мэдээлэл*

№	Цагдаагийн байгууллагын үзүүлэлт	№	Шүүхийн үзүүлэлт
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	1	Хүнийг алах
2	Хүнийг алах гэмт хэрэг	2	Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах гэмт хэрэг
3	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	3	Хүчиндэх гэмт хэрэг
4	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг	4	Хулгайлах гэмт хэрэг
5	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	5	Дээрэмдэх гэмт хэрэг
6	Хүчиндэх	6	Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах
7	Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	7	Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг
8	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	8	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг
9	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	9	Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэг
10	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	10	Залилах гэмт хэрэг
11	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	11	Хүн худалдаалах гэмт хэрэг
12	Хулгайлах гэмт хэрэг	12	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах
13	Залилах гэмт хэрэг	13	Бусад
14	Дээрэмдэх гэмт хэрэг		
15	Эдийн засгийн гэмт хэрэг		
16	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг		
17	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг		

Хүснэгт 1-ийн үргэлжлэл

18	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг
19	Авлигын гэмт хэрэг
20	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг
21	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг
22	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг
23	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг
24	Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг
25	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг
26	Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг

Дээрх мэдээллийн агуулгаас харахад цагдаагийн байгууллага ЭХ-ийн бүлэг, мөн тухайн бүлэг дэх тодорхой төрлийн зарим гэмт хэргийн дүнг голлох мэдээлэл болгон нийтэд түгээж байгаа бол шүүхийн хувьд тодорхой төрлийн зарим гэмт хэргийн дүнг түгээж байна. Тус байгууллагуудын тодорхой төрлийн зарим гэмт хэрэгт давхцал гарч байгаа нь тухайн гэмт хэрэг нийгмийн аюулын шинж өндөртэй, түлхүү үйлдэгддэгтэй холбоотой. Мэдээллийг хооронд нь харьцуулбал мэдээлэл олж авах, судалгааны эргэлтэд оруулах талаасаа цагдаагийн байгууллагын мэдээлэл давуутай байна. Тухайлбал, ЭХ-ийн бүлэг болон тодорхой төрлийн зарим гэмт хэргийн мэдээллийн аль алиныг авах боломжтой.

Монгол Улс дахь гэмт хэргийн статистикийн өнөөгийн нөхцөл байдлыг нэгтгэн дүгнэвэл, өмнөхтэй харьцуулахад илүү нарийвчлагдаж, дэлгэрэнгүй хэлбэрээр боловсруулагдан, нийтэд түгээгдэж байгаагийн зэрэгцээ хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагууд энэ чиглэлээр олон төрлийн хамтарсан ажил төлөвлөн хэрэгжүүлж байгаа дүр зураг харагдаж байна. Мөн гэмт хэргийн статистик мэдээллийг хууль зүйн салбарын бусад статистик мэдээлэл, эрх зүйн бусад зөрчлийн мэдээлэлтэй харьцуулахад илүү нарийвчилсан, өргөн цар хүрээг хамарсан давуу тал ажиглагдлаа

Манай улсад боловсруулагдаж буй статистик мэдээллийн агуулгаас үзэхэд, ЭХХША-ны үе шат бүрийн мэдээллийг ЭХ-ийн зүйл, хэсгийн дүнгээр буюу ЭХ-ийн системчлэлийн дагуу харуулж байна. Тухайлбал, ямар төрлийн гэмт хэрэг хэд бүртгэгдэж, хянагдаж, шийдвэрлэгдэж, тухайн гэмт хэргийн улмаас хэдэн хүн ял шийтгүүлж, ялтан болсныг харуулж байгаа бөгөөд энэ нь гэмт хэргийн статистикийн зайлшгүй хэрэгцээт мэдээллийг агуулжээ. Цаашлаад энэ статистик нь тухайн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг харуулах агуулгатай байна.

Гэвч гэмт хэргийн статистик мэдээлэл нь зөвхөн ЭХ-ийн зүйл, хэсэгт хамаарах мэдээллээр хязгаарлагдах ёсгүй бөгөөд гэмт хэрэг, гэмт үйлдлийн учир шалтгаан, харилцан хамаарал, зүй тогтол, үйлдлийн арга хэрэгсэл, үйлдэгдсэн шинж байдал гэх зэргийг агуулах шаардлагатай. Үүний дүнд гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судлах, хохирогч-холбогдогчийн хамаарал, гэмт хэрэг болон хохирогч, хохирлын хамаарлыг хамтад нь зэрэгцүүлэн авч үзэх замаар гарсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх бодлогоо шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлоход чухал ач холбогдолтой. Үндсэндээ энэ зорилгын дагуу боловсруулсан цогц мэдээлэл нь гэмт хэргийн статистикийн ач холбогдлыг илэрхийлнэ.

НЭГ. ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИКИЙН ОЛОН УЛСЫН 01 ДҮГЭЭР АНГИЛАЛ²²

ГХСОУА-ын 1-р түвшний 01-11 хүртэл 11 төрлийн бүлэг ангилал байгаагаас гэмт хэргийн хохирол, үр дагаврын хувьд хамгийн хүнд төрлийн гэмт хэрэг, тэдгээрт хамаарах үйлдлийг 01 дүгээр ангилалд хамааруулсан байдаг. 01 дүгээр ангилал нь өөртөө 14 ангиллыг багтаах бөгөөд тус ангилалд хамаарах гэмт хэргийг ЭХ-ийн бүлэг, зүйл, хэсгээс нь түүвэрлэх замаар дүйцүүлэн боловсрууллаа.

1.1. ГХСОУА-ЫН 01 ДҮГЭЭР АНГИЛЛЫН АГУУЛГА

ГХСОУА-ын 01 дүгээр ангиллыг судалж, ЭХ-д заасан гэмт хэрэгтэй дүйцүүлэхэд гэмт хэргийн улмаас хүний амь нас хохирох үр дагавартай гэмт хэрэг үйлдэж төгссөн, эсвэл завдсан бүх тохиолдлыг 01 дүгээр ангилалд хамааруулахаар байна. Гэвч эдгээр гэмт хэрэг нь ЭХ-ийн хэд хэдэн бүлэг, түүний зүйл, хэсэг, заалтад хамаарахаар байх тул дээрх үр дагавар бүхий гэмт хэргийг орхигдуулахгүйгээр бүгдийг энэ ангилалд багтаан хамааруулах нь чухал юм.

ГХСОУА-д category гэсэн нэр томъёог хэрэглэсэн нь “ангилал” гэсэн нэршлээр эх хэлнээ орчуулагдаж, хэрэглэгдэж хэвшсэн. 01 дүгээр ангиллын агуулгыг ойлгомжтой илэрхийлэх зорилгоор хүснэгтэд шилжүүлж, жишээ болгон харууллаа (Хүснэгт 2).

²² ГХСОУА-ын энэ ангилалд хамаарах судалгааг судлаач М.Цэдэвсүрэн боловсруулав.

Хүснэгт 2. ГХСОУА-01 дүгээр ангилал, англи хэлээр²³

№	Level 1	Level 2	Level 3	Level 4	2019	2020	Comments
1	Acts leading to death or intending to cause death						
2		Intentional homicide					
3		Attempted intentional homicide					
4		Non-intentional homicide					
5			Non-negligent manslaughter				
6			Negligent manslaughter				
7				Vehicular homicide			
8				Non-vehicular homicide			
9				Assisting or instigating suicide			
10				Assisting suicide			
11				Other acts of assisting or instigating suicide			
12		Euthanasia					
13		Illegal feticide					
14		Unlawful killing associated with armed conflict					
15		Other acts leading to death or intending to cause death					

²³ Хүснэгтэд дурдсан нэр томьёо нь ГХСОУА-ын англи хэл дээрх албан ёсны нэр томьёо болно.

Хүснэгт 3. ГХСОУА-01 дүгээр ангилал, монгол хэлээр²⁴

№	1-р түвшний үзүүлэлт	2-р түвшний үзүүлэлт	3-р түвшний үзүүлэлт	4-р түвшний үзүүлэлт	2019	2020	Тайлбар
1	Хүний аминд хүрсэн болон хүрэхийг завдсан						
2		Санаатай аллага					
3		Санаатай аллага үйлдэхээр завдах					
4	Санамсаргүй аллага						
5	Хайхрамжгүй бус байдлаар үйлдсэн хүн амины хэрэг						
6	Хайхрамжгүйгээс санамсаргүй үйлдсэн хүн амины хэрэг						
7				Тээврийн хэрэгслээр хүний амь хороох			
8				Тээврийн хэрэгслийн оролцоогүй хүний амь хороох			
9				Амиа хорлоход туслах, өдөөн турхирах бусад үйлдэл			
10				Амиа хорлоход туслах			
11				Амиа хорлоход туслах, өдөөн турхирах бусад үйлдэл			
12	Эдгэшгүй өвчин туссан хүнийг үхүүлэх						
13	Хууль бус үр хөндөлт						
14	Зэвсэгт мөргөлдөөнтэй холбоотой хууль бус аллага						
15	Үхэлд хүргэсэн, эсвэл үхэлд хүргэхийг завдсан хэрэг						

²⁴ Хүснэгтэд дурдсан нэр томъёо нь ГХСОУА-ыг орчуулсан НҮБ-ын гарын авлагад дурдсан нэр томъёо болно.

Дээрх Хүснэгт 3-т үзүүлсэн мэдээлэл нь монгол хэл дээрх ГХСОУА-ын 01 дүгээр ангиллын агуулгыг нэг мөр ойлгож, хэрэглэхэд зориулсан хувилбар болно.

НҮБ-аас зарим төрлийн судалгааг тогтмол хугацаанд гишүүн улсуудаас гаргуулж авдаг. Тухайлбал, жил бүрийн намар авдаг Гэмт хэргийн чиг хандлагын судалгаа (ГХЧХС)²⁵-г энд дурдаж болно. Энэ судалгааны үзүүлэлтэд ГХСОУА-ын зарим ангилал багтсан байдаг. Гэвч энэ судалгааг бөглөж байгаа тухайн байгууллагын статистик хариуцсан алба хаагчдад нэгдсэн арга зүй, заавар бүхий гарын авлага, эх сурвалж байхгүй тул тухайн судалгаанд дурдагдсан ангилал, үзүүлэлтийг өөр өөрийн хэмжээнд ойлгож, нөхөж ирсэн байна.

1.2. ГХСОУА БА ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ДАХЬ ГЭМТ ХЭРГИЙГ ДҮЙЦҮҮЛСЭН ХУВИЛБАР, ТҮҮНИЙГ НӨХӨХ АСУУДАЛ

Дүйцүүлэх хувилбарыг боловсруулах явцад ГХСОУА-ын зарим ангилал ЭХ-ийн тодорхой төрлийн гэмт хэргийн агуулгатай бүрэн дүйцэж байна. Харин зарим ангиллын хувьд одоогийн статистик мэдээллээр шууд нөхөгдөх боломжгүй ангиллууд бас байгаа нь судалгааны үр дүнд тодорхой болсон юм.

Иймд зөвхөн дүйцүүлэх хувилбарыг харуулаад зогсохгүй дүйцэж буй гэмт хэргийн тоог судалгаанд нөхөх боломж хэр байгааг хамтатган судалж, судалгааны тайлангийн хавсралт хүснэгтэд ангилал тус бүрд холбогдох тайлбар, зааврыг тусгалаа.

ГХСОУА-ыг үндэсний хэмжээн дэх гэмт хэргийн төрөлтэй дүйцүүлэх ажлыг хийх болсон гол шалтгаан нь дүйцэж байгаа гэмт хэргийнхээ тоон мэдээллийг НҮБ-аас ирүүлсэн судалгаанд

²⁵ Энэ судалгааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2017, 2018 бүтээлүүд болон энэхүү тайланд орсон “Олон улсын судалгаа” хэсгээс тус тус харна уу.

нөхөж хүргүүлэх явдал юм. Ингэснээрээ олон улсад (ОУ)-д гэмт хэргийн ангиллын дагуу өөрийн орны мэдээллийг бусад улс орны мэдээлэлтэй харьцуулан судлах, дүгнэх ажилд оролцох, үр дүнг харах, бодлого шийдвэр гаргахдаа ашиглах боломж бүрдэх тул дүйцүүлсэн гэмт хэрэг, түүний статистик мэдээллийг хэрхэн нөхөх тухай асуудал нь энэхүү судалгааны ажлын салшгүй хэсэг юм.

Судлаачдын зүгээс дүйцүүлэх хувилбарыг боловсруулахдаа “бүрэн хэмжээнд” болон “зарим хэсгээр” дүйцэж байна хэмээн тодорхойлсон нь манай улсын гэмт хэргийн статистикийн үзүүлэлтүүд хийгээд статистик мэдээллийг боловсруулан тархааж буй хэлбэртэй шууд холбоотой. Статистик мэдээлэл нь үндэсний хэмжээнд ЭХ-ийн тусгай ангид заасан гэмт хэргийн бүлэг, зүйл, хэсэг, заалтын дүнгээр гардаг. Энэхүү мэдээллээр ГХСОУА-ын 1 болон 2 дугаар түвшний зарим ангиллыг нөхөх боломжтой хэдий ч 3 болон 4 дүгээр түвшний зарим ангиллын хувьд ЭХ-ийн нэг зүйл түүний доторх нэг заалт, хэсгийн доторх аль нэг үйлдэл, эсвэл үр дагаварт л хамаарах нөхцөлөөр агуулга нь илэрхийлэгдсэн ангилал нэлээд хэмжээнд байх тул ГХСОУА-ыг нөхөх боломжгүй нөхцөл байдалтай тулгарч байна.

Иймд дээр дурдсан хүндрэл тулгараагүй тохиолдолд “бүрэн хэмжээнд”, харин эсрэгээрээ бол “зарим хэсгээр” дүйцэж болох юм гэдэг байдлаар дүйцүүлэх хувилбарыг ялгаж, хүснэгтээр харууллаа (Хүснэгт 4).

Хүснэгт 4. ГХСОУА-ын 01 дүгээр ангилалд МУ-ын ЭХ дахь гэмт хэргийг дүйцүүлсэн хувилбар

ГХСОУА-ын дугаар	МУ-ын ЭХ-ийн бүлэг, зүйл, хэсгийн дугаар	Гэмт хэргийн нэр (үйлдэл, эсвэл үр дагаврын шинжийг харуулах тухайн зүйл, хэсэг, заалтын агуулга)
01	ЭХ-д заасан дараах бүлэг, зүйл, хэсэг, заалт хамаарч байна. 10.1, 10.2.1, 10.3.1, 10.4.1, 10.5.1, 10.6, 11.1.2.5, 12.1.3, 12.1.4, 12.3.3.1, 13.4.4.2, 15.1.3, 15.2.2.2, 15.3.3, 15.4.1, 15.5, 16.2.2, 16.3.2, 16.11.3, 19.3.2, 19.5, 20.6.2, 20.11.2.1, 20.12.2.1, 20.13.1, 20.14.3.1, 20.15.2, 20.16.2.4, 23.5.2, 24.1.2.1, 24.3.2.1, 24.7.3.1, 27.2.1, 27.3.1, 27.6.2, 27.7.3, 27.8.2.3, 27.9.1, 27.10.3, 27.10.4.2, 28.9.2, 28.10.2.2, 28.11.2, 29.5.1, 29.7.2, 29.8.1	ГХСОУА-ын 2-р түвшний 0101, 0102, 0103, 0104, 0105, 0106, 0107, 0109 ангиллуудад дурдсан бүрэн болон зарим хэсгээр дүйцэх тайлбар энэ хэсэгт нэгэн адил ²⁶ хамаарна.
0101	10 дугаар бүлэг. 10.1, 10.2.1, 10.3.1, 10.4.1, 10.5.1 19 дүгээр бүлэг. 19.3.2 29 дүгээр бүлэг. 29.5.1, 29.7.2, 29.8.1 Тайлбар: дээрх зүйл хэсэгт хамаарах үйлдэл төгссөн гэмт хэрэг хамаарна.	10.1 дүгээр зүйл. Хүнийг алах (бүрэн хэмжээнд) 10.2 дугаар зүйл. Санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүнийг алах (10.2.1 бүрэн хэмжээнд) 10.3 дугаар зүйл. Баривчлах, таслан зогсоох хэр хэмжээг хэтрүүлж хүнийг алах (10.3.1 бүрэн хэмжээнд) 10.4 дүгээр зүйл. Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх (10.4.1 бүрэн хэмжээнд)

²⁶ 1-р түвшний 01 ангилал нь өөртөө 2-р түвшний 0101-0107, 0109 ангиллыг багтаасан бөгөөд эдгээр ангиллын агуулгын нийлбэрээр 01 дүгээр ангилал өөрөө бүрдэх тул 0101-0107, 0109 дүгээр ангилал бүр дэх тайлбар мэдээллийн агуулга нь 01 дүгээр ангиллын агуулгатай нэгэн адил болно. Иймд хүснэгтийн энэ нүдэнд мэдээллийг давтаж оруулах, нуршихаас сэргийлэн дээрх тэмдэглэлийг оруулсан болно.

Хүснэгт 4-ийн цргэлжлэл

ГХСОУА-ын дугаар	МУ-ын ЭХ-ийн бүлэг, зүйл, хэсгийн дугаар	Гэмт хэргийн нэр (үйлдэл, эсвэл үр дагаврын шинжийг харуулах тухайн зүйл, хэсэг, заалтын агуулга)
		<p>10.5 дугаар зүйл. Эх нярай хүүхдээ алах (10.5.1 бүрэн хэмжээнд)</p> <p>19.3 дугаар зүйл. Төрийн өндөр албан тушаалтны амь биед халдах (19.3.2 бүрэн хэмжээнд)</p> <p>29.5 дугаар зүйл. Төрлөөр устгах (29.5.1 зарим хэсгээр)</p> <p>29.7 дугаар зүйл. Олон улсын хамгаалалтад байдаг хүнд халдах (29.7.2 зарим хэсгээр)</p> <p>29.8 дугаар зүйл. Террорист үйлдэл хийх (29.8.1 зарим хэсгээр)</p> <p>ЭХ-ийн 29.5 дугаар зүйлд заасан зөвхөн “Үндэс, угсаа, арьсны өнгө, шашны тодорхой бүлгийг устгах зорилгоор хүнийг алсан”, 29.7 дугаар зүйлд заасан зөвхөн “олон улсын хамгаалалтад байдаг хүнийг алсан”, 29.8 дугаар зүйлд заасан зөвхөн “хүнийг алсан” үр дагаварт хүргэсэн тохиолдлууд хамаарахаар байна.</p>
0102	<p>10 дугаар бүлэг. 10.1, 10.2.1, 10.3.1, 10.4.1, 10.5.1</p> <p>19 дүгээр бүлэг. 19.3.2</p> <p>29 дүгээр бүлэг. 29.5.1, 29.7.2, 29.8.1</p> <p>Тайлбар: дээрх зүйл хэсэгт хамаарах гэмт хэрэгт завдсан тохиолдлууд хамаарна.</p>	<p>0101 ангилалд дүйцүүлсэн дээр дурдсан зүйл, хэсэг бүгд хамаарна. Бүрэн хэмжээнд эсвэл зарим хэсгээр нөхөх талаарх тайлбар мөн 0101 ангилалтай ижил. Харин энэ ангиллын хувьд практикт завдсан тохиолдлыг тусад нь нөхөж гаргадаг үзүүлэлт батлагдсан маягтуудад байхгүй тул нөхөх үзүүлэлтийг маягтад шинээр нэмэх замаар мэдээллийг гаргах шаардлагатай. Иймд дүйцүүлэх гэмт хэргүүд нь энэхүү хувилбарын дагуу тодорхой болж болох ч нөхөх мэдээлэл байхгүй гэдгийг анхаарах хэрэгтэй.</p>

Хүснэгт 4-ийн үргэлжлэл

ГХСОУА-ын дугаар	МУ-ын ЭХ-ийн бүлэг, зүйл, хэсгийн дугаар	Гэмт хэргийн нэр (үйлдэл, эсвэл үр дагаврын шинжийг харуулах тухайн зүйл, хэсэг, заалтын агуулга)
0103	10.6 дугаар зүйл. 11.1 дүгээр зүйл. 11.1.2.5 12.1 дүгээр зүйл. 12.1.4 13.4 дүгээр зүйл. 13.4.4.2 15.1 дүгээр зүйл. 15.1.3 15.2 дугаар зүйл. 15.2.2.2 15.3 дугаар зүйл. 15.3.3 15.4 дүгээр зүйл. 15.4.1 15.5 дугаар зүйл. 15.5.3 16.2 дугаар зүйл. 16.2.2 16.3 дугаар зүйл. 16.3.2 16.11 дүгээр зүйл. 16.11.3 20.6 дугаар зүйл. 20.6.2 20.15 дугаар зүйл. 20.15.2 28.9 дүгээр зүйл. 28.9.2 28.10 дугаар зүйл. 28.10.2.2 28.11 дүгээр зүйл. 28.11.2 20.11 дүгээр зүйл. 20.11.2.1 20.12 дугаар зүйл. 20.12.2.1 20.13 дугаар зүйл. 20.13.1 20.14 дүгээр зүйл. 20.14.3.1 20.16 дугаар зүйл. 20.16.2.4 23.5 дугаар зүйл. 23.5.2 24.1 дүгээр зүйл. 24.1.2.1 24.3 дугаар зүйл. 24.3.2.1 24.7 дугаар зүйл. 24.7.3.1 27.2 дугаар зүйл. 27.2.1 27.3 дугаар зүйл. 27.3.1 27.6 дугаар зүйл. 27.6.2 27.7 дугаар зүйл. 27.7.3 27.8 дугаар зүйл. 27.8.2.3 27.9 дүгээр зүйл. 27.9.1 27.10 дугаар зүйл. 27.10.3, 27.10.4	ЭХ-ийн 10.6, 11.1.2.5, 15.5.3, 16.11.3, 27.10.3, 27.10.4.2, 28.9.2-т заасан гэмт хэргийг бүрэн хэмжээнд. Доор дурдсан гэмт хэргийг зарим хэсгээр буюу зөвхөн “хохирогч нас барсан”, “хүний амь нас хохирсон” үр дагаварт хамаарах хэсгээр дүйцүүлэн нөхөхөөр байна. ЭХ-ийн 12.1.4, 13.4.4.2, 15.3.3, 15.4.1, 16.2.2, 16.3.2, 20.6.2, 20.15.2, 28.10.2.2, 28.11.2 дугаар хэсэгт заасан зөвхөн “хохирогч нас барсан” үр дагавар, харин 20.11.2.1, 20.12.2.1, 20.13.1, 20.14.3.1, 20.16.2.4, 23.5.2, 24.1.2.1, 24.3.2.1, 24.7.3.1, 27.2.1, 27.3.1, 27.6.2, 27.7.3, 27.8.2.3, 27.9.1 дүгээр хэсэг, заалтад заасан зөвхөн “амь нас хохирсон” үр дагавар.
01031	-	-
01032	20.6 дугаар зүйл. 20.6.2 20.15 дугаар зүйл. 20.15.2 27.10 дугаар зүйл. 27.10.3, 27.10.4.2	20.6 дугаар зүйл. Галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хамгаалахад хайнга хандах (20.6.2 зарим хэсгээр) 20.15 дугаар зүйл. Орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгах (20.15.2 зарим хэсгээр) 27.10 дугаар зүйл. Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих (27.10.3, 27.10.4.2 бүрэн хэмжээнд)

Хүснэгт 4-ийн үргэлжлэл

ГХСОУА-ын дугаар	МУ-ын ЭХ-ийн бүлэг, зүйл, хэсгийн дугаар	Гэмт хэргийн нэр (үйлдэл, эсвэл үр дагаврын шинжийг харуулах тухайн зүйл, хэсэг, заалтын агуулга)
010321	27.10 дугаар зүйл. 27.10.3 27.10 дугаар зүйл. 27.10.4.2	27.10.3. Энэ гэмт хэргийн улмаас хүний амь нас хохирсон (бүрэн хэмжээнд) 27.10.4.2. энэ гэмт хэргийн улмаас хоёр, түүнээс олон хүний амь нас хохирсон (бүрэн хэмжээнд)
010322	20.6.2. Энэ гэмт хэргийн улмаас хүний эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, хохирогч нас барсан 20.15.2. Энэ гэмт хэргийн улмаас хүний эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, хохирогч нас барсан	20.6.2. Энэ гэмт хэргийн улмаас хүний эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, хохирогч нас барсан (зарим хэсгээр) 20.15.2. Энэ гэмт хэргийн улмаас хүний эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, хохирогч нас барсан (зарим хэсгээр)
0104	10.4 дүгээр зүйл. 10.4.1	10.4 дүгээр зүйл. Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх (10.4.1 бүрэн хэмжээнд)
01041	-	-
01049	10.4 дүгээр зүйл. 10.4.	10.4 дүгээр зүйл. Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх (бүрэн хэмжээнд)
0105	-	-
0106	15.5 дугаар зүйл. 15.5.1, 15.5.2	15.5 дугаар зүйл. Хууль бусаар үр хөндөх (15.5.1, 15.5.2 бүрэн хэмжээнд) Мөн 15.5 дугаар зүйлийн дүнгээс 15.5.3 дахь хэсгийг хасаж гарсан мэдээллээр нөхөх боломжтой.
0107	-	-
0109	15.1 дүгээр зүйл. 15.1.3 15.2 дугаар зүйл. 15.2.2.2	15.1 дүгээр зүйл. Эмнэлгийн тусламж үзүүлэхгүй байх (15.1.3 бүрэн хэмжээнд) 15.2 дугаар зүйл. Аюултай байдалд орхих, тусламж үзүүлэхгүй байх (15.2.2.2 бүрэн хэмжээнд)

ГХСОУА-ын бүтэц, агуулгыг судлан үзэхэд хамгийн бага нэгж дэх задаргаа буюу 4-р түвшний ангилал нь 3-ыг, 3 нь 2-ыг, 2 нь 1-р түвшний ангиллаа бүрдүүлж өгч байна. Өөрөөр хэлбэл, 1-р түвшний буюу 2 оронтой тооноос бүрдсэн ангиллын агуулгыг ойлгохын тулд хамгийн бага нэгж дэх 4-р түвшний ангиллын агуулгыг эхлээд

ойлгох шаардлагатай болно. Иймд 01 дүгээр ангиллын агуулгыг судлахдаа эхлээд 4-р түвшний ангиллыг, дараа нь 4-р түвшний нийт ангиллын агуулгаар 3-р түвшний ангиллыг, түүний дараа эдгээрийн агуулгаар 2-р түвшний ангиллын агуулгыг, хамгийн сүүлд нь 1-р түвшний ангиллыг ойлгож, танин мэдэх нь чухал.

Дээрх арга зүйн дагуу судалгааг хийх нь нэг түвшний ангилал дотор, мөн ижил түвшний ангилал хооронд 1 гэмт хэрэг давхар тоологдохоос сэргийлэх боломжийг бүрдүүлж өгөх юм.

1.2.1. Бүрэн хэмжээнд дүйцүүлж болох гэмт хэрэг²⁷

0101 ангилал. Энэ ангилалд бүрэн хэмжээнд дүйцэж болох МУ-ын ЭХ дахь хохирогч нас барсан буюу амь нас хохирсон үр дагавар бүхий үйлдлээр төгссөн дараах гэмт хэргүүд багтана. Үүнд:

10.1 дүгээр зүйл. Хүнийг алах (10.1.1, 10.1.2)

10.2 дугаар зүйл. Санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүнийг алах (10.2.1)

10.3 дугаар зүйл. Баривчлах, таслан зогсоох хэр хэмжээг хэтрүүлж хүнийг алах (10.3.1)

10.4 дүгээр зүйл. Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх (10.4.1)

10.5 дугаар зүйл. Эх нярай хүүхдээ алах (10.5.1)

19.3 дугаар зүйл. Төрийн өндөр албан тушаалтны амь биед халдах (19.3.2)

0102 ангилал. Энэ ангилалд бүрэн хэмжээнд дүйцэж болох ЭХ дахь хохирогч нас барах буюу амь нас хохирох үр дагавар бүхий гэмт хэрэгт завдсан тохиолдлууд хамаарна. Үүнд:

10.1 дүгээр зүйл. Хүнийг алах (10.1.1, 10.1.2)

²⁷ Энэ хэсэгт хамаарч буй гэмт хэргийн талаарх тайлбарыг тайлангийн 1 дүгээр бүлгийн 1.2 дахь хэсгийн Хүснэгт 3 болон Хавсралт 1-ээс тус тус дэлгэрүүлж харах боломжтой.

10.2 дугаар зүйл. Санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүнийг алах (10.2.1)

10.3 дугаар зүйл. Баривчлах, таслан зогсоох хэр хэмжээг хэтрүүлж хүнийг алах (10.3.1)

10.4 дүгээр зүйл. Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх (10.4.1)

10.5 дугаар зүйл. Эх нярай хүүхдээ алах (10.5.1)

19.3 дугаар зүйл. Төрийн өндөр албан тушаалтны амь биед халдах (19.3.2)

0103 ангилал. Энэ ангилалд бүрэн хэмжээнд дүйцэж болох ЭХ дахь дараах гэмт хэргүүд байна. Үүнд:

10.6 дугаар зүйл. Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох (10.6)

11.1 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах (11.1.2.5)

15.5 дугаар зүйл. Хууль бусаар үр хөндөх (15.5.3)

16.11 дүгээр зүйл. Хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх (16.11.3)

27.10 дугаар зүйл. Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих (27.10.3, 27.10.4.2)

28.9 дүгээр зүйл. Байлдааны зэвсэг, галт хэрэгсэл, орчиндоо аюул учруулж болох бусад хэрэгсэлтэй харьцах журам зөрчих (28.9.2)

01032 ангилал. Энэ ангилалд бүрэн хэмжээнд дүйцэж болох МУ-ын ЭХ дахь дараах гэмт хэргүүд байна. Үүнд:

27.10 дугаар зүйл. Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих (27.10.3, 27.10.4.2)

010321 ангилал. Энэ ангилалд бүрэн хэмжээнд дүйцэж болох ЭХ дахь дараах гэмт хэрэг байна. Үүнд:

27.10 дугаар зүйл. Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих (27.10.3, 27.10.4.2)

0104 ангилал. Энэ ангилалд бүрэн хэмжээнд дүйцэж болох ЭХ дахь дараах гэмт хэрэг байна. Үүнд:

10.4 дүгээр зүйл. Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх (10.4.1)

0109 ангилал. Энэ ангилалд бүрэн хэмжээнд дүйцэж болох ЭХ дахь дараах гэмт хэргүүд байна. Үүнд:

15.1 дүгээр зүйл. Эмнэлгийн тусламж үзүүлэхгүй байх (15.1.3)

15.2 дугаар зүйл. Аюултай байдалд орхих, тусламж үзүүлэхгүй байх (15.2.2.2)

Дээр дурдсан ангиллыг ЭХ-ийн холбогдох зүйл, хэсэг, заалтаар бүрэн хэмжээнд дүйцүүлэн нөхөх боломжтой байна.

1.2.2. Хэсэгчлэн дүйцүүлж болох гэмт хэрэг²⁸

0101 ангилал. Энэ ангилалд холбогдуулан хэсэгчлэн дүйцүүлж болох хохирогч нас барсан буюу амь хохирсон үр дагавар бүхий үйлдэл төгссөн дараах гэмт хэрэг ЭХ-д байна. Үүнд:

29.5 дугаар зүйл. Төрлөөр устгах (29.5.1)

29.7 дугаар зүйл. Олон улсын хамгаалалтад байдаг хүнд халдах (29.7.2)

29.8 дугаар зүйл. Террорист үйлдэл хийх (29.8.1)

0102 ангилал. Энэ ангилалд ЭХ дахь амь хохирох, хохирогч нас барах үр дагавар бүхий гэмт хэрэгт завдсан тохиолдол хамаарна. Үүнд:

29.5 дугаар зүйл. Төрлөөр устгах (29.5.1)

²⁸ Энэ хэсэгт хамаарч буй гэмт хэргийн талаарх тайлбарыг тайлангийн 1 дүгээр бүлгийн 1.2 дахь хэсгийн Хүснэгт 2 болон Хавсралт 1-ээс тус тус дэлгэрүүлж харах боломжтой.

29.7 дугаар зүйл. Олон улсын хамгаалалтад байдаг хүнд халдах (29.7.2)

29.8 дугаар зүйл. Террорист үйлдэл хийх (29.8.1)

0103 ангилал. Энэ ангилалд зарим хэсгээр дүйцэж болох ЭХ дахь дараах гэмт хэргүүд байна. Үүнд:

ЭХ-ийн 12.1.4, 13.4.4.2, 15.3.3, 15.4.1, 16.2.2, 16.3.2, 20.6.2, 20.15.2, 28.10.2.2, 28.11.2 дугаар хэсэгт заасан зөвхөн “хохилогч нас барсан” үр дагавар, харин 20.11.2.1, 20.12.2.1, 20.13.1, 20.14.3.1, 20.16.2.4, 23.5.2, 24.1.2.1, 24.3.2.1, 24.7.3.1, 27.2.1, 27.3.1, 27.6.2, 27.7.3, 27.8.2.3, 27.9.1 дүгээр хэсэг, заалтад заасан зөвхөн “амь нас хохирсон” үр дагавар бүхий тохиолдлууд хамаарна.

01032 ангилал. Энэ ангилалд зарим хэсгээр дүйцэж болох ЭХ дахь дараах гэмт хэргүүд байна. Үүнд:

20.6 дугаар зүйл. Галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хамгаалахад хайнга хандах (20.6.2)

20.15 дугаар зүйл. Орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгах (20.15.2)

010322 ангилал. Энэ ангилалд зарим хэсгээр дүйцэж болох ЭХ дахь дараах гэмт хэргүүд байна. Үүнд:

20.6 дугаар зүйл. Галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хамгаалахад хайнга хандах (20.6.2)

20.15 дугаар зүйл. Орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгах (20.15.2)

0106 ангилал. Энэ ангилалд зарим хэсгээр дүйцэж болох ЭХ дахь дараах гэмт хэрэг байна. Үүнд:

15.5 дугаар зүйл. Хууль бусаар үр хөндөх (15.5.1, 15.5.2)

Дээр дурдсан ангиллыг ЭХ-ийн холбогдох зүйл, хэсэг, заалтын зарим хэсгээр дүйцүүлэн нөхөх боломж болох нь судалгаанаас харагдаж байна.

1.2.3. Бусад асуудал

01 дүгээр ангилалд хамаарах бусад ангилал. Тайлангийн 1 дүгээр бүлгийн 1.1.2-т дурдагдаагүй үлдсэн 2-р түвшний 0105 болон 0107, 3-р түвшний 01031 болон 01041 ангиллууд байгаа бөгөөд тодорхой шалтгааны улмаас нөхөх боломжгүй байна.

01031 ангилал. 0103 ангилалд дүйцүүлсэн ЭХ-ийн хэд хэдэн бүлэг, зүйл, хэсэг, заалтад хамаарах гэмт хэрэг бүрийг 01031 буюу Хайхрамжгүй бус байдлаар үйлдсэн хүн амины хэрэг болон 01032 буюу Хайхрамжгүйгээс санамсаргүй үйлдсэн хүн амины хэрэг хэмээн тус тусад нь ангилж байж дүйцүүлэх гэмт хэрэг тодорхой болохоор байна. Иймд цаашид судлаачид, практик байгууллагын төлөөллийн хүрээнд хэлэлцүүлэх замаар хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллага энэ асуудлаар нэгдсэн нэг ойлголттой болж байж энэ ангиллын дүйцүүлэх хувилбарыг эцэслэн гаргаж, нэгдсэн агуулгаар нөхөх боломжтой болно.

01041 ангилал. 0104 ангилалд ЭХ-ийн 10.4 дүгээр зүйлд заасан гэмт хэргийг дүйцүүлсэн тул 0104 дүгээр ангиллын задаргаа болох 01041 болон 01049 ангиллын аль нэгэнд нь дүйцэх логик хамааралтай. ЭХ-ийн 10.4 дүгээр зүйлд хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэргийг хуульчилж өгсөн бөгөөд холбогдогчийн зүгээс хохирогчийг амиа хорлоход хүргэх үр дагавартай хуульд заасан үйлдэл хийсэн байхыг ойлгоно. Энэ нь “Эд хөрөнгө, албан тушаал, гэр бүлийн хамаарал бүхий харилцаа, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа хүнийг байнга хүчирхийлсэн, доромжилсон, зодсон, тамлан зовоосон, айлган сүрдүүлсний улмаас амиа хорлоход гарцаагүй хүргэсэн”²⁹ үйлдэл байх учиртай. Гэтэл 01041 ангиллын агуулгаас харахад хүчирхийлсэн, доромжилсон, зодсон, тамлан зовоосон, айлган сүрдүүлсэн үйлдлийн агуулгатай дүйцэхээргүй байна. Иймд 01041 ангилалд дүйцүүлэх боломжгүй тул түүнийг нөхөх боломжгүй юм.

²⁹ Эрүүгийн хуулийн 10.4 дүгээр зүйл

0105 ангилал. Энэ ангилалд заасан гэмт хэргийг ЭХ-иар гэмт хэрэгт тооцоогүй тул нөхөх боломжгүй.

0107 ангилал. ЭХ-ийн 19.5 дугаар зүйлд “Зэвсэгт үймээн дэгдээх” гэмт хэрэг хуульчлагдсан хэдий ч энэ гэмт хэрэгт хохирогч нас барсан, амь хохирсон үр дагавар бүхий гэмт хэрэг хуульчлагдаагүй тул 0107 ангиллыг нөхөх хувилбар байхгүй болно.

Нэр томьёог ойлгож, хэрэглэх асуудал. 1-р түвшний 01 ангилал болон түүний доторх 14 ангиллын агуулга бүхэлдээ хүний амь нас хохироосон болон хохироохыг завдсан гэмт хэрэг, түүнд хамаарах үйлдэл, эс үйлдэхүйг багтаажээ.

Иймд ГХСОУА-ыг сонирхон судлагч, албан ажлын шаардлагаар уг ангиллын дагуу судалгаа, мэдээлэл нөхдөг байгууллага ГХСОУА-ын нэр томьёог дараах агуулгаар ойлгож, хэрэглэх нь зохистой байна. Үүнд:

Хүснэгт 5. ГХСОУА-ын 01 дүгээр ангиллын монгол хэл дээрх нэр томьёог боловсронгуй болгох санал

Ангиллын дугаар	Англи эх дэх нэр томьёо	НУБ-ын гарын авлага дахь нэр томьёо	Судлаачдын хувилбар
01	Acts leading to death or intending to cause death	Хүний аминд хүрсэн болон хүрэхийг завдсан	Хүний амь нас хохироосон болон хохироохыг завдсан
0101	Intentional homicide	Санаатай аллага	Хүний амь насыг санаатайгаар хохироох
0102	Attempted intentional homicide	Санаатай аллага үйлдэхээр завдах	Хүний амь насыг санаатайгаар хохироох гэмт хэрэгт завдсан
0103	Non-intentional homicide	Санамсаргүй аллага	Хүний амь нас хохирсон бусад гэмт хэрэг
01031	Non-negligent manslaughter	Хайхрамжгүй бус байдлаар үйлдсэн хүн амины хэрэг	Хөнгөмсгөөр найдсаны улмаас хүний амь нас хохирсон
01032	Negligent manslaughter	Хайхрамжгүйгээс санамсаргүй үйлдсэн хүн амины хэрэг	Хайхрамжгүй хандсаны улмаас хүний амь нас хохирсон
010321	Vehicular homicide	Тээврийн хэрэгслээр хүний амь хороох	Тээврийн хэрэгслийн улмаас хүний амь нас хохирсон

Хүснэгт 5-ын үргэлжлэл

Ангиллын дугаар	Англи эх дэх нэр томьёо	НҮБ-ын гарын авлага дахь нэр томьёо	Судлаачдын хувилбар
010322	Non-vehicular homicide	Тээврийн хэрэгслийн оролцоогүй хүний амь хороох	Тээврийн хэрэгслийн улмаас хүний амь нас хохирсноос бусад байдлаар хүний амь нас хохирсон гэмт хэрэг
0104	Assisting or instigating suicide	Амиа хорлоход туслах, өдөөн турхирах бусад үйлдэл	Амиа хорлоход туслах, хүргэх
01041	Assisting suicide	Амиа хорлоход туслах	-
01049	Other acts of assisting or instigating suicide	Амиа хорлоход туслах, өдөөн турхирах бусад үйлдэл	Амиа хорлоход туслах болон амиа хорлоход хүргэсэн бусад үйлдэл
0105	Euthanasia	Эдгэшгүй өвчин туссан хүнийг үхүүлэх	-
0106	Illegal feticide	Хууль бус үр хөндөлт	Хууль бусаар үр хөндөх
0107	Unlawful killing associated with armed conflict	Зэвсэгт мөргөлдөөнтэй холбоотой хууль бус аллага	-
0109	Other acts leading to death or intending to cause death	Үхэлд хүргэсэн, эсвэл үхэлд хүргэхийг завдсан бусад хэрэг	Амь насыг хохироосон болон хохироохыг завдсан бусад гэмт хэрэг

Хувилбарыг дэвшүүлэхдээ манай улсын хууль тогтоомжид нэгэнт тогтсон гэмт хэргийн нэршил, эрүүгийн эрх зүйн салбарт хэрэглэж хэвшсэн нэр томьёог ашиглан боловсрууллаа. Өөр өөр байгууллага мэдээллийг нөхөхдөө тогтож хэвшсэн агуулгаар оноон хэрэглэвэл судалгааны мэдээллийг нөхөхөд хялбар болох юм.

Үүний зэрэгцээ ГХСОУА-ыг нэгдмэл агуулгаар зөв ойлгож, өөр өөрийн үйл ажиллагаанд хамаарах хэсгээ нөхөх нь судалгааны үр дүнд чухал нөлөөтэй. Судлаачдын хувьд маргаан бүхий, эсхүл тодорхой бус нэр томьёонд өөрсдийн хувилбарыг дэвшүүлсэн тул бусад нэр томьёог НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдсаны дагуу ойлгож, хэрэглэх боломжтой. Мөн ойлгомжгүй, тодорхой бус нэр томьёоны асуудлаар хууль сахиулах, шүүх эрх мэдлийн

байгууллага болон эрдэмтэн судлаачдын дунд хэлэлцүүлэг өрнүүлэх замаар нэг мөр ойлголтод хүрэх, гарын авлагын агуулгыг сайжруулах нь гэмт хэргийн үндэсний статистикийг олон улсын гэмт хэргийн статистиктай нийцүүлэх, улмаар бусад улс оронтой өөрийн орны гэмт хэргийн нөхцөл байдлыг харьцуулан судлахад ихээхэн ач холбогдолтой болно.

Дүйцүүлэх хувилбарын дагуу тоон мэдээллийг нөхөх асуудал ГХСОУА-ыг ЭХ-д заасан гэмт хэрэгтэй дүйцүүлэх хувилбарыг боловсруулах явцдаа түүний дагуу тоон мэдээллийг хэрхэн нөхөх, бидэнд байгаа болон байхгүй мэдээллийг тодорхой түвшинд судаллаа. Иймд дүйцүүлж буй гэмт хэргийг хэрхэн нөхөх талаар тодорхой жишээг доор дурдлаа.

Жишээ 1.

01 дүгээр ангилалд үйлдэл төгссөн болон завдсан гэмт хэргийг хамааруулсан. Гэтэл манай улсын тухайд гэмт хэргийн статистик мэдээлэл нь ЭХ-ийн тусгай ангийн бүлэг, зүйл, хэсгийн дүнгээр нөхөгдөн гардаг тул үйлдэл төгссөн болон завдсан гэсэн агуулгаар тус тусдаа гардаггүй. Тиймээс шүүхийн статистик мэдээллийн маягтын 10.1 дүгээр зүйлийн дүнд хамаарах шийдвэрлэсэн хэргийн тоог харуулсны дараа энэ гэмт хэрэгт завдсан үзүүлэлтийг нэмж өгвөл анхан шатны мэдээлэгч нар маягтын дагуу мэдээллийг нөхөх боломжтой болох юм. Яг үүнтэй адил шууд нөхөх боломжгүй бусад ангиллыг тухайн байгууллагын статистик мэдээллийн маягтад тусад нь үзүүлэлт болгон нэмж оруулах талаар энэхүү судалгааны ажлын хавсралт хүснэгтэд тухай бүр тэмдэглэсэн болно.

Жишээ 2.

Судалгааны тайлан болон түүний хавсралтад “зарим хэсгээр” дүйцүүлэн нөхөхөөр байгаа гэмт хэргийн хувьд дээр дурдсаны адил дүйцэж байгаа зарим хэсгийнхээ агуулгаар тусад нь үзүүлэлт болгон тоолж бүртгэх шаардлагатай. Тухайлбал, ЭХ-ийн 29.5, 29.7, 29.8 дугаар зүйлд заасан гэмт хэрэг дэх ердийн болон хүндрүүлэх бүрэлдэхүүн дэх агуулгаас ГХСОУА-ын 01 дүгээр ангилалд дүйцэх нь зөвхөн “хохирогч нас барах, амь хохирох” агуулгад хамаарах гэмт хэрэг, эсвэл энэ гэмт хэрэгт завдсан тохиолдлууд хамаарах тул шүүхийн статистик мэдээлэл дэх ЭХ-ийн дээрх зүйлүүдийн дүнгээс зөвхөн амь хохирох, нас барах үр дагаварт хамаарах үйлдэл төгссөн болон завдсан агуулгыг маягтаар тусад нь гаргах үзүүлэлт болгон нэмж өгснөөр мэдээллийг тоолж бүртгэх, улсын дүнг нэгтгэх ажил хийгдэх боломжтой болно.

1.3. ХЭСГИЙН ДҮГНЭЛТ

ГХСОУА-ын 1-р түвшний 01 ангилал нь дотроо 14 ангиллыг багтаадаг. Агуулгыг бүхэлд нь судлан үзэхэд ЭХ-д заасан хүний амь нас хохирсон эсвэл хохирох гэмт хэрэгт завдсан тохиолдлуудыг хамруулахаар байна. Өөрөөр хэлбэл, ийм үр дагавар бүхий гэмт хэргүүдийг ЭХ-иас түүвэрлэх замаар энэхүү ангилал, түүний доторх задаргаа ангиллыг дүйцүүлэх, нөхөх ажил тус тус хийгдэхээр байна.

01 дүгээр ангиллын доторх 14 ангилалд гэм буруу, үйлдэл болон үр дагаврын ялгамжтай байдлыг шалгуур болгон санаатайгаар хүний амь насыг хохироох, энэ гэмт хэрэгт завдах, болгоомжгүйгээр хохироох, үүний дотор хөнгөмсгөөр найдах, хайхрамжгүй хандах, мөн хүнийг амиа хорлоход туслах, ийм үр дагаварт хүргэх, эдгэшгүй өвчин туссан хүнийг үхүүлэх, зэвсэгт мөргөлдөөний улмаас хүний амь нас хохирсон, хууль бусаар үр хөндсөн, амь насыг хохироосон, эсвэл хохироохыг завдсан бусад гэмт хэрэг гэж төрөлжүүлэн ангилжээ.

Практикаас харахад, бүрэн хэмжээнд дүйцүүлсэн гэмт хэргийн хувьд одоо байгаа статистик мэдээллээс шууд нөхөх боломжтой байгаа бол зарим хэсгээр дүйцүүлсэн гэмт хэрэг нь шууд нөхөгдөх боломжгүй, нэмэлт мэдээлэл заавал шаардагдахаар байна. Иймд нэмэлт мэдээлэл шаардагдаж байгаа ангиллыг цаашид хэрхэн нөхөх асуудлыг анхаарах шаардлагатай.

1-р түвшний 01 дүгээр ангилалд огт нөхөх боломжгүй ангилал мөн байна. Тухайлбал, ЭХ-д гэмт хэрэгт тооцоогүй үйлдэл эсхүл хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллага нэгдсэн ойлголцолд хүрээгүйн улмаас гаргадаггүй мэдээлэл үүнд хамаарч байна.

НҮБ-аас орчуулан гаргасан ГХСОУА-ын гарын авлагад дурдагдсан нэр томъёог ангиллын агуулга болон дүйцүүлэн нөхөж буй гэмт хэргийн агуулгатай уялдуулан судлах нь ихээхэн практик ач холбогдолтой юм. Учир нь тус орчуулгад 01 дүгээр ангиллын

хүрээнд аллага, хүний аминд хүрэх, хүн амины хэрэг, хүний амь хороох гэх зэргээр олон төрлийн нэршил өгчээ. Энэ нь хүнийг алах гэмт хэргийг гэм буруугийн санаатай болон болгоомжгүй хэлбэрээр үйлдэх, эсвэл үйлдэл төгсөөгүй буюу энэ гэмт хэрэгт завдсан байх, хүнийг алах санаа зорилгогүй байсан хэдий ч үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хүний амь нас хохирсон зэргээр холбогдогчийн үйлдэл, эс үйлдэхүйд хандсан гэм буруугийн хэлбэр, үйлдэл төгссөн эсэх, бусад гэмт хэргийг үйлдэхдээ хүний амь насыг хохироосон эсэхийг харгалзан ангилсан ангиллууд байгаа тул нэр томъёо нь үүнийгээ дагаад англи хэлнээ ч өөр өөрөөр нэршиж, хэрэглэгджээ.

01 дүгээр ангиллыг бүхэлд нь судлаад, түүний агуулгыг цогц хэлбэрээр дүгнэн хэлбэл “Хүний амь нас хохироосон болон хохироохыг завдсан” гэмт хэрэг, үүн дотроо санаатайгаар хохироох, санаатай хохироох гэмт хэрэгт завдах, болгоомжгүйгээр хохироох, хүнийг амиа хорлоход туслах, хүргэх, хууль бусаар үр хөндөх, амь насыг хохироосон болон хохироохыг завдсан бусад гэмт хэрэг гэсэн нэршилд холбогдох агуулгаар ойлгож, хэрэглэх боломжтой гэж үзэж байна.

ХОЁР. ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИКИЙН ОЛОН УЛСЫН 02 ДУГААР АНГИЛАЛ³⁰

Энэ ангилалд хүний эрүүл мэндийн халдашгүй байдал болон халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй холбоотой гэмт хэргүүд хамаарч байна. Гэмт хэргийн хохирол, үр дагаврын хувьд хүний биед хүнд гэмтэл учруулсан, материаллаг хохирол шаардах гэмт хэрэг байхын зэрэгцээ мөн хүн хулгайлах гэх мэт бодит хохирол үл шаардах хэрэг ч хамаарч байгаагаараа онцлогтой. 02 дугаар ангилал нь 72 задаргаа ангилал (нийт 73 ангилал)-ыг өөртөө багтаасан, бусад ангилалтай харьцуулахад хамгийн их задаргаатай ангилал болно.

Энэхүү ангилалд Монгол Улсын ЭХ-ийн хэд хэдэн бүлэг, тухайлбал Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг, Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг, Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг, Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг тэдгээрт холбогдох зүйл, хэсгүүд хамаарч байх тул ЭХ-ийн олон бүлэг, тэдгээрт хамаарах зүйл, хэсгийг түүвэрлэн багтаасан ГХСОУА дотроо хамгийн том ангилал юм.

2.1. ГХСОУ-ЫН 02 ДУГААР АНГИЛЛЫН АГУУЛГА

МУ-ын ЭХ-д заасан гэмт хэргүүдийг ГХСОУА-ын 02 дугаар ангилалтай дүйцүүлэн үзэхэд гэмт хэргийн улмаас хүний биед хүнд гэмтэл учирсан бодит хохирол шаардах материаллаг

³⁰ ГХСОУ-ын энэхүү ангилалд хамаарах судалгааг судлаач Т.Золбоо, Б.Батбаяр нар боловсруулав.

бүрэлдэхүүнтэй хэргүүд хамаарч байгаа ч мөн бодит хохирол үл шаардах хэлбэрийн бүрэлдэхүүнтэй хүн хулгайлах гэх мэт хэрэг хамаарч байна. Эдгээр гэмт хэрэг нь ЭХ-ийн зөвхөн нэг бүлэг, зүйлд хамаарах бус ЭХ-ийн хэд хэдэн бүлэг, түүний зүйл, хэсэг, заалтад хамаарах тул энэхүү ангилалд багтах нийт хэргийг олж илрүүлэхийн тулд эрүүгийн хуулийг бүхэлд нь судалж үзлээ.

02 дугаар ангиллын агуулгыг ойлгомжтой харуулах үүднээс хүснэгтэд шилжүүлж, жишээ болгон харууллаа (Хүснэгт 6).

Хүснэгт 6. ГХСОУА-ын 02 дугаар ангилал, англи хэлээр³¹

№	Level 1	Level 2	Level 3	Level 4	2019	2020	Comments
1	Acts causing harm or intending to cause harm to the person						
2		Assaults and threats					
3		Acts against liberty					
4		Slavery and exploitation					
5		Trafficking in persons (TIP)					
6		Coercion					
7		Negligence					
8		Dangerous acts					
9		Acts intended to induce fear or emotional distress					
10		Defamation or insult					
11		Discrimination					
12		Acts that trespass against the person					
13		Other acts causing harm or intending to cause harm to the person					
14			Assault				
15			Threat				
16			Other assaults or threats				
17			Abduction of a minor				
18			Deprivation of liberty				

³¹ Маягтад дурдсан нэр томьёо нь ГХСОУА-ын англи хэл дээрх албан ёсны нэр томьёо болно.

Хүснэгт 6-гийн үргэлжлэл

№	Level 1	Level 2	Level 3	Level 4	2019	2020	Comments
19			Other acts against liberty				
20			Slavery				
21			Forced labour				
22			Other acts of slavery and exploitation				
23			TIP for sexual exploitation				
24			TIP for forced labour or services				
25			TIP for organ removal				
26			TIP for other purposes				
27			Extortion or blackmail				
28			Other acts of coercion				
29			Negligence in situations of persons under care				
30			Professional negligence				
31			Negligence related to driving a vehicle				
32			Other acts of negligence				
33			Acts that endanger health				
34			Operating a vehicle under the influence of psychoactive substances				
35			Other dangerous acts				
36			Harassment				
37			Stalking				
38			Other acts intended to induce fear or emotional distress				
39			Defamation or insult due to the victim's characteristics or ascribed attributes				
40			Defamation or insult due to the victim's ascribed beliefs or values				
41			Other defamation or insult				
42			Personal discrimination				
43			Group discrimination				
44			Other discrimination				
45			Invasion of privacy				

Хүснэгт 6-гийн үргэлжлэл

№	Level 1	Level 2	Level 3	Level 4	2019	2020	Comments
46			Other acts that trespass against the person				
47				Serious assault			
48				Minor assault			
49				Serious threat			
50				Minor threat			
51				Parental abduction			
52				Abduction by another family member			
53				Abduction by a legal guardian			
54				Other abduction of a minor			
55				Kidnapping			
56				Illegal restraint			
57				Hijacking			
58				Other deprivation of liberty			
59				Illegal adoption			
60				Forced marriage			
61				Other acts against liberty			
62				Forced labour for domestic services			
63				Forced labour for industrial services			
64				Forced labour for the State or armed forces			
65				Other forced labour			
66				Negligence in situations of children under care			
67				Negligence in situations of other dependent persons under care			

Хүснэгт 6-ийн үргэлжлэл

№	Level 1	Level 2	Level 3	Level 4	2019	2020	Comments
68				Other negligence in situations of persons under care			
69				Operating a vehicle under the influence of alcohol			
70				Operating a vehicle under the influence of illicit drugs			
71				Operating a vehicle under the influence of other psychoactive substances			
72				Harassment in the workplace			
73				Other harassment			

Хүснэгт 7. ГХСОУА-ын 02 дугаар ангилал, монгол хэлээр³²

№	1-р түвшний үзүүлэлт	2-р түвшний үзүүлэлт	3-р түвшний үзүүлэлт	4-р түвшний үзүүлэлт	2019	2020	Тайлбар
1	Хувь хүнд, хохирол, гэмтэл учруулсан, учруулахыг завдсан хэрэг						
2		Танхай болон заналхийлэх					
3		Эрх чөлөөний эсрэг					
4		Боолчлол ба мөлжлөг					
5		Хүн худалдаалах гэмт хэрэг					
6		Албадлага					
7		Анхаарал, хайхрамжгүй байдал					
8		Аюултай үйлдэл					
9		Айдас, сэтгэл зүйн дарамт буй болгох үйлдэл					
10		Нэр төр гутаах, доромжлох					
11		Ялгаварлан гадуурхах					
12		Хүний эсрэг хууль зөрчсөн үйлдэл					

³² Хүснэгтэд дурдсан нэр томьёо нь ГХСОУА-ыг орчуулсан НҮБ-ын гарын авлагад дурдсан нэр томьёо болно.

Хүснэгт 7-гийн үргэлжлэл

№	1-р түвшний үзүүлэлт	2-р түвшний үзүүлэлт	3-р түвшний үзүүлэлт	4-р түвшний үзүүлэлт	2019	2020	Тайлбар
13			Хүнд хохирол учруулсан, хохирол учруулахыг завдсан бусад үйлдэл				
14			Танхай				
15			Сүрдүүлэх, заналхийлэх				
16			Танхай болон заналхийлэх бусад хэлбэр				
17			Насанд хүрээгүй хүүхдийг хулгайлах				
18			Эрх чөлөөг нь хасах				
19			Эрх чөлөөний эсрэг бусад гэмт хэрэг				
20			Боолчлол				
21			Албадан хөдөлмөр				
22			Боолчлол ба мөлжлөгийн бусад хэлбэр				
23			Бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах				
24			Үйлчилгээний зорилгоор албадан хөдөлмөр эрхлүүлэх, хүн худалдаалах				
25			Эрхтэн шилжүүлэх зорилгоор хүн худалдаалах				
26			Өөр бусад зорилгоор хүн худалдаалах				
27			Дарамтлах эсвэл айлган сүрдүүлэх				
28			Албадлагын бусад хэлбэр				
29			Асрамжид байгаа хүнд хайхрамжгүй хандах				
30			Албан ажилдаа хайнга хандах				
31			Тээврийн хэрэгслийг хайхрамжгүй жолоодох				
32			Бусад анхаарал, хайхрамжгүй үйлдэл				
33			Эрүүл мэндэд аюултай үйлдэл				
34			Сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон үйлдэл				
35			Бусад аюултай үйлдэл				
36			Дарамт				
37			Мөрдөн мөшгөх				
38			Сэтгэл санааны зовлон, айдаст хүргэх бусад үйлдэл				

Хүснэгт 7-гийн үргэлжлэл

№	1-р түвшний үзүүлэлт	2-р түвшний үзүүлэлт	3-р түвшний үзүүлэлт	4-р түвшний үзүүлэлт	2019	2020	Тайлбар
39			Хохирогчийн шинж чанараас хамаарч нэр төрийг нь гутаах, доромжлох				
40			Хохирогчийн итгэл үнэмшил, үнэт зүйлсийг нь гутаан доромжлох				
41			Нэр төр гутаах, доромжлох бусад хэлбэр				
42			Хувь хүнийг ялгаварлан гадуурхах				
43			Хэсэг бүлгээр ялгаварлан гадуурхах				
44			Бусад хэлбэрээр ялгаварлан гадуурхах				
45			Хувийн нууцад халдах				
46			Хувь хүний эсрэг хууль, зөрчсөн бусад үйлдэл				
47				Ноцтой танхайн хэрэг			
48				Танхайн хөнгөн хэлбэр			
49				Ноцтой заналхийлэх			
50				Хөнгөн хэлбэрээр заналхийлэх			
51				Өөрт нь хүүхдээ асран хамгаалах, халамжлах эрх олгогдоогүй байхад эцэг, эх нь хүүхдээ хулгайлах			
52				Гэр бүлийн өөр гишүүндээ хулгайлуулах			
53				Хууль ёсны асран хамгаалагчдаа хулгайлуулах			
54				Насанд хүрээгүй хүүхдийг хулгайлах, өөр бусад хэлбэр			
55				Хүн хулгайлах			
56				Хууль бусаар хорих			
57				Тээврийн хэрэгслийг зорчигчдын хамт хууль бусаар эрхшээл, хяналтдаа оруулах үйлдэл			

Хүснэгт 7-гийн үргэлжлэл

№	1-р түвшний үзүүлэлт	2-р түвшний үзүүлэлт	3-р түвшний үзүүлэлт	4-р түвшний үзүүлэлт	2019	2020	Тайлбар
58				Эрх чөлөөг хасах бусад үйлдэл			
59				Хууль бус үрчлэлт			
60				Хүчээр гэрлүүлэх			
61				Эрх чөлөөний эсрэг бусад хэрэг			
62				Гэрийн үйлчилгээний албадан хөдөлмөр			
63				Үйлдвэр, үйлчилгээний албадан хөдөлмөр			
64				Төр болон зэвсэгт хүчний албадан хөдөлмөр			
65				Албадан хөдөлмөрийн бусад хэлбэр			
66				Асрамжид байгаа хүүхдэд хайхрамжгүй хандах			
67				Асрамжид байгаа бусад хүмүүст хайхрамжгүй хандах			
68				Асрамжид байгаа этгээддээ бусад нөхцөл байдалд хайхрамжгүй хандах			
69				Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ жолоо барих			
70				Мансууруулах бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох			
71				Сэтгэцэд нөлөөлөх бусад бодис хэрэглэсэн үедээ жолоо барих			
72				Ажлын байрны дарамт			
73				Бусад дарамт			

02 дугаар ангилал нь дотроо 2-р түвшний ангилал 12, 3-р түвшний ангилал 33, 4-р түвшний ангилал 27-г тус тус багтаасан. Эндээс харахад ГХСОУА-ын 02 дугаар ангилал нь 01, 03 дугаар ангилалтай харьцуулахад 3, 4-р түвшний ангилал буюу хамгийн бага нэгж (3, 4-р түвшин) дэх задаргаа ангиллын тоогоор харьцангуй илүү байна. Энэ нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдал, хүний халдашгүй, чөлөөтэй байх эрх хийгээд гэмт хэргийн хохирол, үр дагаврын хувьд хүний биед хүнд гэмтэл учруулсан материаллаг хохирол шаардах гэмт хэрэг, түүнчлэн бодит хохирол үл шаардах гэмт хэрэг зэрэг өргөн хүрээг хамарсны зэрэгцээ олон улсын түвшинд энэ ангиллын дагуу нэгж мэдээллийн агуулгыг илүү нарийвчлалтай гаргах шаардлагыг чухалчилж үздэгтэй холбоотой.

2.2. ГХСОУА БА ЭХ ДАХЬ ГЭМТ ХЭРГИЙГ ДҮЙЦҮҮЛСЭН ХУВИЛБАР, ТҮҮНИЙГ НӨХӨХ АСУУДАЛ

Дүйцүүлэх хувилбарыг боловсруулах явцад зарим ангилал нь ЭХ-ийн тодорхой төрлийн гэмт хэргийн агуулгатай бүрэн дүйцэж байгаа бол зарим нь тодорхой төрлийн гэмт хэргийн зүйл, хэсэг, заалтаас аль нэг үйлдэл, эсвэл үр дагаварт хамаарах шинжээрээ дүйцэж байна. Мөн нөхөгдөх боломжгүй ангиллууд ч бий. ГХСОУА-ын 02 дугаар ангилалд ЭХ дахь гэмт хэргийг дүйцүүлсэн хувилбарыг доорх хүснэгтэд жагсаалаа.

Хүснэгт 8. ГХСОУА-ын 02 дугаар ангилалд ЭХ дахь гэмт хэргийг дүйцүүлсэн хувилбар

ГХСОУА-ын дугаар	ЭХ-ийн бүлэг, зүйл, хэсгийн дугаар	Гэмт хэргийн нэр (үйлдэл эсвэл үр дагаврын шинжийг харуулах тухайн зүйл, хэсэг, заалтын агуулга)
02	11 дүгээр бүлэг: 11.1.1, 11.2.1, 11.3.1, 11.4.1, 11.5.1, 11.6.1, 11.7.1, 13 дугаар бүлэг: 13.1.1, 13.2.1, 13.4.1, 13.4.2, 13.4.4.2, 13.5.1, 13.8.1, 13.9.1, 13.10.1, 13.10.2.1, 13.11.1, 13.12.1, 13.13.1, 13.14.1, 14 дүгээр бүлэг: 14.1.1, 14.8.1, 15 дугаар бүлэг: 15.1.1, 15.2.1, 15.6.1, 16 дугаар бүлэг: 16.2.2, 16.10.1, 16.11.1, 17 дугаар бүлэг: 17.2.1, 19 дүгээр бүлэг: 19.9.1, 23 дугаар бүлэг: 23.5.1, 26 дугаар бүлэг: 26.1.1, 27 дугаар бүлэг: 27.8.2.3, 27.9.1, 27.10.1, 27.10.2.1, 27.10.2.3, 27.10.4.1, 27.11.1, 29 дүгээр бүлэг: 29.5.1,	11.1 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах 11.2 дугаар зүйл. Санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах 11.3 дугаар зүйл. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол болгоомжгүйгээр учруулах 11.4 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах 11.5 дугаар зүйл. Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол болгоомжгүйгээр учруулах 11.6 дугаар зүйл. Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах 11.7 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 13.1 дүгээр зүйл. Хүн худалдаалах 13.2 дугаар зүйл. Хүн хулгайлах 13.4 дүгээр зүйл. Хүнийг хүчээр алга болгох 13.5 дугаар зүйл. Заналхийлэх 13.8 дугаар зүйл. Зөвшөөрөлгүй гэрэл зураг авах, дуу, дүрс бичлэг хийж дамжуулах, тараах 13.9 дүгээр зүйл. Хууль бусаар баривчлах, саатуулах 13.10 дугаар зүйл. Хувь хүний нууцад халдах 13.11 дүгээр зүйл. Хувь хүний нууцыг задруулах 13.12 дугаар зүйл. Хууль бусаар мөрдөж мөшгөх 13.13 дугаар зүйл. Албадан хөдөлмөрлүүлэх 13.14 дүгээр зүйл. Худал мэдээлэл тараах 14.1 дүгээр зүйл. Ялгаварлан гадуурхах 14.8 дугаар зүйл. Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах 15.1 дүгээр зүйл. Эмнэлгийн тусламж үзүүлэхгүй байх 15.2 дугаар зүйл. Аюултай байдалд орхих, тусламж үзүүлэхгүй байх 15.6 дугаар зүйл. Бусдын амь насанд аюул учруулж болзошгүй халдварт өвчин, дархлал хомсдолын вирус халдаах 16.2 дугаар зүйл. Хүүхдийг согтуурах, мансуурах, донтох байдалд татан оруулах 16.10 дугаар зүйл. Хүүхдээр гэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх 16.11 дүгээр зүйл. Хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх 17.2 дугаар зүйл. Дээрэмдэх

Хүснэгт 8-ын үргэлжлэл

ГХСОУА-ын дугаар	ЭХ-ийн бүлэг, зүйл, хэсгийн дугаар	Гэмт хэргийн нэр (үйлдэл эсвэл үр дагаврын шинжийг харуулах тухайн зүйл, хэсэг, заалтын агуулга)
		<p>19.9 дүгээр зүйл. Үндэсний эв нэгдлийг бусниулах</p> <p>23.5 дугаар зүйл. Хайнга хандах</p> <p>26.1 дүгээр зүйл. Цахим мэдээлэлд хууль бусаар халдах</p> <p>27.8 дугаар зүйл. Агаарын хөлгийг авч зугтаах</p> <p>27.9 дүгээр зүйл. Замын байгууламжийн ашиглалт, засварын аюулгүй байдлын журам зөрчих</p> <p>27.10 дугаар зүйл. Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих</p> <p>27.11 дүгээр зүйл. Авто тээврийн гэмт хэрэг үйлдсэн жолооч зугтаах</p> <p>29.5 дугаар зүйл. Төрлөөр устгах</p>
0201	ЭХ-д уг ангилалд хамаарах гэмт хэрэг алга байна.	<p>Уг ангиллын агуулгаас харахад танхайрах болон заналхийлэх явцдаа хүний биед гэмтэл, хохирол учруулах гэмт хэргүүд хамаарахаар байна.</p> <p>ЭХ-ийн 11.1.2.1-д онц харгис, хэрцгий аргаар хүний биед гэмтэл учруулж болохоор заасан. Гэвч энэ нь танхайрах болон заналхийлэх үйлдлээс нийгмийн хор аюулын хувьд өндөр учир уг гэмт хэрэгт хамаарахгүй юм.</p> <p>ЭХ-ийн 13.5, 15.3, 17.6 гэх мэт гэмт хэрэг заналхийлэх гэх ухагдахууныг хуульчилсан байдаг ч энэ нь тусдаа гэмт хэргийн шинж бус, харин тухайн гэмт хэргийг үйлдэх аргыг илэрхийлж байдаг. Иймд уг ангилалд оруулах боломжгүй.</p>
02011	<p>11 дүгээр бүлэг: 11.1.1, 11.2.1, 11.3.1, 11.4.1, 11.5.1, 11.6.1, 11.7.1</p> <p>13 дугаар бүлэг: 13.4.4.2</p> <p>16 дугаар бүлэг: 16.2.2</p> <p>29 дүгээр бүлэг: 29.5.1</p>	<p>Тус ангиллын тайлбарт санаатай болон болгоомжгүй хүч хэрэглэсэн үйлдлээр хүний бие махбодод гэмтэл учруулсан үйлдэл хамаарна хэмээн тайлбарласан байсан учир 11 дүгээр бүлгийн доорх гэмт хэргүүдийг уг ангилалд дүйцүүлэн хамааруулав.</p> <p>11.1 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах (11.1.1. бүрэн хэмжээнд)</p> <p>11.2 дугаар зүйл. Санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах (11.2.1. бүрэн хэмжээнд)</p> <p>11.3 дугаар зүйл. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол болгоомжгүйгээр учруулах (11.3.1. бүрэн хэмжээнд)</p> <p>11.4 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах (11.4.1. бүрэн хэмжээнд)</p> <p>11.5 дугаар зүйл. Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол болгоомжгүйгээр учруулах (11.5.1. бүрэн хэмжээнд)</p>

Хүснэгт 8-ын үргэлжлэл

ГХСОУА-ын дугаар	ЭХ-ийн бүлэг, зүйл, хэсгийн дугаар	Гэмт хэргийн нэр (үйлдэл эсвэл үр дагаврын шинжийг харуулах тухайн зүйл, хэсэг, заалтын агуулга)
		<p>11.6 дугаар зүйл. Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах (11.6.1. бүрэн хэмжээнд)</p> <p>11.7 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх (11.7.1. бүрэн хэмжээнд)</p> <p>13.4 дүгээр зүйл. Хүнийг хүчээр алга болгох (13.4.4.2. зарим хэсгээр)</p> <p>16.2 дугаар зүйл. Хүүхдийг согтуурах, мансуурах, донтох байдалд татан оруулах (16.2.2. зарим хэсгээр)</p> <p>29.5 дугаар зүйл. Төрлөөр устгах (29.5.1. зарим хэсгээр)</p> <p>Харин 13 дугаар бүлэгт заасан 13.4.4.2, 16 дугаар бүлэгт заасан 16.2.2, 29 дүгээр бүлэгт заасан 29.5.1-д хүч хэрэглэсэн гэсэн нөхцөл байхгүй хэдий ч тухайн гэмт хэрэг нь хүч хэрэглэх аргаар мөн явагдаж болох учир уг ангилалд дүйцүүлж болохоор байна.</p>
020111	<p>11 дүгээр бүлэг: 11.1.1, 11.2.1, 11.3.1, 11.4.1, 11.5.1.</p> <p>13 дугаар бүлэг: 13.4.4.2</p> <p>16 дугаар бүлэг: 16.2.2</p> <p>27 дугаар бүлэг: 27.8.2.3</p> <p>29 дүгээр бүлэг: 29.5.1</p>	<p>Тус ангиллыг тайлбарласан тайлбарт хүнд хохирол учирсан үйлдлийг шаардаж байсан учир</p> <p>11.1 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах (11.1.1. бүрэн хэмжээнд)</p> <p>11.4 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах (11.4.1. бүрэн хэмжээнд)</p> <p>13.4 дүгээр зүйл. Хүнийг хүчээр алга болгох (13.4.4.2. бүрэн хэмжээнд) хэргүүд уг ангилалтай бүрэн хэмжээгээр,</p> <p>11.2 дугаар зүйл. Санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах (11.2.1. зарим хэсгээр),</p> <p>16.2 дугаар зүйл. Хүүхдийг согтуурах, мансуурах, донтох байдалд татан оруулах (16.2.2. зарим хэсгээр)</p> <p>27.8 дугаар зүйл. Агаарын хөлгийг авч зугтаах (27.8.2.3 зарим хэсгээр)</p> <p>29.5 дугаар зүйл. Төрлөөр устгах (29.5.1. зарим хэсгээр) хэргүүдийг үйлдэл үр дагаврын шинжээр нь дүйцүүлэн хамааруулж болохоор байна.</p> <p>11.2.1, 16.2.2, 27.8.2.3, 29.5.1-д заасан хэргүүдийн заалтад хүч хэрэглэх гэсэн нөхцөл онцгойлон байхгүй хэдий ч эдгээр хэрэг нь хүч хэрэглэсэн үйлдлээр үйлдэгдэн хүнд, хүндэвтэр хохирлыг хохирогчид учруулах боломжтой.</p>

Хүснэгт 8-ын үргэлжлэл

ГХСОУА-ын дугаар	ЭХ-ийн бүлэг, зүйл, хэсгийн дугаар	Гэмт хэргийн нэр (үйлдэл эсвэл үр дагаврын шинжийг харуулах тухайн зүйл, хэсэг, заалтын агуулга)
020112	11 дүгээр бүлэг: 11.6.1, 11.7.1	<p>11.6 дугаар зүйл. Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах (11.6.1. бүрэн хэмжээнд)</p> <p>11.7 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх (11.7.1. зарим хэсгээр)</p> <p>11.6-д заасан гэмт хэргийг уг ангилалд бүрэн хэмжээгээр, 11.7.1-д заасан гэмт хэргийг зарим хэсгээр дүйцүүлэн хамааруулж болохоор байна. 11.7.1-д заасан “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэрэг нь өөртөө хөнгөн гэмтэл учруулах болон гэмтэл учраагүй байх үр дагаврыг агуулдаг. ЭХ-д хөнгөн довтолгоогоор үйлдэгдэх явцдаа хөнгөн гэмтэл болон гэмтэл учруулахаар хуульчлагдсан хэргүүд байдаг хэдий ч тэдгээр нь хөнгөн гэмтэл учруулсан тохиолдолд хөнгөн гэмтэлтэй давхар зүйлчлэгдэх ба гэмтэл учруулаагүй бол тухайн хэргийн арга болж дангаар зүйлчлэгдэх учир уг ангилалд бус, бусад холбогдох ангилалд хамаарах юм.</p>
02012	13 дугаар бүлэг: 13.5.1	<p>13.5 дугаар зүйл. Заналхийлэх (13.5.1. зарим хэсгээр)</p> <p>МУ-ын ЭХ-д Заналхийлэх явцдаа хүний биед хохирол, гэмтэл учруулахаар тодорхой хуульчилсан гэмт хэрэг байхгүй. Харин 13.5.1-д өөрт нь, түүний ойр дотнын хүнд хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн гэсэн нөхцөл байх ба үүнд биед нь хохирол, гэмтэл учруулахаас эхлээд бүх хэлбэрийн заналхийлэл багтах учир уг зүйл ангийг дүйцүүлэх боломжтой. Мөн ЭХ-д заналхийлэх замаар үйлдэж болох тодорхой гэмт хэргүүд байх хэдий ч үүнээс хүний биед хохирол учруулахаар заналхийлэх гэмт хэрэг байхгүй бөгөөд хүчиндэх гэх мэт өөр үр дагаварт чиглэсэн байна.</p>
020121	13 дугаар бүлэг: 13.5.1	<p>13.5 дугаар зүйл. Заналхийлэх (13.5.1. зарим хэсгээр)</p> <p>МУ-ын ЭХ-д хүний биед хохирол, гэмтэл учруулахаар тодорхой хуульчилсан гэмт хэрэг байхгүй. Харин 13.5.1-д өөрт нь, түүний ойр дотнын хүнд хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн гэсэн нөхцөл байх ба үүнд биед нь хохирол, гэмтэл учруулахаас эхлээд бүх хэлбэрийн заналхийлэл багтах учир уг зүйл ангийг дүйцүүлэх боломжтой. Мөн ЭХ-д заналхийлэх замаар үйлдэж болох тодорхой гэмт хэргүүд байх хэдий ч үүнээс хүний биед хохирол учруулахаар заналхийлэх гэмт хэрэг байхгүй бөгөөд хүчиндэх гэх мэт өөр үр дагаварт чиглэсэн байна.</p>

Хүснэгт 8-ын үргэлжлэл

ГХСОУА-ын дугаар	ЭХ-ийн бүлэг, зүйл, хэсгийн дугаар	Гэмт хэргийн нэр (үйлдэл эсвэл үр дагаврын шинжийг харуулах тухайн зүйл, хэсэг, заалтын агуулга)
020122	13 дугаар бүлэг: 13.5.1	13.5 дугаар зүйл. Заналхийлэх (13.5.1. зарим хэсгээр) МУ-ын ЭХ-д ялимгүй байдлаар заналхийлэх хэмээн заналхийлэх хэргийг хэлбэрээр нь нарийвчлан хуульчилсан гэмт хэрэг байхгүй. Харин 13.5.1-д өөрт нь, түүний ойр дотнын хүнд хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн гэсэн ерөнхий нөхцөл байх ба ялимгүй заналхийлэх үйлдэл багтах учир уг зүйл ангийг дүйцүүлэх замаар уг ангилалд багтаах боломжтой. Мөн ЭХ-д заналхийлэх замаар үйлдэж болох тодорхой гэмт хэргүүд байх хэдий ч хүчиндэх гэх мэт өөр үр дагаварт чиглэсэн байх учир уг ангилалд хамаарахгүй юм.
02019	-	-
0202	13 дугаар бүлэг: 13.2.1, 13.4.1	13.2 дугаар зүйл. Хүн хулгайлах (13.2.1. бүрэн хэмжээнд) 13.4 дүгээр зүйл. Хүнийг хүчээр алга болгох (13.4.1. бүрэн хэмжээнд) Хүний шилжилт хөдөлгөөнийг түүний хүсэл зоригоос гадуур хязгаарласан үйлдэл ЭХ-ийн 13.2.1, 13.4.1-д байх бөгөөд эдгээрийг уг ангилалд бүрэн хэмжээгээр дүйцүүлж болно. МУ-ын ЭХ-д хүний шилжилт хөдөлгөөнийг түүний хүсэл зоригоос гадуур хязгаарласан үйлдэл дээрх хоёр зүйл ангиас гадна өөр зүйл ангид бий. Гэхдээ тэдгээр нь тусдаа бие даасан гэмт хэрэг биш, харин өөр гэмт хэргийг үйлдэх арга учир энэ ангилалд хамаарахгүй юм. (Тухайлбал, хүн худалдаалах зорилгоор хүнийг хулгайлах)
02021	13 дугаар бүлэг: 13.2.1	13.2 дугаар зүйл. Хүн хулгайлах (13.2.1. зарим хэсгээр) МУ-ын ЭХ-д хулгайлж байгаа хүнийх нь насны онцлогоос хамаарч хүүхэд болон насанд хүрсэн хүнийг хулгайлах хэмээн нарийвчлан хуульчилсан зүйл анги байхгүй бөгөөд ерөнхийдөө 13.2.1-д хүн хулгайлах хэмээн зааж бүх насны хүнийг хамаарахаар хуульчилсан тул уг ангилалд 13.2.1-ийг зарим хэсгээр дүйцүүлэн хамааруулах боломжтой.
020211	-	-
020212	-	-
020213	-	-
020219	-	-
02022	13 дугаар бүлэг: 13.2.1, 13.4.1, 13.9.1	13.2 дугаар зүйл. Хүн хулгайлах (13.2.1. бүрэн хэмжээнд) 13.4 дүгээр зүйл. Хүнийг хүчээр алга болгох (13.4.1. бүрэн хэмжээнд) 13.9 дүгээр зүйл. Хууль бусаар баривчлах, саатуулах (13.9.1. бүрэн хэмжээнд)

Хүснэгт 8-ын үргэлжлэл

ГХСОУА-ын дугаар	ЭХ-ийн бүлэг, зүйл, хэсгийн дугаар	Гэмт хэргийн нэр (үйлдэл эсвэл үр дагаврын шинжийг харуулах тухайн зүйл, хэсэг, заалтын агуулга)
020221	13 дугаар бүлэг: 13.2.1	13.2 дугаар зүйл. Хүн хулгайлах (13.2.1. зарим хэсгээр) ЭХ-ийн 13.2.1-д заасан Хүн хулгайлах гэмт хэрэг нь хүнийг эрхшээлдээ оруулах буюу хулгайлах үйлдлээр гүйцэтгэгддэг учир энэ ангилалд зарим хэсгээр дүйцүүлэн хамааруулж болно. Учир нь ЭХ-д заасан хүн хулгайлах гэмт хэрэг нь уг ангилалд заасан тодорхой ашиг бий болгох, үйлдэл хийлгэх эсвэл үйлдэл хийлгэхгүй байх зорилгыг агуулдаггүй.
020222	13 дугаар бүлэг: 13.4.1	13.4 дүгээр зүйл. Хүнийг хүчээр алга болгох (13.4.1. бүрэн хэмжээнд) ЭХ-ийн 13.4.1-д заасан Хүнийг хүчээр алга болгох хэрэг нь хүнийг хууль бусаар хорих агуулгатай байдаг учир уг ангилалд бүрэн хэмжээгээр дүйцүүлж хамааруулна.
020223	17 дугаар бүлэг: 17.2.1	17.2 дугаар зүйл. Дээрэмдэх (17.2.1. зарим хэсгээр) ЭХ-д тээврийн хэрэгслийг дээрэмдэх гэсэн нарийвчилсан зүйл анги байхгүй. Харин 17.2.1-д Дээрэм гэсэн зүйл анги бий бөгөөд үүнд нийт эд хөрөнгө тэр дундаа тээврийн хэрэгсэл хамаарах учир уг ангилалд зарим хэсгээр дүйцүүлэн хамааруулах боломжтой
020229	13 дугаар бүлэг: 13.9.1	13.9 дүгээр зүйл. Хууль бусаар баривчлах, саатуулах (13.9.1 бүрэн хэмжээнд) ГХСОУА-д Эрх бүхий албан тушаалтан хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж баривчилсан үйлдлийг тусгайлан заагаагүй. Харин Эрүүгийн хуулийн 13.9.1-д уг үйлдлийг хуульчилсан ба энэ нь 2 эрх чөлөөг хасах бусад үйлдэлд хамаарахаар байна.
02029	-	-
020291	-	-
020292	-	-
020299	-	-
0203	13 дугаар бүлэг: 13.13.1 16 дугаар бүлэг: 16.10.1	13.13 дугаар зүйл. Албадан хөдөлмөрлүүлэх (13.13.1 бүрэн хэмжээнд) 16.10 дугаар зүйл. Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх (16.10.1 зарим хэсгээр) Уг ангилалд ЭХ-ийн 13.13.1-д заасан гэмт хэрэг бүрэн хэмжээгээр дүйцэх бол 16.10.1-д заасан хэргийг зарим хэсгээр дүйцүүлэх боломжтой. Дүйцүүлэх учир нь 16.10.1-д заасан хэргийн хохирогч нь хүүхэд байх бөгөөд өөрөө хөдөлмөр эрхлэхийг зөвшөөрсөн байж болдог.
02031	-	-
02032	13 дугаар бүлэг: 13.13.1	13.13 дугаар зүйл. Албадан хөдөлмөрлүүлэх (13.13.1 бүрэн хэмжээнд) ЭХ-ийн 13.13.1-д заасан хэргийн нөхцөл нь уг ангиллын агуулгатай таарч байх тул бүрэн хэмжээгээр дүйцүүлэн хамааруулна.

Хүснэгт 8-ын үргэлжлэл

ГХСОУА-ын дугаар	ЭХ-ийн бүлэг, зүйл, хэсгийн дугаар	Гэмт хэргийн нэр (үйлдэл эсвэл үр дагаврын шинжийг харуулах тухайн зүйл, хэсэг, заалтын агуулга)
020321	-	-
020322	-	-
020323	-	-
020329	-	-
0204	13 дугаар бүлэг: 13.1.1	13.1 дүгээр зүйл. Хүн худалдаалах (13.1.1. бүрэн хэмжээнд) ЭХ-ийн 13.1.1-д заасан гэмт хэргийг уг ангилалд бүрэн хэмжээгээр дүйцүүлж болно.
02041	13 дугаар бүлэг: 13.1.1	13.1 дүгээр зүйл. Хүн худалдаалах (13.1.1. зарим хэсгээр) ЭХ-д хүн худалдаалах гэмт хэргийг зорилго тус бүрээр нь нарийвчилж бие даасан гэмт хэрэг болгон хуульчлаагүй, нийтэд нь 13.1-д хуульчилсан. ЭХ-ийн 13.1.1-д “бэлгийн мөлжлөгт” оруулах зорилгоор гэсэн нөхцөл байх тул энэ нөхцөлөөр нь зарим хэсгээр дүйцүүлэн уг ангилалд хамааруулах боломжтой.
02042	13 дугаар бүлэг: 13.1.1	13.1 дүгээр зүйл. Хүн худалдаалах (13.1.1. зарим хэсгээр) ЭХ-д хүн худалдаалах гэмт хэргийг зорилго тус бүрээр нь нарийвчилж бие даасан гэмт хэрэг болгон хуульчлаагүй, нийтэд нь 13.1-д хуульчилсан. ЭХ-ийн 13.1.1-д “албадан хөдөлмөрлүүлэх” зорилгоор гэсэн нөхцөл байх ба үүгээр нь зарим хэсгээр дүйцүүлэн уг ангилалд хамааруулах боломжтой.
02043	13 дугаар бүлэг: 13.1.1	13.1 дүгээр зүйл. Хүн худалдаалах (13.1.1. зарим хэсгээр) МУ-ын ЭХ-д хүн худалдаалах гэмт хэргийг зорилго тус бүрээр нь нарийвчлан бие даасан гэмт хэрэг болгон хуульчлаагүй ба нийтэд нь 13.1-д хуульчилсан юм. ЭХ-ийн 13.1.1-д “эд, эрхтнийг авах” зорилгоор гэсэн нөхцөл байх ба үүгээр нь зарим хэсгээр дүйцүүлэн уг ангилалд хамааруулах боломжтой.
02044	13 дугаар бүлэг: 13.1.1	13.1 дүгээр зүйл. Хүн худалдаалах (13.1.1. бүрэн хэмжээнд) МУ-ын ЭХ-д хүн худалдаалах гэмт хэргийг зорилго тус бүрээр нь нарийвчлан бие даасан гэмт хэрэг болгон хуульчлаагүй ба нийтэд нь 13.1-д хуульчилсан. ЭХ-ийн 13.1.1-д “биеийг үнэлүүлэх, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил нөхцөлд байлгах” зорилгыг хуульчилсан ба эдгээр нь уг ангиллын өөр бусад гэсэн ангилалд хамаарна.

Хүснэгт 8-ын үргэлжлэл

ГХСОУА-ын дугаар	ЭХ-ийн бүлэг, зүйл, хэсгийн дугаар	Гэмт хэргийн нэр (үйлдэл эсвэл үр дагаврын шинжийг харуулах тухайн зүйл, хэсэг, заалтын агуулга)
0205	13 дугаар бүлэг: 13.5.1	13.5 дугаар зүйл. Заналхийлэх (13.5.1. зарим хэсгээр) ЭХ-д Албадлага гэсэн гэмт хэрэг байхгүй ч 13.5.1-д “Бусдыг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг шаардаж өөрт нь, түүний ойр дотнын хүнд хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь хохирол учруулж болохуйц баримт, мэдээлэл тараахаар сүрдүүлсэн” гэсэн нөхцөл байдаг учир уг нөхцөлөөр нь дүйцүүлэх боломжтой.
02051	13 дугаар бүлэг: 13.5.1	13.5 дугаар зүйл. Заналхийлэх (13.5.1. зарим хэсгээр) МУ-ын ЭХ-д Албадлага гэсэн гэмт хэрэг байхгүй ч 13.5.1-д “Бусдыг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг шаардаж өөрт нь, түүний ойр дотнын хүнд хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь хохирол учруулж болохуйц баримт, мэдээлэл тараахаар сүрдүүлсэн” гэсэн нөхцөл байдаг учир уг нөхцөлөөр нь дүйцүүлэх боломжтой.
02059	-	-
0206	16 дугаар бүлэг: 16.11.1	16.11 дүгээр зүйл. Хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх (16.11.1. зарим хэсгээр) ЭХ-ийн 16.11.1-д заасан хэргийн гэм буруугийн болгоомжгүй хэлбэрээр үйлдэгдсэн төрлийг дүйцүүлэн уг ангилалд хамааруулж болно.
02061	-	-
020611	-	16.11 дүгээр зүйл. Хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх (16.11.1) МУ-ын ЭХ-ийн 16.11.1-д “Хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх” гэх гэмт хэрэг байх хэдий ч уг хэрэг нь асран хамгаалах үүргээ биелүүлээгүй санаатай үйлдлийн улмаас болгоомжгүй хохирол үүссэн гэм буруугийн холимог хэлбэртэй байдаг. Гэтэл уг ангилал нь болгоомжгүй үйлдлийн улмаас асран хамгаалж буй хүүхдэд хохирол учруулах агуулгатай учир дээрх гэмт хэрэг уг ангилалд хамаарахгүй юм.
020612	-	-
020619	-	-
02062	15 дугаар бүлэг: 15.1.1 23 дугаар бүлэг: 23.5.1	15.1 дүгээр зүйл. Эмнэлгийн тусламж үзүүлэхгүй байх (15.1.1. зарим хэсгээр) 23.5 дугаар зүйл. Хайнга хандах (23.5.1. бүрэн хэмжээнд) Уг ангилалд ЭХ-ийн 23.5.1-д заасан гэмт хэрэг бүрэн хэмжээгээр дүйцэх бол 15.1.1-д заасан гэмт хэргийн “зохих ёсоор биелүүлээгүй” гэсний болгоомжгүй хэлбэрийг зарим хэсгээр дүйцүүлэн хамааруулах боломжтой.

Хүснэгт 8-ын үргэлжлэл

ГХСОУА-ын дугаар	ЭХ-ийн бүлэг, зүйл, хэсгийн дугаар	Гэмт хэргийн нэр (үйлдэл эсвэл үр дагаврын шинжийг харуулах тухайн зүйл, хэсэг, заалтын агуулга)
02063	27 дугаар бүлэг: 27.10.1, 27.10.2.3, 27.11.1	27.10 дугаар зүйл. Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих (27.10.1, 27.10.2.3. бүрэн хэмжээнд) 27.11 дүгээр зүйл. Авто тээврийн гэмт хэрэг үйлдсэн жолооч зугтаах (27.11.1. бүрэн хэмжээнд) ЭХ-ийн 27.10.1, 27.10.2.3, 27.11.1-ийг уг ангилалд бүрэн хэмжээгээр дүйцүүлэн хамааруулна.
02069	15 дугаар бүлэг: 15.2.1 27 дугаар бүлэг: 27.9.1	15.2 дугаар зүйл. Аюултай байдалд орхих, тусламж үзүүлэхгүй байх (15.2.1. бүрэн хэмжээнд) 27.9 дүгээр зүйл. Замын байгууламжийн ашиглалт, засварын аюулгүй байдлын журам зөрчих (27.9.1. бүрэн хэмжээнд) ЭХ-д 15.2.1 болон 27.9.1-д заасан хэргүүд уг ангилалд бүрэн хэмжээгээр дүйцэхээр байна.
0207	11 дүгээр бүлэг: 11.1.1, 11.4.1, 11.6.1 15 дугаар бүлэг: 15.6.1 27 дугаар бүлэг: 27.10.2.1, 27.10.4.1	11.1 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах (11.1.1. зарим хэсгээр) 11.4 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах (11.4.1. зарим хэсгээр) 11.6 дугаар зүйл. Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах (11.6.1. зарим хэсгээр) 15.6 дугаар зүйл. Бусдын амь насанд аюул учруулж болзошгүй халдварт өвчин, дархлал хомсдолын вирус халдаах (15.6.1. бүрэн хэмжээнд) 27.10 дугаар зүйл. Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих (27.10.2.1, 27.10.4.1. бүрэн хэмжээнд) ЭХ-ийн 15.6.1, 27.10.2.1, 27.10.4.1-д заасан хэргүүд уг ангилалд бүрэн хэмжээгээр дүйцэх бол 11.1.1, 11.4.1, 11.6.1 хэргүүдийг зарим хэсгээр дүйцүүлж болохоор байна.

Хүснэгт 8-ын үргэлжлэл

ГХСОУА-ын дугаар	ЭХ-ийн бүлэг, зүйл, хэсгийн дугаар	Гэмт хэргийн нэр (үйлдэл эсвэл үр дагаврын шинжийг харуулах тухайн зүйл, хэсэг, заалтын агуулга)
02071	11 дүгээр бүлэг: 11.1.1, 11.4.1, 11.6.1 15 дугаар бүлэг: 15.6.1	11.1 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах (11.1.1. зарим хэсгээр) 11.4 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах (11.4.1. зарим хэсгээр) 11.6 дугаар зүйл. Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах (11.6.1. зарим хэсгээр) 15.6 дугаар зүйл. Бусдын амь насанд аюул учруулж болзошгүй халдварт өвчин, дархлал хомсдолын вирус халдаах (15.6.1. бүрэн хэмжээнд) ЭХ-ийн 15.6.1-д заасан гэмт хэрэг уг ангилалд бүрэн хэмжээгээр дүйцэх бол 11.1.1, 11.4.1, 11.6.1-д заасан хэргүүдийг зарим хэсгээр дүйцүүлж болно. Дүйцүүлэх үндэслэл нь 11.1.1, 11.4.1, 11.6.1-д заасан гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд зөвхөн “зэвсэг болон зэвсгийн чанартай зүйл” ашигласан тохиолдлыг хуульчилсан юм. Харин аюултай аргаар гэмтэл, хохирол учруулсан үйлдлийг онцгойлон хуульчлаагүй тул ердийн бүрэлдэхүүндээ орно.
02072	27 дугаар бүлэг. 27.10.2.1, 27.10.4.1	27.10 дугаар зүйл. Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих (27.10.2.1, 27.10.4.1. зарим хэсгээр) ЭХ-ийн 27.10.2.1, 27.10.4.1-д заасан гэмт хэргийн “мансуурсан” гэсэн нөхцөлийг уг ангилалд зарим хэсгээр дүйцүүлэн хамааруулж болно.
020721	27 дугаар бүлэг. 27.10.2.1, 27.10.4.1	27.10 дугаар зүйл. Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих (27.10.2.1, 27.10.4.1. бүрэн хэмжээнд) ЭХ-ийн 27.10.2.1, 27.10.4.1-д заасан гэмт хэргийн “согтуурсан” гэсэн нөхцөлийг уг ангилалд бүрэн хэмжээгээр дүйцүүлэн хамааруулна.
020722	27 дугаар бүлэг: 27.10.2.1, 27.10.4.1	27.10 дугаар зүйл. Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих (27.10.2.1, 27.10.4.1. зарим хэсгээр) ЭХ-ийн 27.10.2.1, 27.10.4.1-д заасан гэмт хэргийн “мансуурсан” гэсэн нөхцөлийг уг ангилалд зарим хэсгээр дүйцүүлэн хамааруулж болно.
020729	-	-
02079	-	-
0208	13 дугаар бүлэг: 13.14.1	13.14 дүгээр зүйл. Худал мэдээлэл тараах (13.14.1. зарим хэсгээр) ЭХ-ийн 13.14.1-д заасан хэргийн “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан” гэсэн шинжээр нь уг ангилалд дүйцүүлэх боломжтой.

Хүснэгт 8-ын үргэлжлэл

ГХСОУА-ын дугаар	ЭХ-ийн бүлэг, зүйл, хэсгийн дугаар	Гэмт хэргийн нэр (үйлдэл эсвэл үр дагаврын шинжийг харуулах тухайн зүйл, хэсэг, заалтын агуулга)
02081	13 дугаар бүлэг: 13.14.1	13.14 дүгээр зүйл. Худал мэдээлэл тараах (13.14.1. зарим хэсгээр) ЭХ-ийн 13.14.1-д заасан хэргийн “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан” гэсэн шинжээр нь уг ангилалд дүйцүүлэх боломжтой.
020811	-	-
020819	-	-
02082	13 дугаар бүлэг: 13.12.1	13.12 дугаар зүйл. Хууль бусаар мөрдөж мөшгөх (13.12.1. бүрэн хэмжээнд) ЭХ-ийн 13.12.1-д заасан хэрэг уг ангилалд бүрэн хэмжээгээр дүйцнэ.
02089	-	-
0209	14 дүгээр бүлэг: 14.1.1, 14.8.1 19 дүгээр бүлэг: 19.9.1	14.1 дүгээр зүйл. Ялгаварлан гадуурхах (14.1.1. бүрэн хэмжээнд) 14.8 дугаар зүйл. Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах (14.8.1. бүрэн хэмжээнд) 19.9 дүгээр зүйл. Үндэсний эв нэгдлийг бусниулах (19.9.1. бүрэн хэмжээнд) ЭХ-д заасан 14.1.1, 14.8.1, 19.9.1-д заасан хэргүүд уг ангилалд хамаарна
02091	-	-
02092	14 дүгээр бүлэг: 14.8.1	14.8 дугаар зүйл. Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах (14.8.1. зарим хэсгээр) ЭХ-ийн 14.8.1 “Сонгуульд оролцогч улс төрийн нам, намуудын эвсэл, нэр дэвшигчийн нэр хүндэд халдаж, илт худал мэдээлэл тараасан” гэсэн онцлог шинжээр нь уг ангилалд хамааруулна.
02099	-	-
0210	14 дүгээр бүлэг: 14.1.1 19 дүгээр бүлэг: 19.9.1	14.1 дүгээр зүйл. Ялгаварлан гадуурхах (14.1.1. бүрэн хэмжээнд) 19.9 дүгээр зүйл. Үндэсний эв нэгдлийг бусниулах (19.9.1. бүрэн хэмжээнд) ЭХ-ийн 14.1.1, 19.9.1-д заасан хэргүүд уг ангилалд шууд хамаарна.
02101	14 дүгээр бүлэг: 14.1.1	14.1 дүгээр зүйл. Ялгаварлан гадуурхах (14.1.1. зарим хэсгээр) ЭХ-ийн 14.1.1-д “эрхэлсэн ажил. нөхцөл байдлаар ялгаварлан гадуурхаж эрх, эрх чөлөөг нь хязгаарласан бол” гэх хэсэг уг ангилалд хамаарах учир зарим хэсгээр дүйцүүлнэ.

Хүснэгт 8-ын үргэлжлэл

ГХСОУА-ын дугаар	ЭХ-ийн бүлэг, зүйл, хэсгийн дугаар	Гэмт хэргийн нэр (үйлдэл эсвэл үр дагаврын шинжийг харуулах тухайн зүйл, хэсэг, заалтын агуулга)
02102	19 дүгээр бүлэг: 19.9.1	19.9 дүгээр зүйл. Үндэсний эв нэгдлийг бусниулах (19.9.1. зарим хэсгээр) ЭХ-ийн 19.9.1 дүгээр зүйлд “Хүмүүсийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, шашны номлол, үзэл бодлоор дайсагнуулах, эвдрэлцүүлэх, салан тусгаарлахыг ухуулсан, уриалсан, ялгаварлан гадуурхсан” гэсэн нөхцөл байх тул уг ангилалд зарим хэсгээр дүйцүүлэн хамааруулна.
02109	14 дүгээр бүлэг: 14.1.1	14.1 дүгээр зүйл. Ялгаварлан гадуурхах (14.1.1. бүрэн хэмжээнд) Уг ангилалд тухайн бүлэгт заагаагүй бусад хэлбэрээр ялгаварлан гадуурхах үйлдэл хамаарах ба ЭХ-ийн 14.1.1-д заасан “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, эрүүл мэндийн нөхцөл байдлаар ялгаварлан гадуурхаж эрх, эрх чөлөөг нь хязгаарласан” үйлдэл хамаарна.
0211	13 дугаар бүлэг: 13.8.1, 13.10.1, 13.11.1 26 дугаар бүлэг: 26.1.1	13.8 дугаар зүйл. Зөвшөөрөлгүй гэрэл зураг авах, дуу, дүрс бичлэг хийж дамжуулах, тараах (13.8.1 бүрэн хэмжээнд) 13.10 дугаар зүйл. Хувь хүний нууцад халдах (13.10.1 бүрэн хэмжээнд) 13.11 дүгээр зүйл. Хувь хүний нууцыг задруулах (13.11.1 бүрэн хэмжээнд) 26.1 дүгээр зүйл. Цахим мэдээлэлд хууль бусаар халдах (26.1.1 зарим хэсгээр) ЭХ-ийн 13.8.1, 13.10.1, 13.11.1-д заасан хэргүүд уг ангилалд бүрэн хэмжээгээр дүйцэх бол 26.1.1-ийн хэрэв цахим хэрэгсэлд агуулагдах хувь хүний нууцад халдсан бол гэсэн нөхцөлөөр нь зарим хэсгээр дүйцүүлэн хамааруулна.

Хүснэгт 8-ын үргэлжлэл

ГХСОУА-ын дугаар	ЭХ-ийн бүлэг, зүйл, хэсгийн дугаар	Гэмт хэргийн нэр (үйлдэл эсвэл үр дагаврын шинжийг харуулах тухайн зүйл, хэсэг, заалтын агуулга)
02111	13 дугаар бүлэг: 13.10.1, 13.10.2.1 26 дугаар бүлэг: 26.1.1	13.10 дугаар зүйл. Хувь хүний нууцад халдах (13.10.1, 13.10.2.1 бүрэн хэмжээнд) 26.1 дүгээр зүйл. Цахим мэдээлэлд хууль бусаар халдах (26.1.1 зарим хэсгээр) ЭХ-ийн 13.10.1-д “Хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг хууль бусаар олж авсан, бусдад дамжуулсан” гэсэн нөхцөл байх ба уг нөхцөлөөр дээрх зүйл анги нь тус ангилалд бүрэн хэмжээгээр дүйцнэ. Мөн тус зүйл ангийн 2.1-д заасан “харилцаа холбоо, цахим хэрэгсэл ашиглаж” үйлдсэн хэргийг уг ангилалд бүрэн хэмжээгээр дүйцүүлж болохоор байна. Түүнчлэн ЭХ-ийн 26.1.1-д “Оршин суугчийн зөвшөөрөлгүйгээр орон байранд, эсхүл гадна талаас орон байрны доторх орчны гэрэл зураг авч, эсхүл дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийж олон нийтэд тараасан, эсхүл бусдад дамжуулсан бол” гэсэн нөхцөл заасан ба ийнхүү зураг авахдаа өөрийг нь оруулсан болон хувийн орон зай болох гэрийн дотор байдлыг харуулсан тохиолдолд уг ангилалд дүйцүүлэх замаар оруулна.
02119	-	-
0219	-	-

2.2.1. Бүрэн хэмжээнд дүйцүүлж болох гэмт хэрэг³³

02011 ангилал. Энэ ангилалд бүрэн хэмжээнд дүйцүүлж болох ЭХ-д заасан дараах гэмт хэргүүд байна. Үүнд:

11.1 *дүгээр зүйл.* Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах (11.1.1)

11.2 *дугаар зүйл.* Санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах (11.2.1)

11.3 *дугаар зүйл.* Хүний эрүүл мэндэд хүнд хохирол болгоомжгүйгээр учруулах (11.3.1)

11.4 *дүгээр зүйл.* Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах (11.4.1)

³³ Энэ хэсэгт хамаарч буй гэмт хэргийн талаарх тайлбарыг тайлангийн 2 дугаар хэсгийн 2.2 дахь хэсгийн Хүснэгт 6 болон Хавсралт 2-оос тус тус дэлгэрүүлж харах боломжтой.

11.5 дугаар зүйл. Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол болгоомжгүйгээр учруулах (11.5.1)

11.6 дугаар зүйл. Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах (11.6.1)

11.7 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх (11.7.1)

020111 ангилал. Энэ ангилалд бүрэн хэмжээнд дүйцүүлж болох ЭХ-д заасан дараах гэмт хэргүүд байна. Үүнд:

11.1 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах (11.1.1)

11.4 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах (11.4.1)

13.4 дүгээр зүйл. Хүнийг хүчээр алга болгох (13.4.4.2)

020112 ангилал. Энэ ангилалд бүрэн хэмжээнд дүйцүүлж болох ЭХ-д заасан дараах гэмт хэрэг байна. Үүнд:

11.6 дугаар зүйл. Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах (11.6.1)

0202 ангилал. Энэ ангилалд бүрэн хэмжээнд дүйцүүлж болох ЭХ-д заасан дараах гэмт хэргүүд байна. Үүнд:

13.2 дугаар зүйл. Хүн хулгайлах (13.2.1)

13.4 дүгээр зүйл. Хүнийг хүчээр алга болгох (13.4.1)

02022 ангилал. Энэ ангилалд бүрэн хэмжээнд дүйцэж болох ЭХ-д заасан дараах гэмт хэргүүд байна. Үүнд:

13.2 дугаар зүйл. Хүн хулгайлах (13.2.1)

13.4 дүгээр зүйл. Хүнийг хүчээр алга болгох (13.4.1)

13.9 дүгээр зүйл. Хууль бусаар баривчлах, саатуулах (13.9.1)

020222 ангилал. Энэ ангилалд бүрэн хэмжээнд дүйцэж болох ЭХ-д заасан дараах гэмт хэрэг байна. Үүнд:

13.4 дүгээр зүйл. Хүнийг хүчээр алга болгох (13.4.1)

020223 ангилал. Энэ ангилалд бүрэн хэмжээнд дүйцэж болох ЭХ-д заасан дараах гэмт хэрэг байна. Үүнд:

17.2 дугаар зүйл. Дээрэмдэх (17.2.1)

020229 ангилал. Энэ ангилалд бүрэн хэмжээнд дүйцэж болох ЭХ-д заасан дараах гэмт хэрэг байна. Үүнд:

13.9 дүгээр зүйл. Хууль бусаар баривчлах, саатуулах (13.9.1)

0203 ангилал. Энэ ангилалд бүрэн хэмжээнд дүйцэж болох ЭХ-д заасан дараах гэмт хэрэг байна. Үүнд:

13.13 дугаар зүйл. Албадан хөдөлмөрлүүлэх (13.13.1)

02032 ангилал. Энэ ангилалд бүрэн хэмжээнд дүйцэж болох ЭХ-д заасан дараах гэмт хэрэг байна. Үүнд:

13.13 дугаар зүйл. Албадан хөдөлмөрлүүлэх (13.13.1)

0204 ангилал. Энэ ангилалд бүрэн хэмжээнд дүйцэж болох ЭХ-д заасан дараах гэмт хэрэг байна. Үүнд:

13.1 дүгээр зүйл. Хүн худалдаалах (13.1.1)

02044 ангилал. Энэ ангилалд бүрэн хэмжээнд дүйцэж болох ЭХ-д заасан дараах гэмт хэрэг байна. Үүнд:

13.1 дүгээр зүйл. Хүн худалдаалах (13.1.1)

02062 ангилал. Энэ ангилалд бүрэн хэмжээнд дүйцэж болох ЭХ-д заасан дараах гэмт хэрэг байна. Үүнд:

23.5 дугаар зүйл. Хайнга хандах (23.5.1)

02063 ангилал. Энэ ангилалд бүрэн хэмжээнд дүйцэж болох ЭХ-д заасан дараах гэмт хэргүүд байна. Үүнд:

27.10 дугаар зүйл. Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих (27.10.1, 27.10.2.3)

27.11 дүгээр зүйл. Авто тээврийн гэмт хэрэг үйлдсэн жолооч зугтаах (27.11.1)

02069 ангилал. Энэ ангилалд бүрэн хэмжээнд дүйцэж болох ЭХ-д заасан дараах гэмт хэргүүд байна. Үүнд:

15.2 дугаар зүйл. Аюултай байдалд орхих, тусламж үзүүлэхгүй байх (15.2.1)

27.9 дүгээр зүйл. Замын байгууламжийн ашиглалт, засварын аюулгүй байдлын журам зөрчих (27.9.1)

0207 ангилал. Энэ ангилалд бүрэн хэмжээнд дүйцэж болох ЭХ-д заасан дараах гэмт хэргүүд байна. Үүнд:

15.6 дугаар зүйл. Бусдын амь насанд аюул учруулж болзошгүй халдварт өвчин, дархлал хомсдолын вирус халдаах (15.6.1)

27.10 дугаар зүйл. Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих (27.10.2.1, 27.10.4.1)

02071 ангилал. Энэ ангилалд бүрэн хэмжээнд дүйцэж болох ЭХ-д заасан дараах гэмт хэрэг байна. Үүнд:

15.6 дугаар зүйл. Бусдын амь насанд аюул учруулж болзошгүй халдварт өвчин, дархлал хомсдолын вирус халдаах (15.6.1)

020721 ангилал. Энэ ангилалд бүрэн хэмжээнд дүйцэж болох ЭХ-д заасан дараах гэмт хэрэг байна. Үүнд:

27.10 дугаар зүйл. Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих (27.10.2.1, 27.10.4.1)

02082 ангилал. Энэ ангилалд бүрэн хэмжээнд дүйцэж болох ЭХ-д заасан дараах гэмт хэрэг байна. Үүнд:

13.12 дугаар зүйл. Хууль бусаар мөрдөж мөшгөх (13.12.1)

0209 ангилал. Энэ ангилалд бүрэн хэмжээнд дүйцэж болох ЭХ-д заасан дараах гэмт хэргүүд байна. Үүнд:

14.1 дүгээр зүйл. Ялгаварлан гадуурхах (14.1.1)

14.8 дугаар зүйл. Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах (14.8.1)

19.9 дүгээр зүйл. Үндэсний эв нэгдлийг бусниулах (19.9.1)

0210 ангилал. Энэ ангилалд бүрэн хэмжээнд дүйцэж болох ЭХ-д заасан дараах гэмт хэргүүд байна. Үүнд:

14.1 дүгээр зүйл. Ялгаварлан гадуурхах (14.1.1)

19.9 дүгээр зүйл. Үндэсний эв нэгдлийг бусниулах (19.9.1)

02109 ангилал. Энэ ангилалд бүрэн хэмжээнд дүйцэж болох ЭХ-д заасан дараах гэмт хэрэг байна. Үүнд:

14.1 дүгээр зүйл. Ялгаварлан гадуурхах (14.1.1)

0211 ангилал. Энэ ангилалд бүрэн хэмжээнд дүйцэж болох ЭХ-д заасан дараах гэмт хэргүүд байна. Үүнд:

13.8 дугаар зүйл. Зөвшөөрөлгүй гэрэл зураг авах, дуу, дүрс бичлэг хийж дамжуулах, тараах (13.8.1)

13.10 дугаар зүйл. Хувь хүний нууцад халдах (13.10.1)

13.11 дүгээр зүйл. Хувь хүний нууцыг задруулах (13.11.1)

02111 ангилал. Энэ ангилалд бүрэн хэмжээнд дүйцэж болох ЭХ-д заасан дараах гэмт хэрэг байна. Үүнд:

13.10 дугаар зүйл. Хувь хүний нууцад халдах (13.10.1, 13.10.2.1)

Судалгааны дүнгээс үзвэл дээр дурдсан ангиллуудыг ЭХ-ийн холбогдох зүйл, хэсэг, заалтаар бүрэн хэмжээнд дүйцүүлэн нөхөх боломжтой гэж үзэж байна.

2.2.2. Зарим хэсгээр дүйцүүлж болох гэмт хэрэг

Энэ ангилалд зарим хэсгээр дүйцүүлж болох ЭХ-д заасан дараах гэмт хэргүүд байна. Үүнд:

02011 ангилал. 13.4 дүгээр зүйл. Хүнийг хүчээр алга болгох (13.4.4.2)

16.2 дугаар зүйл. Хүүхдийг согтуурах, мансуурах, донтох байдалд татан оруулах (16.2.2)

19.3 дугаар зүйл. Төрийн өндөр албан тушаалтны амь биед халдах (19.3.1)

Төрлөөр устгах (29.5.1)

020111 ангилал. 11.2 дугаар зүйл. Санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах (11.2.1)

16.2 дугаар зүйл. Хүүхдийг согтуурах, мансуурах, донтох байдалд татан оруулах (16.2.2)

19.3 дугаар зүйл. Төрийн өндөр албан тушаалтны амь биед халдах (19.3.1)

27.8 дугаар зүйл. Агаарын хөлгийг авч зугтаах (27.8.2.3)

29.5 дугаар зүйл. Төрлөөр устгах (29.5.1)

020112 ангилал. 11.7 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх (11.7.1)

02012 ангилал. 13.5 дугаар зүйл. Заналхийлэх (13.5.1)

020121 ангилал. 13.5 дугаар зүйл. Заналхийлэх (13.5.1)

020122 ангилал. 13.5 дугаар зүйл. Заналхийлэх (13.5.1)

02021 ангилал. 13.2 дугаар зүйл. Хүн хулгайлах (13.2.1)

020211 ангилал. 13.2 дугаар зүйл. Хүн хулгайлах (13.2.1)

020221 ангилал. 13.2 дугаар зүйл. Хүн хулгайлах (13.2.1)

020223 ангилал. 17.2 дугаар зүйл. Дээрэмдэх (17.2.1)

0203 ангилал. 16.10 дугаар зүйл. Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх (16.10.1)

02041 ангилал. 13.1 дүгээр зүйл. Хүн худалдаалах (13.1.1)

02042 ангилал. 13.1 дүгээр зүйл. Хүн худалдаалах (13.1.1)

02043 ангилал. 13.1 дүгээр зүйл. Хүн худалдаалах (13.1.1)

0205 ангилал. 13.5 дугаар зүйл. Заналхийлэх (13.5.1)

02051 ангилал. 13.5 дугаар зүйл. Заналхийлэх (13.5.1)

0206 ангилал. 16.11 дүгээр зүйл. Хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх (16.11.1)

02062 ангилал. 15.1 дүгээр зүйл. Эмнэлгийн тусламж үзүүлэхгүй байх (15.1.1)

23.5 дугаар зүйл. Хайнга хандах (23.5.1)

0207 ангилал. 11.1 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах (11.1.1)

11.4 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах (11.4.1)

11.6 дугаар зүйл. Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах (11.6.1)

02071 ангилал. 11.1 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах (11.1.1)

11.4 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах (11.4.1)

11.6 дугаар зүйл. Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах (11.6.1)

02072 ангилал. 27.10 дугаар зүйл. Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих (27.10.2.1, 27.10.4.1)

020722 ангилал. 27.10 дугаар зүйл. Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих (27.10.2.1, 27.10.4.1)

0208 ангилал. 13.14 дүгээр зүйл. Худал мэдээлэл тараах (13.14.1)

02081 ангилал. 13.14 дүгээр зүйл. Худал мэдээлэл тараах (13.14.1)

02092 ангилал. 14.8 дугаар зүйл. Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах (14.8.1)

02101 ангилал. 14.1 дүгээр зүйл. Ялгаварлан гадуурхах (14.1.1)

02102 ангилал. 19.9 дүгээр зүйл. Үндэсний эв нэгдлийг бусниулах (19.9.1)

0211 ангилал. 26.1 дүгээр зүйл. Цахим мэдээлэлд хууль бусаар халдах (26.1.1)

02111 ангилал. 26.1 дүгээр зүйл. Цахим мэдээлэлд хууль бусаар халдах (26.1.1)

Дээр дурдсан ангиллыг ЭХ-ийн холбогдох зүйл, хэсэг, заалтын зарим хэсгээр дүйцүүлэн нөхөх боломжтой байна.

2.2.3. Бусад асуудал

Тайлангийн 2 дугаар бүлгийн 2.2.1, 2.2.2-т дурдагдаагүй үлдсэн нь дараах ангиллууд байна. Үүнд:

0201 ангилал. Энэ ангилалд танхайрах болон заналхийлэх аргаар үйлдэгдсэн гэмт хэргүүд хамаарахгүй. Уг ангиллын агуулгаас харахад танхайрах болон заналхийлэх явцдаа хүний биед гэмтэл, хохирол учруулсан гэмт хэргүүд хамаарахаар байна. ЭХ-ийн 11.1.2.1-д онц харгис, хэрцгий аргаар хүний биед гэмтэл учруулж болохоор заасан. Гэвч энэ нь нийгмийн хор аюулын хувьд танхайрах болон заналхийлэх үйлдлээс ноцтой тул уг ангилалд хамаарахгүй. ЭХ-ийн 13.5, 15.3, 17.6 гэх мэт гэмт хэрэгт заналхийлэх гэх ухагдахууныг хуульчилсан байдаг ч энэ нь тусдаа гэмт хэргийн шинж бус, харин тухайн гэмт хэргийг үйлдсэн аргыг илэрхийлдэг учраас уг ангилалд дүйцүүлэх боломжгүй.

02019 ангилал. ЭХ-д хүний биед хохирол, гэмтэл учруулах, учруулахаар заналхийлсэн үйлдлийг нарийвчлалгүй, ерөнхий байдлаар хуульчилсан учир уг ангилалд дүйцүүлэх боломжгүй буюу нөхөх асуудал хөндөгдөхгүй.

020212, 020213, 020219, 02029, 020291, 020292, 020299, 02031, 020321, 020322, 020323, 020329, 02039, 02059, 02061, 020612, 020619, 020729, 02079, 020811, 020819, 02089, 02091, 02099, 02119, 0219 ангилал. Эдгээр ангилалд буй гэмт хэргийг ЭХ-д гэмт хэрэгт тооцож хуульчлаагүй тул дүйцүүлэх болон нөхөх хувилбар байхгүй болно.

Нэр томьёог ойлгож, хэрэглэх асуудал. 1-р түвшний 02 ангилал болон түүний доторх задаргаа ангиллын агуулгыг бүхэлд нь судлан үзэхэд энэхүү ангилал нь хүний бие махбод болон сэтгэл санаанд гэмтэл, хохирол учруулсан үйлдлийг багтаажээ.

Уг ангиллыг судлах явцад НҮБ-аас гаргасан орчуулга эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны бус нэр томьёо хэрэглэсэн нь ойлголтын зөрүү үүсгэж, ихээхэн хүндрэл үүсгэснийг дурдах нь зүйтэй. Судлаачдын хувьд ГХСОУА-ын англи хэл дээрх эх болон НҮБ-аас орчуулан гаргасан гарын авлагад дурдсан зарим нэр томьёог

Хүснэгт 9-д харуулсан агуулгаар³⁴ ойлгож, хэрэглэх нь зохистой гэж үзэж байна.

Хүснэгт 9. ГХСОУА-ын 02 дугаар ангиллын монгол хэл дээрх нэр томъёог боловсронгуй болгох санал

Ангиллын дугаар	Англи эх дэх нэр томъёо	НҮБ-ын гарын авлага дахь нэр томъёо	Судлаачдын хувилбар
02	Acts causing harm or intending to cause harm to the person	Хувь хүнд хохирол, гэмтэл учруулсан, учруулахыг завдсан хэрэг	Хувь хүнд хохирол бий болгох, хохирол учруулах нөхцөлийг бүрдүүлэх
0201	Assaults and threats	Танхайрах болон заналхийлэх	Танхайрах явцдаа хүний биед хүнд гэмтэл учруулсан
02011	Assaults	Танхайрах	Довтолгоо. Агуулгын хувь идэвхтэй үйлдэл буюу довтолгоогоор хүний биед хохирол учруулсан
020111	Serious assault	Танхайн ноцтой хэлбэр	Хүч хэрэглэсэн довтолгоо
020112	Minor assault	Танхайн хөнгөн хэлбэр	Ялимгүй хэлбэрийн довтолгоо. Агуулгын хувьд энэ нь довтолсон ч хүний биед хөнгөн хохирол учруулсан эсхүл хохирол учруулаагүй хэргүүдийг агуулна
0202	Acts against liberty	Эрх чөлөөний эсрэг хэрэг	Биеийн шилжилт хөдөлгөөний эрх чөлөөний эсрэг үйлдэл
02021	Abduction of a minor	Насанд хүрээгүй хүүхдийг хулгайлах	1) 18 насанд хүрээгүй хүнийг хулгайлах 2) Хүүхдийг хулгайлах
02022	Deprivation of liberty	Эрх чөлөөгүй болгох	Хүний чөлөөтэй байх эрхийг хязгаарлах
020223	Hijacking	Булаан эзлэх	Тээврийн хэрэгслийн дээрэм
02042	TIP for forced labour or services	Үйлчилгээний зорилгоор албадан хөдөлмөр эрхлүүлэх хүн худалдаалах	Албадан хөдөлмөрлүүлэх болон мэргэшсэн ажил үйлчилгээ эрхлүүлэх зорилгоор хүнийг худалдах

³⁴ Нэр томъёоны орчуулгын зарим агуулгыг тус тайлангийн Хавсралт 2-т дэлгэрэнгүй тайлбарласан тул тэндээс харьцуулан үзнэ үү.

Хүснэгт 9-ийн үргэлжлэл

Ангиллын дугаар	Англи эх дэх нэр томьёо	НҮБ-ын гарын авлага дахь нэр томьёо	Судлаачдын хувилбар
02043	TIP for organ removal	Эрхтэн шилжүүлэх зорилгоор хүн худалдаалах	Эрхтэн авах зорилгоор хүнийг худалдаалах
020611	Negligence in situations of children under care	Асрамжид байгаа хүүхдэд хайхрамжгүй хандах	Асран хамгаалж байгаа хүүхдэдээ болгоомжгүй хандах
020612	Negligence in situations of other dependent persons under care	Асрамжид байгаа бусад хүмүүст хайхрамжгүй хандах	Асран хамгаалж байгаа бусад этгээдэд болгоомжгүй хандах
0219	Other acts causing harm or intending to cause harm to the person	Хүнд хохирол учруулсан, хохирол учруулахыг завдсан бусад үйлдэл	Хүнд хохирол учруулсан болон хохирол учрахад хүргэсэн бусад үйлдэл

Орчуулгын хувилбарыг боловсруулахдаа хууль зүйн зүйн шинжлэх ухааны, тэр дундаа эрүүгийн эрх зүйн үүднээс авч үзэн, голчлон агуулгыг илүүтэй анхаарсан болно. Нэр томьёог зөв оноох асуудал нь тухайн гэмт хэргийн агуулгатай шууд холбоотой байх учир буруу нэр томьёо хэрэглэсэн тохиолдолд агуулга бүхэлдээ буруугаар өөрчлөгдөх магадлал өндөр юм. Цаашид ГХСОУА-ын англи хэл дээрх эх бичвэрийг эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны үүднээс нягталж, хууль зүйн нэр томьёонд нийцүүлэн дахин хянан тохиолдуулах нь чухал байна.

2.3. ХЭСГИЙН ДҮГНЭЛТ

ГХСОУА-ын 1-р түвшний 02 ангилалд хүний бие махбодод гэмтэл, хохирол учруулсан болон сэтгэл санаанд хохирол учруулах үйлдлийг хамааруулсан байна. Түүний агуулгаас үзэхэд бодит хохирол учруулсан болон учруулаагүй хэмээн ангилж болох ба үйлдлийн аргаар нь заналхийлэх үйлдлийг авч үзжээ.

2-р түвшний ангилал дотор огт нөхөх боломжгүй ангиллууд байх бөгөөд энэ нь ЭХ-д гэмт хэрэгт тооцоогүй үйлдэл, эсхүл хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагууд нэг мөр ойлгож байж шийдэлд хүрэх асуудлууд байна.

Эрүүгийн эрх зүйд үйлдэл нь гэм буруугийн хэлбэр, үйлдлийг хийж байгаа аргаараа ялгагддаг бөгөөд уг ангилал нь дээрх системийн дагуу дараалалд орсон байдаг. Гэвч зарим буруу орчуулгаас үүдэлтэйгээр уг дараалал алдагдах, цаашилбал ЭХ-д заасан гэмт хэргийг буруу нөхөх нөхцөл байдал үүсэж болзошгүй байна. 02 дугаар ангиллын гэмт хэргийг үйлдлийн төгсгөлд бий болж байгаа үр дагавраар ангилах боломжгүй. Учир нь 02 дугаар ангиллын дийлэнх гэмт хэрэг нь хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг байна.

ГУРАВ. ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИКИЙН ОЛОН УЛСЫН 03 ДУГААР АНГИЛАЛ³⁵

ГХСОУА-ын 1-р түвшний 03 дугаар ангилал нь бэлгийн хүчирхийлэл, бэлгийн шинжтэй бусад гэмт хэргийг хамааруулсан байдаг. 03 дугаар ангилал нь өөртөө 20 ангиллыг багтаадаг. Энэ ангилалд хамаарч байгаа ЭХ-ийн Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргүүдийн дүйцүүлэх хувилбарыг боловсруулахдаа 08 дугаар ангилал болон 02 дугаар ангилалд хамаарах зарим задаргаа ангиллаас хэрхэн ялгах, ойролцоо төрлийн ангиллын агуулгыг зөв ангилан дүйцүүлэх асуудал чухал юм.

3.1. ГХСОУА-ЫН 03 ДУГААР АНГИЛЛЫН АГУУЛГА

ГХСОУА-ын 03 дугаар ангиллыг судалж, ЭХ-д заасан гэмт хэрэгтэй дүйцүүлж үзэхэд гэмт хэргийн улмаас бэлгийн шинжтэй хохирол учирсан тохиолдлуудыг энэхүү 03 дугаар ангилалд хамааруулах агуулгатай байна.

Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг нь ЭХ-ийн 12 дугаар бүлэгт хуульчлагдсан бөгөөд энэ бүлэгт хамаарах гэмт хэргүүд нь хор уршиг, үр дагавар ихтэй бөгөөд улсын хэмжээнд өндөр дүнтэй үйлдэгддэг гэмт хэргийн төрөлд багтдаг. Иймд 03 дугаар ангилалд хамаарах гэмт хэргийг ЭХ-ийн холбогдох гэмт хэргийн агуулгатай дүйцүүлэх замаар олон улсын түвшинд харьцуулан судлах боломжийг нээж өгөх нь зүйтэй.

03 дугаар ангиллын агуулгаас харахад Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн дотор насанд хүрээгүй хүүхэд энэ гэмт хэргийн улмаас хохирсон үр дагаварт хамаарах үзүүлэлтүүд хэд хэд багтсан байдаг. Судалгааны явцад ГХСОУА-ын бусад ангилалд ч насанд хүрээгүй хүүхэд, бага насны

³⁵ ГХСОУ-ын энэхүү ангилалд хамаарах судалгааг судлаач М.Цэдэвсүрэн боловсруулав.

хүүхдэд гэсэн шинжээр нь ялган, ангилал болгосон тохиолдлууд ажиглагддаг тул энэ нь ГХСОУА-ын өөрийн онцлогтой холбогдон тайлбарлагдах боломжтой.

03 дугаар ангиллын агуулгыг ойлгомжтой харуулах үүднээс хүснэгтэд шилжүүлж, жишээ болгон харууллаа (Хүснэгт 10).

Хүснэгт 10. ГХСОУА-ын 03 дугаар ангилал, англи хэлээр

№	Level 1	Level 2	Level 3	Level 4	2019	2020	Comments
03	Injurious acts of a sexual nature						
1		Sexual violence					
2			Rape				
3				Rape with force			
4				Rape without force			
5				Statutory rape			
6				Other rape			
7			Sexual assault				
8				Physical sexual assault			
9				Non-physical sexual assault			
10				Other sexual assault not elsewhere classified			
11			Other acts of sexual violence				
12		Sexual exploitation					
13			Sexual exploitation of adults				
14			Sexual exploitation of children				
15				Child pornography			
16				Child prostitution			
17				Sexual grooming of children			
18				Other sexual exploitation of children			
19			Other acts of sexual exploitation				
20		Other injurious acts of a sexual nature					

Хүснэгт 11. ГХСОУА-03 дугаар ангилал, монгол хэлээр

№	1-р түвшний ангилал	2-р түвшний ангилал	3-р түвшний ангилал	4-р түвшний ангилал	2019	2020	Тайлбар
03		Бэлгийн шинж чанартай хохирол учруулсан үйлдэл					
1		Бэлгийн хүчирхийлэл					
2			Хүчин				
3				Хүч хэрэглэн хүчиндэх			
4				Хүч хэрэглэхгүйгээр хүчиндэх			
5			Үүнээс				
6				Насанд хүрээгүй хүүхдийг хүчиндэх			
7		Үүнээс		Бусад төрлийн хүчингийн гэмт хэрэг			
8		Бэлгийн дарамт					
9			Бие махбодод бэлгийн дарамт учруулах				
10			Сэтгэл санааны бэлгийн дарамт				
11			Бусад төрлийн бэлгийн дарамт				
12	Үүнээс	Бэлгийн хүчирхийллийн бусад төрөл					
13		Бэлгийн мөлжлөг					
14		Насанд хүрэгчдийн бэлгийн мөлжлөг					
15		Насанд хүрээгүй хүүхдийн бэлгийн мөлжлөг					
16			Хүүхдийн садар самуун бүхий дүрс бичлэг				
17			Хүүхдийн биеэ үнэлэлт				
18		Үүнээс		Хүүхэдтэй бэлгийн чанартай холбоо тогтоох			
19			Бусад төрлийн хүүхдийн бэлгийн мөлжлөг				
20		Хүүхдийн бэлгийн мөлжлөгийн бусад төрөл					
20		Хүний биед хохирол учруулсан бэлгийн шинжтэй бусад гэмт хэрэг					

03 дугаар ангилал нь дотроо 2-р түвшний ангилал гурав, 3-р түвшний ангилал зургаа, 4-р түвшний ангилал арван нэгийг тус тус багтаасан. Эндээс харахад ГХСОУА-ын 03 дугаар ангилал нь 01 дүгээр ангилалтай харьцуулахад 4-р түвшний ангилал буюу хамгийн бага нэгж дэх задаргаа ангиллын тоогоороо илүү байна.

Энэ ангиллын дээрх бүтэц нь нэг талаас тухайн ангиллын дагуу судалгаанд ашиглах нэгж мэдээллийн агуулга нарийвчлагдсан хэлбэрээр илэрхийлэгдэх, тоон мэдээлэл цуглуулах ангиллын агуулга маш тодорхой байгааг илтгэн харуулж байгаа бол нөгөө талаас, тухайн ангилалд хамаарч буй гэмт хэргийн нийгмийн аюулын хэр хэмжээ өндөр, хүнд хор уршиг, үр дагавар бүхий гэмт хэрэг учраас түүнийг судлах нэгж мэдээллийн агуулга илүү их нарийвчилсан хэлбэрээр илэрхийлэгдэх шаардлага олон улсын түвшинд чухал байдгийг харуулж байна.

Ялангуяа 3-р түвшний ангиллын задаргаа болох 4-р түвшний ангилалд насанд хүрээгүй хүүхэд, бага насны хүүхдэд холбогдох үзүүлэлтийг тусад нь ангилал болгон боловсруулсан хэд хэдэн тохиолдол байгааг харж болно.

Өмнө дурдсанчлан ГХСОУА-ыг боловсруулахдаа олон орны ЭХ-ийг судлан, тэдгээрт заасан гэмт хэргийг баримжаалан, дундын хувилбараар ангилал болгосон байх тул ГХСОУ-ын 03012 ангилал нь Бэлгийн дарамт гэх нэршилтэй байгааг анхаарах нь чухал. Олон улс оронд ийм гэмт хэрэг байгаа учраас ГХСОУА-д 3-р түвшний ангилал болон боловсруулагдсан байх бөгөөд энэ ангиллыг дотор нь бие махбодод, сэтгэл санаанд, бусад хэлбэрээр дарамт учруулах гэж ялган, үүнийгээ задаргаа ангилал болгон боловсруулжээ.

3.2. ГХСОУА БА ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ДАХЬ ГЭМТ ХЭРГИЙГ ДҮЙЦҮҮЛСЭН ХУВИЛБАР, ТҮҮНИЙГ НӨХӨХ АСУУДАЛ

Дүйцүүлэх хувилбарыг боловсруулах явцад өмнөх ангиллыг судлахад үүсэж байсан асуудлууд нэгэн адил байна. Иймд судалгааны тайлангийн энэхүү хэсэгт мөн л бүрэн хэмжээнд, зарим хэсгээр дүйцэж байгаа гэмт хэргийг харуулахын зэрэгцээ огт дүйцэхгүй ангилал, эдгээрийг нөхөх асуудлыг мөн хамтатган судаллаа.

Хүснэгт 12. ГХСОУА-ын 03 дугаар ангилалд ЭХ дахь гэмт хэргийг дүйцүүлсэн хувилбар

ГХСОУА-ын дугаар	ЭХ-ийн бүлэг, зүйл, хэсгийн дугаар	Гэмт хэргийн нэр (үйлдэл эсвэл үр дагаврын шинжийг харуулах тухайн зүйл, хэсэг, заалтын агуулга)
03	12 дугаар бүлэг	12 дугаар бүлэг. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 16.9 дүгээр зүйл. Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах
0301	12.1. Хүчиндэх	12.1. Хүчиндэх (зарим хэсгээр)
	12.1 дүгээр зүйл 12.1.1	12.1.1 Хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл сэтгэцийн өвчтэй, согтуурсан, мансуурсан, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, бусад өвчний улмаас биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй, эсхүл эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгааг далимдуулан хүчээр бэлгийн харьцаанд орсон, эсхүл бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн (зарим хэсгээр)
	12.1.2 дугаар хэсэг 12.1.2.2	12.1.2.1 арван дөрвөөс дээш арван найман насанд хүрээгүй хүнийг хүчиндэж (бүрэн хэмжээнд)
	12.1.2 дугаар хэсэг 12.1.2.3	12.1.2.2 бүлэглэж (бүрэн хэмжээнд)
	12.1.2 дугаар хэсэг 12.1.2.4	12.1.2.3 гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндэж (бүрэн хэмжээнд)
	12.1.2 дугаар хэсэг 12.1.2.5	12.1.2.4 хохирогчийг жирэмсэн болгож (бүрэн хэмжээнд)
	12.1.2 дугаар хэсэг 12.1.2.6	
	12.1.2 дугаар хэсэг 12.1.2.7	
	12.1.2 дугаар хэсэг 12.1.2.8	
	12.1.2 дугаар хэсэг 12.1.2.10	
03011	12.1.3 дугаар хэсэг	
	12.1.4 дүгээр хэсэг	
	Тайлбар: 12.1.1 болон 12.1.4 дэх хэсгүүдийн зарим хэсэг энэхүү ангилалд хамаарахаар байна. Иймд ЭХ-ийн 12.1.1, 12.1.4 дэх хэсгийн зөвхөн зарим хэсгийн агуулга дүйцнэ.	

Хүснэгт 12-ын цргэлжлэл

ГХСОУА- ын дугаар	ЭХ-ийн бүлэг, зүйл, хэсгийн дугаар	Гэмт хэргийн нэр (үйлдэл эсвэл үр дагаврын шинжийг харуулах тухайн зүйл, хэсэг, заалтын агуулга)
		<p>12.1.2.5 хохирогчид бэлгийн замын халдварт өвчин халдааж (бүрэн хэмжээнд)</p> <p>12.1.2.6 хоёр, түүнээс олон хүнийг хүчиндэж (бүрэн хэмжээнд)</p> <p>12.1.2.7 урьд нь энэ бүлэгт заасан гэмт хэргийг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн (бүрэн хэмжээнд)</p> <p>12.1.2.8 харгис хэрцгий аргаар (бүрэн хэмжээнд)</p> <p>12.1.2.10 хохирогчийг тохуурхан доромжилж үйлдсэн (бүрэн хэмжээнд)</p> <p>12.1.3 Энэ гэмт хэргийн улмаас ураг зулбасан, эсхүл арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон, гэр бүлийн хамаарал бүхий арван зургаан насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн (бүрэн хэмжээнд),</p> <p>12.1.4 Энэ гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн, энэ гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан (зарим хэсгээр)</p>
030111	<p>12.1 дүгээр зүйл 12.1.1</p> <p>12.1.2 дугаар хэсэг 12.1.2.2</p> <p>12.1.2 дугаар хэсэг 12.1.2.3</p> <p>12.1.2 дугаар хэсэг 12.1.2.4.</p> <p>12.1.2 дугаар хэсэг 12.1.2.5</p> <p>12.1.2 дугаар хэсэг 12.1.2.6</p> <p>12.1.2 дугаар хэсэг 12.1.2.7</p> <p>12.1.2 дугаар хэсэг 12.1.2.8</p> <p>12.1.2 дугаар хэсэг 12.1.2.10</p>	<p>12.1.1 (зарим хэсгээр)</p> <p>12.1.2.2 (бүрэн хэмжээнд)</p> <p>12.1.2.3 (бүрэн хэмжээнд)</p> <p>12.1.2.4 (бүрэн хэмжээнд)</p> <p>12.1.2.5 (бүрэн хэмжээнд)</p> <p>12.1.2.6 (бүрэн хэмжээнд)</p> <p>12.1.2.7 (бүрэн хэмжээнд)</p> <p>12.1.2.8 (бүрэн хэмжээнд)</p> <p>12.1.2.10 (бүрэн хэмжээнд)</p>
030112	-	-
030113	<p>12.1.2 дугаар хэсэг 12.1.2.2</p> <p>12.1 дүгээр зүйл 12.1.3</p> <p>12.1 дүгээр зүйл 12.1.4 дэх хэсэг</p> <p>Тайлбар: 12.1.2.1 дэх заалт мөн 12.1.3 болон 12.1.4 дэх хэсгээс зөвхөн тод хараах будсан агуулга энэхүү ангилалд дүйцэхээр байна.</p>	<p>12.1.2.1 арван дөрвөөс дээш арван найман насанд хүрээгүй хүнийг хүчиндэж (бүрэн хэмжээнд)</p> <p>12.1.3 Энэ гэмт хэргийн улмаас ураг зулбасан, эсхүл арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон; гэр бүлийн хамаарал бүхий арван зургаан насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн (бүрэн хэмжээнд)</p> <p>12.1.4 Энэ гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн, энэ гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан (зарим хэсгээр)</p>

Хүснэгт 12-ын үргэлжлэл

ГХСОУА-ын дугаар	ЭХ-ийн бүлэг, зүйл, хэсгийн дугаар	Гэмт хэргийн нэр (үйлдэл эсвэл үр дагаврын шинжийг харуулах тухайн зүйл, хэсэг, заалтын агуулга)
030119	-	-
03012	-	-
030121	-	-
030122	-	-
030129	-	-
03019	12.1 дүгээр зүйл 12.1.1	12.1.1 ...эсхүл бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн (зарим хэсгээр)
0302	12.3 дугаар зүйл 12.3 16.9 дүгээр зүйл 16.9.1	12.3 дугаар зүйл. Бэлгийн мөлжлөг (зарим хэсгээр) 12.3.1 дэх хэсэг (бүрэн хэмжээнд) 12.3.2 дахь хэсэг (бүрэн хэмжээнд) 12.3.3 дахь хэсэг (бүрэн хэмжээнд) 12.3.4 дэх хэсэг (бүрэн хэмжээнд) 16.9 дүгээр зүйл. Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах (бүрэн хэмжээнд)
03021	12.3 дугаар зүйл 12.3.1 12.3.2 дахь хэсэг 12.3.2.2 12.3.2 дахь хэсэг 12.3.2.3 12.3.2 дахь хэсэг 12.3.2.4 12.3.2 дахь хэсэг 12.3.2.5 12.3.2 дахь хэсэг 12.3.2.6 12.3.3 дахь хэсэг 12.3.3.1 12.3.4 дахь хэсэг 12.3.4.2	12.3.1 Хохирогчид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан зорчих эрхийг хязгаарлахгүйгээр бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулсан (бүрэн хэмжээнд) 12.3.2.2 урьд энэ бүлэгт заасан гэмт хэрэг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн (бүрэн хэмжээнд) 12.3.2.3 хохирогчид мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглүүлж (бүрэн хэмжээнд) 12.3.2.4 хохирогчийг жирэмсэн болгож (бүрэн хэмжээнд) 12.3.2.5 хоёр, түүнээс олон хүний эсрэг (бүрэн хэмжээнд) 12.3.2.6 байнга тогтвортой үйлдсэн (бүрэн хэмжээнд) 12.3.3.1 ураг зулбасан 12.3.4.2 зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн (бүрэн хэмжээнд)

Хүснэгт 12-ын цргэлжлэл

ГХСОУА-ын дугаар	ЭХ-ийн бүлэг, зүйл, хэсгийн дугаар	Гэмт хэргийн нэр (үйлдэл эсвэл үр дагаврын шинжийг харуулах тухайн зүйл, хэсэг, заалтын агуулга)
03022	12.3.2 дахь хэсэг 12.3.2.1 12.3.3 дахь хэсэг 12.3.3.2 12.3.4 дэх хэсэг 12.3.4.1 16.9 дүгээр зүйл 16.9.1, 16.9.2	12.3.2.1 арван дөрвөөс арван найман насанд хүрээгүй хүнийг албадан оруулж (бүрэн хэмжээнд) 12.3.3.2 арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон (бүрэн хэмжээнд) 12.3.4.1 бага насны хүүхдийг албадан оруулж (бүрэн хэмжээнд) 16.9 дүгээр зүйл Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах (бүрэн хэмжээнд)
030221	16.9 дүгээр зүйл. 16.9 Дүрс бичлэгт хамаарах үйлдэл нь энэхүү ангилалд хамаарах агуулгатай тул зарим хэсгээр дүйцүүлэх боломжтой байна.	16.9 дүгээр зүйл. Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах (зарим хэсгээр) Дүрс бичлэгт хамаарах агуулгыг маягтад тусад нь үзүүлэлт болгон тоолж бүртгэх замаар мэдээллийг гарган авч ангилалд дүйцүүлэн нөхөх боломжтой болно.
030222	12.3.2 дахь хэсэг 12.3.2.1 12.3.3 дахь хэсэг 12.3.3.2 12.3.4 дэх хэсэг 12.3.4.1	12.3.2.1 арван дөрвөөс арван найман насанд хүрээгүй хүнийг албадан оруулж (бүрэн хэмжээнд) 12.3.3.2 арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон (бүрэн хэмжээнд) 12.3.4.1 бага насны хүүхдийг албадан оруулж (бүрэн хэмжээнд)
030223	16.9 дүгээр зүйл 16.9.1, 16.9.2	16.9 дүгээр зүйл. Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах (зарим хэсгээр) 030221 ангилалд дүйцсэн ЭХ-ийн 16.9-д дүрс бичлэгт хамаарах үйлдлээс бусад үйлдэлд хамаарах гэмт хэргийг 030223 ангилалд дүйцүүлэх боломжтой байна. Дүрс бичлэгтэй холбоотой үйлдлийг тусад нь үзүүлэлт болгон тоолж бүртгэх замаар энэ ангиллыг дүйцүүлэн нөхөх боломжтой болно.
030229	-	-
03029	-	-
0309	12.2 дугаар зүйл 12.2.1, 12.2.2, 12.2.3 12.6 дугаар зүйл. Биеэ үнэлэхийг зохион байгуулах. 12.6.1, 12.6.2, 12.6.3	12.2 дугаар зүйл. Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах (бүрэн хэмжээнд) 12.6 дугаар зүйл. Биеэ үнэлэхийг зохион байгуулах (бүрэн хэмжээнд)

ГХСОУА-ын 1-р түвшний 03 дугаар ангиллын бүтэц, агуулгыг судлан үзэхэд бэлгийн шинжтэй хохирол учруулсан гэмт хэргээ бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг, хүний биед хохирол учруулсан бэлгийн шинжтэй бусад гэмт хэрэг гэсэн 2-р түвшний ангилалд задалсан байна.

Бэлгийн хүчирхийлэл. Энэ ангилалд хүчиндэх, бэлгийн дарамт учруулах, бэлгийн хүчирхийллийн бусад төрлийн гэмт хэргийг хамааруулжээ. Эндээс харахад бэлгийн хүчирхийлэл гэдгийг хүчиндэх болон бэлгийн дарамт гэсэн бие даасан гэмт хэрэгт тооцож тус тусад нь ангилсан бол бусад бэлгийн хүчирхийлэлд хамаарах гэмт хэргийг нэгтгэн бэлгийн хүчирхийллийн бусад төрлийн гэмт хэрэг болгон ангилжээ.

Хүчиндэх гэмт хэргийн хувьд ЭХ-д бие даасан гэмт хэргээр хуульчлагдаж ирсэн тул тохирох зүйл, хэсэг, заалттай дүйцүүлэхэд үүсэх хүндрэл гарахааргүй байгаа бол бэлгийн дарамт учруулах гэмт хэргийн хувьд ЭХ-д гэмт хэрэгт тооцоогүй, харин зөрчил болгон хуульчилсан. Иймд бэлгийн дарамт гэсэн ангилалд дүйцүүлэх гэмт хэрэг болон түүнийг нөхөх тухай асуудал энэ тайлангийн хүрээнд хөндөгдөхөөргүй байна.

ГХСОУА-ын гарын авлагад тухайн улс орон дахь “захиргааны шинжтэй зөрчлийг авч үздэггүй”³⁶ талаар дурдсан байх тул энэхүү судалгааг ЭХ-д заасан гэмт хэргийн хүрээнд авч үзсэн болно.

³⁶ Ангиллын гол зорилго зорилго бол хангалттай тооны улс оронд гэмт хэрэг мөн гэж нийтлэгээр хүлээн зөвшөөрдөг гэмт үйлдлийг, олон улсын түвшин дэх бодлогын ач холбогдол болон практик хэрэглээний тэнцвэртэй байдлыг харгалзан, нарийвчлалтай тодорхойлон хамруулах явдал юм. Цаашилбал, ГХСОУА ерөнхийдөө захиргааны шинжтэй бага хэмжээний зам тээврийн зөрчил мэтийн хэргийн ангиллыг авч үздэггүй. ICCS_English_2016_web.pdf. p 12.

3.2.1. Бүрэн хэмжээнд дүйцүүлж болох гэмт хэрэг³⁷

0301 ангилал. Энэ ангилалд бүрэн хэмжээнд дүйцэж болох ЭХ-д заасан дараах гэмт хэргүүд байна. Үүнд:

12.1.1 Хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл сэтгэцийн өвчтэй, согтуурсан, мансуурсан, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, бусад өвчний улмаас биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй, эсхүл эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгааг далимдуулан хүчээр бэлгийн харьцаанд орсон, эсхүл бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн;

12.1.2 дахь хэсгийн:

12.1.2.1 арван дөрвөөс дээш арван найман насанд хүрээгүй хүнийг хүчиндэж;

12.1.2.2 бүлэглэж;

12.1.2.3 гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндэж;

12.1.2.4 хохирогчийг жирэмсэн болгож;

12.1.2.5 хохирогчид бэлгийн замын халдварт өвчин халдааж;

12.1.2.6 хоёр, түүнээс олон хүнийг хүчиндэж;

12.1.2.7 урьд нь энэ бүлэгт заасан гэмт хэргийг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн;

12.1.2.8 харгис хэрцгий аргаар;

12.1.2.10 хохирогчийг тохуурхан доромжилж үйлдсэн;

12.1.3 дахь хэсэгт заасан зөвхөн “энэ гэмт хэргийн улмаас ураг зулбасан, эсхүл арван зургаан насанд хүрээгүй хүнийг

³⁷ Энэ хэсэгт хамаарч буй гэмт хэргийн талаарх тайлбарыг тайлангийн 1 дүгээр бүлгийн 1.2 дахь хэсгийн Хүснэгт 2 болон Хавсралт 1-ээс тус тус дэлгэрүүлж харах боломжтой.

жирэмсэн болгосон; гэр бүлийн хамаарал бүхий арван зургаан насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн”.

03011 ангилал. Энэ ангилалд бүрэн хэмжээнд дүйцэж болох ЭХ-д заасан дараах гэмт хэргүүд байна. Үүнд:

12.1.2.1 арван дөрвөөс дээш арван найман насанд хүрээгүй хүнийг хүчиндэж;

12.1.2.2 бүлэглэж;

12.1.2.3 гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндэж;

12.1.2.4 хохирогчийг жирэмсэн болгож;

12.1.2.5 хохирогчид бэлгийн замын халдварт өвчин халдааж;

12.1.2.6 хоёр, түүнээс олон хүнийг хүчиндэж;

12.1.2.7 урьд нь энэ бүлэгт заасан гэмт хэргийг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн;

12.1.2.8 харгис хэрцгий аргаар;

12.1.2.10 хохирогчийг тохуурхан доромжилж үйлдсэн;

12.1.3. Энэ гэмт хэргийн улмаас ураг зулбасан, эсхүл арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон; гэр бүлийн хамаарал бүхий арван зургаан насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн.

030111 ангилал. Энэ ангилалд бүрэн хэмжээнд дүйцэж болох ЭХ-д заасан дараах гэмт хэргүүд байна. Үүнд:

12.1.2.2 бүлэглэж;

12.1.2.3 гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндэж;

12.1.2.4 хохирогчийг жирэмсэн болгож;

12.1.2.5 хохирогчид бэлгийн замын халдварт өвчин халдааж;

12.1.2.6 хоёр, түүнээс олон хүнийг хүчиндэж;

12.1.2.7 урьд нь энэ бүлэгт заасан гэмт хэргийг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн;

12.1.2.8 харгис хэрцгий аргаар;

12.1.2.10 хохирогчийг тохуурхан доромжилж үйлдсэн.

030113 ангилал. Энэ ангилалд бүрэн хэмжээнд дүйцэж болох ЭХ-д заасан дараах гэмт хэрэг байна. Үүнд:

12.1.2.1 арван дөрвөөс дээш арван найман насанд хүрээгүй хүнийг хүчиндэж.

03019 ангилал. Энэ ангилалд бүрэн хэмжээнд дүйцэж болох ЭХ-д заасан дараах гэмт хэрэг байна. Үүнд:

12.1.1 ...эсхүл бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн.

0302 ангилал. Энэ ангилалд бүрэн хэмжээнд дүйцэж болох ЭХ-д заасан дараах гэмт хэргүүд байна. Үүнд:

12.3 дугаар зүйл. Бэлгийн мөлжлөг (12.3.1, 12.3.2, 12.3.3, 12.3.4);

16.9 дүгээр зүйл. Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах (16.9.1, 16.9.2).

03021 ангилал. Энэ ангилалд бүрэн хэмжээнд дүйцэж болох ЭХ-д заасан дараах гэмт хэргүүд байна. Үүнд:

12.3.1. Хохирогчид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан зорчих эрхийг хязгаарлахгүйгээр бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулсан;

12.3.2.2 урьд энэ бүлэгт заасан гэмт хэрэг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн;

12.3.2.3 хохирогчид мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглүүлж;

12.3.2.4 хохирогчийг жирэмсэн болгож;

12.3.2.5 хоёр, түүнээс олон хүний эсрэг;

12.3.2.6 байнга тогтвортой үйлдсэн;

12.3.3.1 ураг зулбасан;

12.3.4.2 зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн.

03022 ангилал. Энэ ангилалд бүрэн хэмжээнд дүйцэж болох ЭХ-д заасан дараах гэмт хэргүүд байна. Үүнд:

12.3.2.1 арван дөрвөөс арван найман насанд хүрээгүй хүнийг албадан оруулж;

12.3.3.2 арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон ;

12.3.4.1 бага насны хүүхдийг албадан оруулж;

16.9 дүгээр зүйл. Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах (16.9.1, 16.9.2).

030222 ангилал. Энэ ангилалд бүрэн хэмжээнд дүйцэж болох ЭХ-д заасан дараах гэмт хэргүүд байна. Үүнд:

12.3.2.1 арван дөрвөөс арван найман насанд хүрээгүй хүнийг албадан оруулж;

12.3.3.2 арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон;

12.3.4.1 бага насны хүүхдийг албадан оруулж.

0309 ангилал. Энэ ангилалд бүрэн хэмжээнд дүйцэж болох ЭХ-д заасан дараах гэмт хэргүүд байна. Үүнд:

12.2 дугаар зүйл. Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах (12.2.1, 12.2.2, 12.2.3);

12.6 дугаар зүйл. Биеэ үнэлэхийг зохион байгуулах (12.6.1, 12.6.2, 12.6.3).

Дээр дурдсан ангиллуудыг ЭХ-ийн холбогдох зүйл, хэсэг, заалтаар бүрэн хэмжээнд дүйцүүлэн нөхөх боломжтой болох нь судалгааны дүнгээс тодорхой харагдаж байна.

3.2.2. Зарим хэсгээр дүйцүүлж болох гэмт хэрэг³⁸

0301 ангилал. Энэ ангилалд зарим хэсгээр дүйцэж болох ЭХ-д заасан дараах гэмт хэрэг байна. Үүнд:

12.1.4 дэх хэсэгт заасан зөвхөн “энэ гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн” тохиолдлууд хамаарна.

03011 Энэ ангилалд зарим хэсгээр дүйцэж болох ЭХ-д заасан дараах гэмт хэргүүд байна. Үүнд:

12.1.1 дүгээр хэсэгт заасан зөвхөн “Хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл сэтгэцийн өвчтэй, согтуурсан, мансуурсан, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, бусад өвчний улмаас биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй, эсхүл эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгааг далимдуулан хүчээр бэлгийн харьцаанд орсон”;

12.1.4 дэх хэсэгт заасан зөвхөн “энэ гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн”.

030111 Энэ ангилалд зарим хэсгээр дүйцэж болох ЭХ-д заасан дараах гэмт хэргүүд байна. Үүнд:

12.1.1 дүгээр хэсэгт заасан зөвхөн “Хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл сэтгэцийн өвчтэй, согтуурсан, мансуурсан, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, бусад өвчний улмаас биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй, эсхүл эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгааг далимдуулан хүчээр бэлгийн харьцаанд орсон”;

12.1.3 Энэ гэмт хэргийн улмаас ураг зулбасан.

030113 ангилал. Энэ ангилалд зарим хэсгээр дүйцэж болох ЭХ-д заасан дараах гэмт хэргүүд байна. Үүнд:

³⁸ Энэ хэсэгт хамаарч буй гэмт хэргийн талаарх тайлбарыг тайлангийн 1 дүгээр бүлгийн 1.2 дахь хэсгийн Хүснэгт 2 болон Хавсралт 1-ээс тус тус дэлгэрүүлж харах боломжтой.

12.1.3 арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон; гэр бүлийн хамаарал бүхий арван зургаан насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн;

12.1.4 Энэ гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн.

030221 ангилал. Энэ ангилалд зарим хэсгээр дүйцэж болох ЭХ-д заасан дараах гэмт хэрэг байна. Үүнд:

16.9 дүгээр зүйл. Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах (16.1, 16.2).

030223 ангилал. Энэ ангилалд зарим хэсгээр дүйцэж болох ЭХ-д заасан дараах гэмт хэрэг байна. Үүнд:

16.9 дүгээр зүйл. Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах (16.9.1, 16.9.2).

Дээр дурдсан ангиллуудыг ЭХ-ийн холбогдох зүйл, хэсэг, заалтын зарим хэсгээр дүйцүүлэн нөхөх боломж байгаа нь судалгааны дүнгээс харагдаж байна.

3.2.3. Бусад асуудал

03 ангилалд хамаарах бусад ангилал. Тайлангийн 3 дугаар бүлгийн 3.2.1 болон 3.2.2-т дурдагдаагүй үлдсэн дараах ангиллууд байна. Эдгээр нь тодорхой шалтгааны улмаас дүйцэхгүй хийгээд нөхөх боломжгүй байгаа 3-р түвшний 03012 болон 03029, 4-р түвшний 030112, 030119, 030121, 030122, 030129, 030229 ангиллууд юм.

03012, 030121, 030222, 030129 ангилал. 3-р түвшний 03012 дугаар ангилал нь Бэлгийн дарамт учруулах гэмт хэрэг байх бөгөөд энэ ангилалд 4-р түвшний 030121, 030222, 030129 гэсэн гурван задаргаа ангиллыг багтаасан. МУ-д энэ төрлийн гэмт хэргийг гэмт хэрэгт тооцоогүй. Гэвч 2015 онд баталж, 2017 онд дагаж мөрдсөн ЭХ-ийн 12.4 дүгээр зүйлд бэлгийн дарамтыг гэмт хэрэгт тооцсон байсан ч 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн нэмэлт, өөрчлөлт оруулсан хуулиар хүчингүй болсонд тооцсон байна. Иймд эдгээр

ангилалд дүйцүүлэх гэмт хэрэг, түүнийг дүйцүүлэн нөхөх хувилбар байхгүй болно.

03029 ангилал. ЭХ-д Хүүхдийн бэлгийн мөлжлөг гэсэн гэмт хэргийг тусад нь зүйл болгон хуульчлаагүй. Харин бэлгийн мөлжлөг гэсэн гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн болгон хэд хэдэн заалтаар насанд хүрээгүй хүүхэд, бага насны хүүхдийн бэлгийн мөлжлөгт хамаарах гэмт хэрэг, үйлдлийг хуульчилсан. Иймд хүүхдийн бэлгийн мөлжлөгт холбогдох дээр дурдсан гэмт хэргүүдээс өөр гэмт хэрэг одоогийн ЭХ-д байхгүй тул дүйцүүлэх гэмт хэрэг, түүнийг дүйцүүлэн нөхөх хувилбар байхгүй болно.

030112 ангилал. ГХСОУА-ын энэ ангиллын агуулга нь хохирогчийг төөрөлдүүлэх замаар, эсвэл мансуурсан үед, эсвэл харилцан тохиролцсон эсэхээс үл хамаараад хүч хэрэглэхгүйгээр бэлгийн харилцаанд орсон үйлдлийг хамааруулахаар заасан байна. Мөн түүнчлэн “бага насны хүүхдийг хүчиндэх” гэмт хэрэг нь энэ ангилалд хамаарахгүй талаар тайлбар хэсэгт дурджээ. Иймд ЭХ-ийн 12.5 дугаар зүйлд заасан гэмт хэргийг дүйцүүлэх боломжгүй тул энэхүү ангиллыг дүйцүүлэх гэмт хэрэг, түүнийг дүйцүүлэн нөхөх хувилбар байхгүй болно.

030119 ангилал. ГХСОУА-ын энэхүү ангилал нь өмнөх ангиллуудад агуулгын хувьд дүйцэхээргүй байгаа бусад төрлийн хүчингийн гэмт хэргийг дүйцүүлэн нөхөх ангилал юм. ЭХ-ийн 12 дугаар бүлэгт заасан гэмт хэрэг нь бүгд өмнөх ангиллуудад дүйцсэн тул энэ ангилалд дүйцүүлэх гэмт хэрэг, түүнийг дүйцүүлэн нөхөх хувилбар байхгүй болно.

030229 ангилал. ГХСОУА-ын энэхүү ангилал нь өмнөх ангиллуудад агуулгын хувьд дүйцэхээргүй байгаа бусад төрлийн хүүхдийн бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийг дүйцүүлэн нөхөх ангилал юм. Гэвч ЭХ-ийн 12.3 дугаар зүйлд заасан гэмт хэрэг нь бүгд өмнөх ангиллуудад дүйцсэн тул энэ ангилалд дүйцүүлэх гэмт хэрэг, түүнийг дүйцүүлэн нөхөх хувилбар байхгүй болно.

Нэр томьёог ойлгож, хэрэглэх асуудал. 1-р түвшний 03 ангилал болон түүний доторх 20 ангиллын агуулгыг бүхэлд нь судлан үзэхэд энэхүү ангилал нь бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийг багтаажээ.

Иймд ГХСОУА-ын тухайн ангилалд хамаарах зарим нэр томьёог нэг мөр, оновчтой ойлгох үүднээс дараах хувилбарыг дэвшүүллээ.

Хүснэгт 13. ГХСОУА-ын 03 дугаар ангиллын монгол хэл дээрх нэр томьёог боловсронгуй болгох санал

Ангиллын дугаар	Англи эх дэх нэр томьёо	НҮБ-ын гарын авлага дахь нэр томьёо	Судлаачийн хувилбар
03	Injurious acts of a sexual nature	Бэлгийн шинж чанартай хохирол учруулсан үйлдэл	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг
0301	Rape	Хүчин	Хүчиндэх гэмт хэрэг
030222	Child prostitution	Хүүхдийн биеэ үнэлэлт	Хүүхдийн биеийг үнэлэх гэмт хэрэг
0309	Other injurious acts of a sexual nature	Хүний биед хохирол учруулсан бэлгийн шинжтэй бусад гэмт хэрэг	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг бусад гэмт хэрэг

03 ангилал нь дотроо 20 задаргаа ангиллыг багтаасан байгаагаас дээрх хүснэгтэд дурдсанаас бусад ангиллын нэршлийг НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдсан³⁹ нэршлийн дагуу ойлгож, хэрэглэхэд хүндрэл үүсэхээргүй байна. 03 дугаар ангиллын агуулгыг судлан үзэхэд ЭХ-ийн 12 дугаар бүлэгт заасан гэмт хэргүүдтэй дүйцэж байх тул ангиллын нэрийг 12 дугаар бүлгийн “Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг” гэх нэршлээр ойлгож, хэрэглэх нь тухайн ангиллыг судлах, ангиллын дагуу тоон мэдээллийг нөхөх зэрэгт илүү хялбар дөхөм болно.

³⁹ Хавсралт 3-аас нэр томьёог дэлгэрүүлж харна уу.

Дүйцүүлэх хувилбарын дагуу тоон мэдээллийг нөхөх асуудал 03 дугаар ангиллын дүйцүүлэх хувилбарын дагуу тоон мэдээллийг нөхөх асуудалд өмнөх ангиллуудад тулгарч байсан асуудлууд мөн адил тулгарч байна. Иймд дүйцүүлж буй гэмт хэргийг хэрхэн нөхөх талаар дараах жишээг дурдъя.

03 дугаар ангиллын 3, 4-р түвшний ангилал дотроо багагүй задарч байгаа тул ЭХ-ийн тодорхой төрлийн гэмт хэрэг, түүний үйлдэл, хэм хэмжээний аль нэг нөхцөл, үр дагавар эдгээр түвшин хооронд ЭХ-ийн зүйл хэсгийн дугаараараа давхцах тохиолдол нэлээд гарахаар байна. Иймд зөвхөн зүйл, хэсгийн дугаараар бус энэхүү судалгааны тайлангийн 3.2 дахь хэсэгт бүрэн хэмжээнд, зарим хэсгээр дүйцэх гэмт хэргийн тайлбар, мөн Хавсралт 3-аас тодорхой мэдээллийг тус тус дэлгэрүүлэн харах шаардлагатай болно.

03 дугаар ангиллын хувьд 01 дүгээр ангилалтай харьцуулахад завдсан тохиолдлуудыг хамааруулах агуулга байхгүй тул зөвхөн үйлдэл төгссөн гэмт хэрэгт дүйцүүлж, нөхөх асуудал яригдана.

3.3. ХЭСГИЙН ДҮГНЭЛТ

ГХСОУА 1-р түвшний 03 ангилал нь дотроо 20 ангиллыг багтаасан бөгөөд бүхэлд нь судлан үзэхэд ЭХ-д заасан Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийг хамруулсан агуулгатай байна. Энэ ангилалд анхаарал татсан зүйл бол ЭХ-ийн 12 дугаар бүлгээс гадна Хүүхдийн садар самуун бүхий дүрс бичлэгт хамаарах гэмт хэрэг⁴⁰, мөн Бэлгийн дарамт учруулах гэмт хэрэг энэ ангилалд тус тус багтжээ.

03 дугаар ангиллын доторх 20 ангилал нь 3 болон 4-р түвшний ангиллыг нэлээд хэмжээгээр багтаасан байх тул Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт хамаарах

⁴⁰ Энэ хэсэгт ашигласан нэршил нь НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдсан хувилбар болно.

зарим үйлдэл, үр дагавар, хэм хэмжээний тодорхой нөхцөлийг тусгайлан ангилал болгон боловсруулж, эдгээрийг илэрхийлэх тоон мэдээллийг нөхүүлж, судалгааны эргэлтэд оруулдаг болох нь тодорхой байна.

03 ангиллыг 01 ангилалтай харьцуулахад зөвхөн төгссөн гэмт хэрэгтэй дүйцүүлж, түүнийг нөхөхөөр байх бөгөөд задаргаа ангиллын агуулгаас харахад бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг, бусад төрлийн бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг гэж ангилжээ.

Бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийг дотор нь хүчиндэх гэмт хэрэг гэж задлаад үүнийгээ хүч хэрэглэж болон хэрэглэхгүйгээр хүчиндэх, насанд хүрээгүй хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг хэмээн төрөлжүүлсэн. Эдгээр төрөл тус бүрд дүйцсэн гэмт хэрэг өөр хоорондоо давхцахгүй байхаар тус тусад нь ангилж боловсруулсан байгаа ангиллыг судлах, албан ажлын шаардлагаар дүйцүүлэн нөхөх тохиолдолд анхаарах шаардлагатай юм.

Практикаас харахад бүрэн хэмжээнд дүйцүүлсэн гэмт хэргийн хувьд одоо байгаа статистик мэдээллийн хүрээнд шууд нөхөх боломжтой бол зарим хэсгээр дүйцүүлсэн гэмт хэргүүд нь шууд нөхөгдөх боломжгүй, нэмэлт мэдээлэл заавал шаардагдахаар байна. Иймд нэмэлт мэдээлэл шаардагдаж байгаа ангиллыг цаашид хэрхэн нөхөхийг мөн л энэ ангиллын хүрээнд анхаарах шаардлагатай.

1-р түвшний 03 дугаар ангилал дотор огт нөхөх боломжгүй байгаа ангиллууд бас бий. Эдгээр нь ЭХ-д гэмт хэрэгт тооцоогүй үйлдлүүд болно. Тухайлбал, Бэлгийн дарамт учруулах гэмт хэрэг, түүнд хамаарах ангиллууд, мөн ЭХ-д заасан тухайн бүлэг, зүйл дэх гэмт хэргийг өмнөх ангиллуудад бүгдийг дүйцүүлсэн учраас тухайн ангиллын “бусад гэмт хэрэг”-т хамаарах ангиллыг дүйцүүлэх гэмт хэрэг байхгүй байна. Бусад гэмт хэргийг дүйцүүлэх ангилал нь гол төлөв хамгийн сүүлийн орон нь 9 гэсэн цифрээр төгссөн байдаг.

ГХСОУА-ын 03 ангиллын нэр томъёог НҮБ-ын орчуулгын дагуу ойлгож, хэрэглэхэд хүндрэл үүсэхээргүй байгаа хэдий ч 03 ангиллын хувьд ЭХ-ийн 12.1 дүгээр зүйлийн нэрээр буюу “Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг” гэж нэрлэх нь уг ангилалд гэмт хэргийг дүйцүүлэн нөхөх этгээдэд илүү ойлгомжтой, тодорхой нөхцөлийг бүрдүүлж өгнө гэж үзэж байна.

ДҮГНЭЛТ

Улсын Их Хурлын 2017 оны 38 дугаар тогтоолоор “Монгол Улсын статистикийн салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг баталж, тус хөтөлбөрийн 2.6.1.11-д “гэмт хэргийн олон улсын ангиллыг үндэсний онцлогт тохируулан боловсруулж, мөрдүүлэх” заалт тусгагджээ. Энэ ажилд хуулийн салбарын судлаач, мэргэжилтнүүд идэвх санаачилгатай оролцох нь ажлын чанар, үр дүнд чухал нөлөөтэй.

ГХСОУА-ын гарын авлагад ГХСОУА болон гэмт хэргийн үндэсний ангиллыг хооронд нь нийцүүлж, уялдуулсан хүснэгтүүд нэмэр болох⁴¹ талаар дурдсан бөгөөд энэ удаагийн судалгаанд ГХСОУА-ын 1-р түвшний эхний гурван ангиллын хүрээнд дүйцүүлэх хувилбар бүхий хүснэгтийг судалгааны тайлангийн хавсралтад харууллаа.

Судалгааны явцад хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагаас гаргаж буй гэмт хэргийн статистикийн мэдээллийн агуулгад шинжилгээ хийхэд ЭХ-ийн системчлэл, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үр дүнг харуулах зорилгоор тухайн статистик үзүүлэлтүүдийг боловсруулсан дүр зураг ажиглагдаж байна. Энэ нь зарим талаар гэмт хэргийн статистик мэдээллийн эрэлт хэрэгцээг хангах хэдий ч гэмт хэргийн статистикт олон өнцгөөс дүн шинжилгээ хийх, дэлхийн бусад улсуудтай өөрсдийн мэдээллийг харьцуулан судлах эрэлт хэрэгцээг хангаж чадахааргүй байна.

Мөн гэмт хэргийн аливаа тоон мэдээлэл нь түүнийг бий болгох болсон хэрэгцээ, шаардлага, зорилгоосоо хамаараад ямар үзүүлэлтээр боловсруулагдах, тэдгээр тоон мэдээллээс ямар

⁴¹ Гэмт хэргийн статистикийн олон улсын ангилал (ГХСОУА). Хувилбар 1.0. 2015 оны 3 дугаар сар. НҮБ-ын гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газар (НҮБ-ын ГХМБТГ)-аас боловсруулав. Үндсэн баримт бичгийг хөрвүүлсэн НҮБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газар. 22 дахь тал.

шалгуурын дагуу аль үзүүлэлтийг статистик болгон боловсруулах вэ гэдэг нь туйлын чухал болохыг ажигласан ба МУ дахь гэмт хэргийн статистик үзүүлэлтийн зорилго нь байгууллага бүр дэх Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа (ЭХХША)-ны үе шатанд хамаарах үйл ажиллагааны мэдээлэл авах, түүнийгээ ашиглах байдлаар ойлгогдож байна. Харин бидэнд энэ зорилгын дагуу боловсруулагдаж буй мэдээллээс гадна Үндэсний хэмжээнд гэмт хэргийн статистикийг гэмт хэргийн нөхцөл, шалтгаан, гэмт хэрэг-хохирогч, хохирлын болон хохирогч-холбогдогчийн харилцан хамаарал зэрэг олон төрлийн хүчин зүйлээр нь дамжуулан тодорхойлох, мэдээллээ олон улсад харьцуулагдах боломжийг бүрдүүлэх, гарсан үр дүнг бодлого шийдвэртээ ашигладаг байх гэсэн шинэ төрлийн зорилгын дагуу давхар боловсруулах хэрэгцээ, шаардлага тулгарч байна.

ГХСОУ-ын 1-р түвшний 01-03 дугаар ангилал, түүний задаргаа ангилал нэг бүрд дүйцүүлсэн МУ-ын ЭХ дахь гэмт хэрэг, үйлдлээс “бүрэн хэмжээнд” дүйцэх боломжтой байгаа ангилал, түүний агуулгад хамаарах олон улсын судалгааны үзүүлэлтийг энэхүү судалгааны тайланд дурдагдсан бүрэн хэмжээнд дүйцэж байгаа гэмт хэргийн тоогоор шууд нөхөх боломжтой байна.

Харин хохирогч-холбогдогчийн хоорондын хамаарал зэрэг гэмт хэргийн тоогоор нөхөх боломжгүй бусад үзүүлэлтийн хувьд эдгээр үзүүлэлтийн агуулгад хамаарах мэдээллийг гэмт хэргийн статистикийн өнөөгийн үзүүлэлтүүдийг боловсронгуй болгох замаар шийдвэрлэх боломж бас байна.

Мөн ГХСОУ-ын 01-03 дугаар ангилал, түүний задаргаа ангилал нэг бүрд дүйцүүлсэн МУ-ын ЭХ дахь гэмт хэрэг, үйлдлээс “зарим хэсгээр” дүйцэх боломжтой ангилал, түүний агуулгад хамаарах олон улсын судалгааны үзүүлэлтийг нөхөх, судалгааг гарган хүргүүлэх асуудлыг мөн л гэмт хэргийн статистикийн өнөөгийн үзүүлэлтүүдийг боловсронгуй болгох замаар шийдвэрлэх боломжтой.

ГХСОУА-ыг НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан нэр томъёог ангиллын агуулга болон дүйцүүлэн нөхөж буй гэмт хэргийн агуулгад уялдуулан судлах нь практик ач холбогдолтой гэж үзэж байна. ГХСОУА-ыг сонирхон судлагч, албан ажлын шаардлагаар уг ангиллын дагуу судалгаа хүргүүлэх, мэдээлэл нөхөх алба хаагчдад хамгийн эхэнд тулгарах асуудал энэ байх тул ГХСОУ-ын аль ангилал нь МУ-ын ЭХ-ийн аль зүйл, хэсэг, заалт, үйлдэлтэй дүйцэж байгаа талаарх арга зүй, заавар шаардлагатай байна.

Дээр дурдсанчлан, ГХСОУА болон МУ-ын ЭХ-ийн шинэчлэл, нэмэлт өөрчлөлтийн асуудал болоод нэг гэмт хэрэг, түүний үйлдэл нь ижил түвшний ангилалд давхцахгүй байх, нийт 11 төрлийн ангиллыг дүйцүүлэн судлах ажил хийгдэж дууссаны дараа ангилал хооронд шилжих гэмт хэрэг, түүнд хамаарах үйлдэл гарч болзошгүй зэрэг асуудлаас шалтгаалан судалгааны багийн зүгээс ГХСОУА-ын агуулгын дагуу боловсруулсан МУ-ын ЭХ дахь гэмт хэрэг, түүний үйлдлийг харуулах схем (зураглал)-ийг боловсруулж гаргах боломжтой. Тэрхүү схемийг дээрх шинэчлэл, нэмэлт өөрчлөлтийн үед болон хураангуй хэлбэрээр хөдөлгөөнийг урьдчилан тооцоолох, дагаж мөрдөх журмын тухай хууль тогтоомж боловсруулахаас авхуулаад бусад дагалдах ажлыг урьдчилан боловсруулах, төлөвлөх зэрэгт ашиглах боломж бүрдэнэ гэж үзэж байна.

Эцэст нь тэмдэглэн хэлэхэд, МУ нь НҮБ-ын гишүүн орны хувьд олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, олон улсын судалгааг цаг алдалгүй, үнэн зөв гаргаж хүргүүлэх, олон улсын стандарт, арга зүйд нийцсэн үзүүлэлтийн дагуу гарган авсан судалгааны бодит үр дүнг бодлого тодорхойлж, шийдвэр гаргахдаа харгалзан үзэх, ашиглах явдлаас хойш суулгүй, олон улсын түвшинд харьцуулагдах мэдээллээ цаг тухайд нь боловсруулан гаргах, хөгжил, өөрчлөлтөөс хоцрохгүй зэрэгцэн оршихоос өөр арга байхгүй гэдгийг анхаарах нь чухал юм.

ГХСОУА-ын 1-р түвшний 01 ангилал нь дотроо 14 ангиллыг багтаасан бөгөөд ЭХ-д заасан Хүний амь нас хохирсон, эсвэл хохирох гэмт хэрэгт завдсан тохиолдлуудыг хамруулах агуулгатай гэм буруу, үйлдэл болон үр дагаврын ялгамжтай байдлыг шалгуур болгон санаатайгаар хүний амь насыг хохироох, энэ гэмт хэрэгт завдах, болгоомжгүйгээр хохироох, үүн дотроо хөнгөмсгөөр найдах, хайхрамжгүйгээр хандах, мөн хүнийг амиа хорлоход туслах, ийм үр дагаварт хүргэх, эдгэшгүй өвчин туссан хүнийг үхүүлэх, зэвсэгт мөргөлдөөний улмаас хүний амь нас хохирсон, хууль бусаар үр хөндсөн, амь насыг хохироосон эсвэл хохироохыг завдсан бусад гэмт хэрэг гэж төрөлжүүлэн ангилсан.

ГХСОУ-ын 1-р түвшний 02 дугаар ангилал нь ижил түвшний бусад ангилалтайгаа харьцуулахад өөртөө хамгийн олон задаргаа ангиллыг багтаасан том хэмжээний ангилал гэдгээрээ онцлогтой бөгөөд үүнийгээ дагаад ЭХ-ийн олон бүлэг, зүйл, хэсэгт хамаарах гэмт хэрэг, үйлдлүүд 02 дугаар ангилалд дүйцэх боломжтой байна. Ерөнхий агуулгаараа хүний бие махбодод гэмтэл, хохирол учруулсан болон сэтгэл санаанд хохирол учруулах үйлдлийг хамааруулсан байна. Түүний агуулгаас үзэхэд бодит хохирол учруулсан болон учруулаагүй хэмээн ангилж болох ба үйлдлийн аргаар нь заналхийлэх үйлдлийг авч үзсэн байна. Эрүүгийн эрх зүйд үйлдэл нь гэмт санааны төрөл болоод үйлдлийг хийж байгаа аргаараа ялгагдаж байдаг ба уг ангилал ч мөн дээрх системийн дагуу дараалалд оржээ. 02 дугаар ангиллын гэмт хэргийг үйлдлийн төгсгөлд бий болж байгаа үр дүнгээр ангилах боломжгүй. Учир нь 02 дугаар ангиллын дийлэнх гэмт хэрэг нь хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг байна. Иймд ГХСОУ-ын нийт 11 төрлийн ангиллыг нэг мөр дүйцүүлэх ажил хийгдэж дуссаны дараа 02 дугаар ангиллын дүйцүүлэх агуулгад тодорхой хэмжээнд засвар, өөрчлөлт орохыг үгүйсгэхгүй юм.

ГХСОУ-ын 1-р түвшний 03 дугаар ангилал нь дотроо 20 ангиллыг багтаасан бөгөөд эдгээрийг бүхэлд нь судлан үзэхэд ЭХ-д заасан Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг

гэмт хэргийг хамруулсан агуулгатай. Энэ ангилалд анхаарал татсан зүйл бол ЭХ-ийн 12 дугаар бүлгээс гадна Хүүхдийн садар самуун бүхий дүрс бичлэгт хамаарах гэмт хэрэг, мөн Бэлгийн дарамт учруулах гэмт хэрэг 03 ангилалд тус тус багтаж болохоор байна. 03 дугаар ангиллын доторх 20 ангилал нь 3 болон 4-р түвшний ангиллыг нэлээд хэмжээгээр багтаасан байх тул Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт хамаарах зарим үйлдэл, үр дагавар, хэм хэмжээний тодорхой нөхцөлийг тусгайлан ангилал болгон боловсруулж, түүнийг илэрхийлэх тоон мэдээллийг нөхүүлж, судалгааны эргэлтэд оруулдаг болох нь тодорхой байна. 03 ангиллыг 01 ангилалтай харьцуулахад зөвхөн төгссөн гэмт хэрэгтэй дүйцүүлж, түүнийг нөхөхөөр байх бөгөөд задаргаа ангиллын агуулгаас харахад бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг, бусад төрлийн бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг гэж ангилсан байна. Бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийг дотор нь хүчиндэх гэмт хэрэг гэж задлаад үүнийгээ хүч хэрэглэн хүчиндэх, хүч хэрэглэхгүйгээр хүчиндэх, насанд хүрээгүй хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг гэж төрөлжүүлсэн бөгөөд энэ ангилалд зарим хэсгээр дүйцүүлэх гэмт хэргүүд гарч байх тул энэ ангиллын дагуу авагдаж буй олон улсын судалгаа нь мөн л шууд нөхөгдөх боломжгүй, нэмэлт мэдээлэл заавал шаардагдахаар байна. ГХСОУА-ын 03 дугаар ангилал дахь НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан нэр томъёог ангиллын агуулга болон дүйцүүлэн нөхөж буй гэмт хэргийн агуулгад уялдуулан судлахад ихэнх ангиллын нэр томъёог орчуулгын дагуу ойлгож, хэрэглэхэд хүндрэл үүсэхээргүй байна.

Ангилал бүрд хамаарах дээрх дүгнэлтээс гадна дараах нэгдсэн дүгнэлтийг 01-03 дугаар ангиллын хүрээнд мөн хийж болохоор байна. Тухайлбал, Практикаас харахад 01 дүгээр ангиллын хувьд бүрэн хэмжээнд эсхүл зарим хэсгээр дүйцэх гэмт хэргүүд байна. Бүрэн хэмжээнд дүйцэж буй хэргүүдийн хувьд ангиллын дагуу мэдээллийг гарган хүргүүлэх боломжтой бол зарим хэсгээр дүйцүүлсэн гэмт хэргүүдийн хувьд тоон мэдээлэл бэлэн биш тул нэмэлт мэдээлэл шаардагдахаар байна.

Үүний зэрэгцээ нийт ангилал дотор нөхөх боломжгүй ангиллууд байх бөгөөд энэ нь ЭХ-д гэмт хэрэгт тооцоогүй үйлдэл, эсхүл тухайн ангиллыг хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын хүрээнд хэлэлцэж байж нэг мөр ойлголтод хүрэх замаар гэмт хэргийг түүнд дүйцүүлэх эсэхийг шийдэх шаардлагаас үүдэлтэй юм.

ГХСОУА-ыг НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан нэр томьёог ангиллын агуулга болон дүйцүүлэн нөхөж буй гэмт хэргийн агуулгатай уялдуулан судлах нь практик ач холбогдолтой гэж үзэж байна. Учир нь, албан ажлын шаардлагаар уг ангиллын дагуу судалгаа хүргүүлэх, мэдээлэл нөхөх алба хаагчдад хамгийн эхэнд тулгарч буй бэрхшээл бол нэр томьёоны асуудал юм. Монгол хэл рүү хөрвүүлсэн нэр томьёо нь эрүүгийн эрх зүйн тогтолцоонд хэрэглэгдэж буй нэр томьёотой дүйцээгүй, тухайн гэмт хэргийн үндсэн шинжийг онож томьёолоогүйн улмаас тухайн мэдээллийг гаргах үүрэгтэй алба хаагчдад ойлгомжгүй, тодорхойгүй байдал үүсгэж, нөхөх боломжтой мэдээллийг ч нөхөхгүй байх үр дагаварт хүргэж байна.

Хэдийгээр бидэнд зарим ангилалд шууд дүйцүүлэх, тэдгээрийг нөхөх, холбогдох судалгааны үзүүлэлтийг нөхөх боломж одоогоор байхгүй ч ГХСОУА-ыг хэрэгжүүлэх, нэвтрүүлэх ажлыг тодорхой үе шаттайгаар хэрэгжүүлбэл дүйцүүлэх хувилбар болон ОУ-ын судалгаа гаргах ажлын чанар, үр дүнг нэмэгдүүлэх боломж байгааг цаашид анхаарах нь зүйтэй. ГХСОУ-ын 01-03 ангилал дотор нөхөх боломжгүй байгаа ангиллууд байгаа нь ЭХ-д гэмт хэрэгт тооцоогүй үйлдлүүд болон одоогоор шууд тодорхойлох боломжгүй буюу нэр томьёо, агуулгын хувьд тодорхойгүй, эргэлзээтэй цаашид хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагуудын хүрээнд хэлэлцэж байж нэгдсэн шийдэлд хүрэх ангиллууд байгаатай шууд холбоотой байх тул энэ чиглэлээр хийх ажилд хуулийн байгууллагуудыг өргөнөөр оролцуулах, ажлын үр дүнг талуудаар хэлэлцүүлэх нь чухал юм. Тиймээс судалгааны хүрээнд 01-03 дугаар ангиллын нэр томьёог нэг мөр ойлгоход хувь нэмэр оруулах

үүднээс санал дэвшүүлсэн бөгөөд энэ нь судалгаанд оролцогч талуудын зүгээс үзүүлэлтүүдийг нэгдсэн арга зүйгээр ойлгож, тодорхойлох асуудалд эерэг нөлөө үзүүлнэ хэмээн найдаж байна.

Мөн ГХСОУА өөрөө шинэчлэгдэх, эсвэл МУ-ын ЭХ-д өөрчлөлт орох гэх зэрэг тохиолдолд судалгааны ажлын тайланд дурдагдсан дүйцүүлэх хувилбарууд мөн өөрчлөгдөх ба 11 төрлийн бүх ангиллыг дүйцүүлэх судалгааны ажил хийгдэж дууссаны дараа эдгээр ангилал хооронд шилжих гэмт хэрэг, үйлдэл гарах боломжтой байгааг мөн анхаарах шаардлагатай. ГХСОУА-ын өөрийн агуулгаас харахад тухайн улсын гэмт хэргийг 11 төрлийн ангиллын аль нэгэнд заавал хамааруулах зорилгыг агуулсан байх тул ангилал бүрийн хамгийн сүүлийн орон нь 9 гэсэн цифрээр төгссөн ангилалд тухайн төрлийн гэмт хэрэг, үйлдлийн дээр дурдсан ангилалд хамаараагүй үлдсэн хэсгийг дүйцүүлэн нөхүүлэх арга зүйг баримталдаг болох нь харагдаж байна. Үүнээс харахад хамгийн наад зах нь ГХСОУА шинэчлэгдэх, өөрчлөлт орох, эсвэл МУ-ын ЭХ-д өөрчлөлт орох тохиолдолд одоогоор ГХСОУА-ын хамгийн сүүлийн орон нь 9 гэсэн цифрээр төгссөн ангилалд дүйцүүлсэн гэмт хэрэг, үйлдэлд өөрчлөлт орох талтай юм

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

- Судалгааны дүнд 01 дүгээр ангиллыг “Хүний амь нас хохироосон болон хохироохыг завдсан” гэмт хэрэг, 02 дугаар ангиллыг “Хувь хүнд хохирол бий болгох, хохирол учруулах нөхцөлийг бүрдүүлэх” гэмт хэрэг, 03 дугаар ангиллыг “Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг” гэмт хэрэг, түүнд хамаарах үйлдлийн агуулгаар тус тус ойлгон хэрэглэх;
- Гарын авлага болон олон улсын судалгаанд орчуулагдсан зарим нэр томъёог эргэн харах, нэгэнт хууль зүйн салбарт хэвшиж тогтсон нэр томъёог ашиглах байдлаар орчуулгыг сайжруулах замаар ГХСОУА болон олон улсын судалгааны агуулгыг зөв ойлгож, хэрэглэх, бодит үр дүн гаргах асуудалд ахиц гаргах боломжийг бүрдүүлэх;
- Орчуулгыг сайжруулах болон дүйцүүлэх хувилбарын үр дүнгээр хэлэлцүүлэг зохион байгуулж, талуудыг оролцуулан нэгдсэн санал, шийдэлд хүрэх ажлыг зохион байгуулах;
- ГХСОУА-ын агуулга нь нэг гэмт хэрэг, түүний үйлдэл нь ижил түвшний зэрэгцээ ангилалд давхар дүйцэж ангилагдахааргүй байгаа тул ангиллыг судлах, албан ажлын шаардлагаар дүйцүүлэн нөхөх, ангилалд хамаарах олон улсын судалгааг гаргах тохиолдолд үүнийг анхаарах;
- ГХСОУ-ын 1-р түвшний 01-03 дугаар ангилал, түүний задаргаа ангилал нэг бүрд дүйцүүлсэн МУ-ын ЭХ дахь гэмт хэрэг, үйлдлээс “бүрэн хэмжээнд” дүйцэх боломжтой байгаа ангилал, түүний агуулгад хамаарах ОУ-ын судалгааны үзүүлэлтийг судалгааны ажлын үр дүнд гарсан арга зүй, загварыг баримтлан үнэн зөв, гүйцэд нөхөх;

- Харин хохирогч-холбогдогчийн хоорондын хамаарал зэрэг гэмт хэргийн тоогоор нөхөх боломжгүй ОУ-ын судалгааны бусад үзүүлэлтийн хувьд эдгээр үзүүлэлтийн агуулгад хамаарах мэдээллийг гэмт хэргийн статистикийн өнөөгийн үзүүлэлтүүдийг боловсронгуй болгох замаар шийдвэрлэх;
- 11 төрлийн ангиллыг дүйцүүлэн судлах ажил хийгдэж дууссаны дараа ангилал хооронд шилжих гэмт хэрэг, түүнд хамаарах үйлдлийн схем (зураглал)-ийг боловсруулан гаргах.

ХАВСРАЛТ 1

ГХСОУА-ЫН 01 АНГИЛЛЫГ МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ДАХЬ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ДҮЙЦҮҮЛСЭН ХУВИЛБАР

№	Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томъёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томъёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
1	I	01	<p>Хүний аминд хүрсэн болон хүрэхийг завдсан хэрэг. 0101-0107, 0109</p> <p><u>ГХСОУА-д:</u></p> <p>1-р түвшний энэ ангилал нь ГХСОУА-ын нийт 11 төрлийн багц ангиллын хамгийн эхний 01 дугаартай ангилал юм.</p> <p>Хүний амь нас хохирох үр дагавартай томъёологдсон бүх гэмт хэргийн тоог энэ хэсэгт нөхөхөөр ойлгогдож байна.</p> <p>Энэхүү ангиллын агуулгаас харахад гэмт хэргийн улмаас учрах хор уршиг, үр дагаврын хувьд хамгийн хүнд гэмт хэргүүд багтсан байдаг.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u></p> <p>10.1, 10.2.1, 10.3.1, 10.4.1, 10.5.1, 10.6, 11.1.2.5, 12.1.3, 12.1.4, 12.3.3.1, 13.4.4.2, 15.1.3, 15.2.2.2, 15.3.3, 15.4.1, 15.5, 16.2.2, 16.3.2, 16.11.3, 19.3.2, 19.5, 20.6.2, 20.11.2.1, 20.12.2.1, 20.13.1, 20.14.3.1, 20.15.2, 20.16.2.4, 23.5.2, 24.1.2.1, 24.3.2.1, 24.7.3.1, 27.2.1, 27.3.1, 27.6.2, 27.7.3, 27.8.2.3, 27.9.1, 27.10.3, 27.10.4.2, 28.9.2, 28.10.2.2, 28.11.2, 29.5.1, 29.7.2, 29.8.1</p>	<p>Acts leading to death or intending to cause death.</p> <p>1-р түвшний 01 дүгээр ангилал нь дотроо 0101-0107, 0109 гэсэн задаргаа ангиллуудаас бүрддэг. Судалгааны явцад тэдгээр ангилал тус бүрийг ЭХ-ийн холбогдох зүйл, хэсэг, заалттай дүйцүүлэх тайлбарт аль ангиллыг бүрэн хэмжээнд, аль ангиллыг зарим хэсгээр дүйцүүлж байгаа талаар тэмдэглэсэн болно.</p> <p>01 дүгээр түвшний ангилалд хүний амь насыг санаатайгаар хохироохыг завдсан, санаатайгаар, болгоомжгүйгээр, тээврийн хэрэгслээр эсвэл бусад байдлаар, мөн эдгэшгүй хүнд өвчтэй хүнийг үхүүлэх, амиа хорлоход туслах, хүргэх гэсэн агуулгаар хүний амь насыг хохироох гэмт хэргүүд бүгд хамаарч байна.</p> <p>Энэ ангилалд ЭХ-ийн хэд хэдэн бүлэг түүнд холбогдох зүйл, хэсэг, заалт хамаарч байгаагаараа анхаарал татаж байна.</p> <p>Практикт гэмт хэргийн улмаас амь хохирсон хүний тоо маягтаар гарах боловч гэмт хэргийн тооны нийлбэр дүн нэгтгэгдэн гардаггүй болно.</p> <p><u>Иймд ЭХ-д гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан, амь нас хохирсон үр дагаварт хүргэсэн эсвэл хүргэх үйлдэлд завдсан бүх гэмт хэргийг энэхүү ангилалд дүйцүүлэн нөхөхөөр байна.</u></p>

№	Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томъёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томъёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
			<p><u>ЭХ-ийн дээр дурдсан зүйл, хэсэг, заалтад заасан гэмт хэрэгтэй бүрэн хэмжээнд болон зарим хэсгээр дүйцүүлж болохоор байна.</u></p>	<p>Завдсан гэмт хэргийн хувьд ийнхүү нөхөх асуудал нь үйлдэл төгссөн гэмт хэргээсээ илүү хүндрэлтэй байна. Учир нь практикт завдсан уу, эсвэл үйлдэл төгссөн үү гэдгээр нь ангилж, үзүүлэлт болгон нөхдөггүй. Иймд үзүүлэлтийг тусад нь гаргаж, тоолох замаар ангиллын завдсан агуулгыг гаргах боломж бүрдэхээр байна.</p> <p>Нэр томъёоны хувьд Хүний амь нас хохироосон болон хохироохыг завдсан гэх нэршлээр ойлгож, хэрэглэх нь зохистой.</p>
2	II	0101	<p>Санаатай аллага.</p> <p><u>ГХСОУА-д:</u></p> <p>Гэмт хэргийн улмаас хүний амь нас хохирсон үр дагаварт хүргэсэн аливаа гэмт хэргийг энэ ангилалд хамааруулах агуулгатай байна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u></p> <p>10.1 дүгээр зүйл. Хүнийг алах (10.1.1, 10.1.2)</p> <p>10.2 дугаар зүйл. Санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүнийг алах (10.2.1)</p> <p>10.3 дугаар зүйл. Баривчлах, таслан зогсоох хэр хэмжээг хэтрүүлж хүнийг алах (10.3.1)</p> <p>10.4 дүгээр зүйл. Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх (10.4.1)</p> <p>10.5 дугаар зүйл. Эх нярай хүүхдээ алах (10.5.1)</p> <p>19.3 дугаар зүйл. Төрийн өндөр албан тушаалтны амь биед халдах (19.3.2)</p>	<p>Intentional homicide.</p> <p>Энэ ангиллын агуулгаас харахад завдах болон болгоомжгүйгээр хүний амь нас хохироох үйлдлээс бусад тохиолдолд хүний амь нас хохироосон гэмт хэргүүд хамаарахаар байна.</p> <p><u>ЭХ-ийн 10.1, 10.2.1, 10.3.1, 10.4.1, 10.5.1, 19.3.2-т заасан гэмт хэргүүдийг бүрэн хэмжээнд, харин ЭХ-ийн 29.5.1, 29.7.2, 29.8.1-д заасан гэмт хэргээс зөвхөн доор дурдсан үйлдэл, үр дагаварт хамаарах хэсгийг дүйцүүлэн нөхөх боломжтой байна.</u></p> <p>Харин ЭХ-ийн 29.5.1-д заасан зөвхөн “Үндэс, угсаа, арьсны өнгө, шашны тодорхой бүлгийг устгах зорилгоор хүнийг алсан, төрөлтийг хүчээр зогсоосон”, 29.7.2-т заасан зөвхөн “Энэ гэмт хэргийг үйлдэхдээ олон улсын хамгаалалтад байдаг хүнийг алсан”, 29.8.1-д заасан зөвхөн “Төр, олон улсын байгууллагаас тодорхой шийдвэр гаргуулах, гаргасан шийдвэрийг өөрчлүүлэх, шийдвэр гаргахаас татгалзуулах зорилгоор галт зэвсэг, тэсэрч</p>

№	Хамаарах түүвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томъёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томъёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
			<p>29.5 дугаар зүйл. Төрлөөр устгах (29.5.1)</p> <p>29.7 дугаар зүйл. Олон улсын хамгаалалтад байдаг хүнд халдах (29.7.2)</p> <p>29.8 дугаар зүйл. Террор үйлдэх (29.8.1)</p> <p><u>ЭХ-ийн дээр дурдсан зүйл, хэсэгт заасан гэмт хэрэгтэй дүйцүүлж болохоор байна.</u></p> <p>Харин амь хохирсон, нас барсан үр дагавраас бусад үр дагавар болон үйлд энэ ангилалд хамаарахгүй байна. Гол шинж болох “амь хохирсон байх”-ыг анхаарах шаардлагатай.</p>	<p>дэлбэрэх, цөмийн бодис, цацраг идэвхт хаягдал, хими, биологийн хортой, аюултай бодис, цахим сүлжээ, техник хэрэгсэл, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйлийг ашиглаж, ашиглахаар заналхийлж хүнийг алсан” үйлдэлд хамаарах гэмт хэргүүдийг тусад нь үзүүлэлт болгон тоолж байж энэ ангиллыг дүйцүүлэн нөхөх боломжтой болно.</p> <p>Нэр томъёоны хувьд Хүний амь насыг санаатайгаар хохироох гэх нэршлээр ойлгож, хэрэглэх нь илүү зохистой.</p>
3	II	0102	<p>Санаатай аллага үйлдэхээр завдах.</p> <p><u>ГХСОУА-д:</u></p> <p>Санаатай аллага гэсэн хэсэгт хамаарч буй бүх гэмт хэрэг энд мөн хамаарах бөгөөд тэдгээр гэмт хэрэгт завдсан тоог энэ хэсэгт нөхөхөөр ойлгогдож байна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u></p> <p>0101 ангилалд дүйцүүлсэн МУ-ын ЭХ-ийн холбогдох зүйл, хэсэг мөн энд хамаарна.</p> <p>Харин гол шинж нь “үйлдэл төгсөөгүй завдсан байх”-ыг анхаарах шаардлагатай.</p>	<p>Attempted intentional homicide.</p> <p>Энэ ангиллын агуулгаас харахад Хүний амь насыг санаатайгаар хохироох гэмт хэрэгт завдсан тохиолдлыг тусад нь тоолж дүйцүүлэн нөхөх шаардлагатай байна.</p> <p>Практикт гэмт хэргийн улмаас амь хохирсон хүний тоо гарах хэдий ч зөвхөн амь хохирсон гэмт хэргийн тооны нийлбэр дүн мөн тэр дүн нь үйлдэл төгссөн, эсвэл завдсан гэдгээрээ тусдаа гардаггүй болно. Иймд маягтад тусад нь үзүүлэлт болгон нөхөх замаар энэхүү мэдээлэл гарах боломж бүрдэх юм.</p> <p>Харин нэр томъёоны хувьд Хүний амь насыг санаатайгаар хохироох гэмт хэрэгт завдсан гэх нэршлээр ойлгож, хэрэглэх нь илүү зохистой байна.</p>

№	Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НУБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томъёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томъёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
4	II	0103	<p>Санамсаргүй аллага. 01031, 01032, 01034, 01039</p> <p><u>ГХСОУА-д:</u></p> <p>Санамсаргүй үйлдсэн хүн амины хэрэг, аюултай байдлаар жолоо барьснаас хүний аминд хүрсэн⁴² гэмт хэрэг хамаарахаар ойлгогдож байна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u></p> <p>10.6 дугаар зүйл.</p> <p>11.1 дүгээр зүйл. 11.1.2.5</p> <p>12.1 дүгээр зүйл. 12.1.4</p> <p>13.4 дүгээр зүйл. 13.4.4.2</p> <p>15.3 дугаар зүйл. 15.3.3</p> <p>15.4 дүгээр зүйл. 15.4.1</p> <p>15.5 дугаар зүйл. 15.5.3</p> <p>16.2 дугаар зүйл. 16.2.2</p> <p>16.3 дугаар зүйл. 16.3.2</p> <p>16.11 дүгээр зүйл. 16.11.3</p> <p>20.6 дугаар зүйл. 20.6.2</p> <p>20.15 дугаар зүйл. 20.15.2</p> <p>28.9 дүгээр зүйл. 28.9.2</p> <p>28.10 дугаар зүйл. 28.10.2.2</p> <p>28.11 дүгээр зүйл. 28.11.2</p> <p>20.11 дүгээр зүйл. 20.11.2.1</p> <p>20.12 дугаар зүйл. 20.12.2.1</p> <p>20.13 дугаар зүйл. 20.13.1</p> <p>20.14 дүгээр зүйл. 20.14.3.1</p> <p>20.16 дугаар зүйл. 20.16.2.4</p> <p>23.5 дугаар зүйл. 23.5.2</p> <p>24.1 дүгээр зүйл. 24.1.2.1</p> <p>24.3 дугаар зүйл. 24.3.2.1</p> <p>24.7 дугаар зүйл. 24.7.3.1</p> <p>27.2 дугаар зүйл. 27.2.1</p> <p>27.3 дугаар зүйл. 27.3.1</p> <p>27.6 дугаар зүйл. 27.6.2</p> <p>27.7 дугаар зүйл. 27.7.3</p> <p>27.8 дугаар зүйл. 27.8.2.3</p> <p>27.9 дүгээр зүйл. 27.9.1</p> <p>27.10 дугаар зүйл. 27.10.3, 27.10.4.2</p>	<p>Non-intentional homicide.</p> <p>Энэ ангиллын агуулгаас харахад гэм буруугийн болгоомжгүй хэлбэрээр үйлдэгдсэн Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох болон гэмт хэрэгтээ гэм буруугийн санаатай хэлбэрээр хандсан боловч хор уршигт болгоомжгүй хэлбэрээр хандсан гэмт хэргүүд мөн хамаарахаар байна. Учир нь эдгээр гэмт хэргийг энэ ангилалд хамааруулахгүй бол 02-11 хүртэлх бусад ангилалд хүний амь нас хохирсон үр дагавартай эдгээр гэмт хэргүүдийн тоо нөхөгдөхөөргүй байна.</p> <p>Маягтаар эдгээр гэмт хэргийн улмаас нас барсан тохиолдол нь “амь хохирсон” гэх үзүүлэлтээр ЭХ-ийн зүйл, хэсэг заалтаараа тус тусдаа гарна. <u>Иймд эдгээрийн дүнг нэгтгэх замаар нэгтгэлийг нь хийж байж 0103 ангиллын нийт дүнг дүйцүүлэн нөхөх боломжтой.</u></p> <p>Харин эдгээр гэмт хэргүүдийг хөнгөмсгөөр найдсан, эсвэл хайхрамжгүй хандсан гэсэн ангилалд ялгахын тулд практикийг сайтар судлах шаардлагатай. Үйлдэлдээ санаатай хор уршигт болгоомжгүйгээр хандсан тохиолдлыг дахин нарийвчилж ангилахад хүндрэлтэй байна.</p> <p><u>ЭХ-ийн 10.6, 11.1.2.5, 15.5.3, 16.11.3, 27.10.3, 27.10.4.2, 28.9.2-г заасан гэмт хэргийг бүрэн хэмжээнд, доор дурдсан гэмт хэргийг зөвхөн “хохилогч нас барсан”, “хүний амь нас хохирсон” үр дагаварт хамаарах хэсгээр дүйцүүлэн нөхөхөөр байна.</u></p>

⁴² ICCS_English_2016_web.pdf. p 33

Хавсралт 1-ийн үргэлжлэл

№ Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томъёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томъёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
		<p>ЭХ-ийн дээр дурдсан зүйлд холбогдох хэсэг, заалттай энэхүү ангиллыг дүйцүүлэх боломжтой.</p>	<p>ЭХ-ийн 12.1.4, 13.4.4.2, 15.3.3, 15.4.1, 16.2.2, 16.3.2, 20.6.2, 20.15.2, 28.10.2.2, 28.11.2 дугаар хэсэгт заасан зөвхөн “хохирогч нас барсан” үр дагавар, харин 20.11.2.1, 20.12.2.1, 20.13.1, 20.14.3.1, 20.16.2.4, 23.5.2, 24.1.2.1, 24.3.2.1, 24.7.3.1, 27.2.1, 27.3.1, 27.6.2, 27.7.3, 27.8.2.3, 27.9.1 дүгээр хэсэг, заалтад заасан зөвхөн “амь нас хохирсон” үр дагаварт хамаарах тохиолдлууд энэ ангилалд хамаарахаар байна.</p> <p>Нэр томъёоны хувьд Хүний амь нас хохирсон бусад гэмт хэрэг гэх нэршлээр ойлгож, хэрэглэх нь илүү зохистой.</p>
5	III 01031	<p>Хайхрамжгүй бус байдлаар үйлдсэн хүн амины хэрэг. <u>ГХСОУА-д:</u> Үхэлд хүргэх, эсвэл ноцтой гэмтэл учруулах зорилгогүй, ерөнхийдөө гэмтээж хохироох зорилготой боловч хүний аминд хууль бусаар хүрсэн үйлдлийг⁴³ ойлгохоор байна.</p>	<p>Non-negligent manslaughter. Хөнгөмсгөөр найдсаны улмаас хүний амь нас хохирсон гэх томъёоллоор хэрэглэх нь зүйтэй. Агуулга нь ЭХ-ийн 2.3.3-т заасан “Өөрийн үйлдэл, эс үйлдэхгүйг хууль бус шинжтэй болохыг ухамсарлаж түүний улмаас хохирол, хор уршиг учрах боломжтойг урьдчилан мэдэж түүнийг гаргахгүй байж чадна гэж тооцсон боловч хохирол, хор уршиг учирсан” байх юм.</p> <p>Орчуулгын “хайхрамжгүй бус байдлаар” гэсэн хэсэг нь ойлгомжгүй байна. Иймд “хөнгөмсгөөр найдах” гэх нэршлээр ойлгож, хэрэглэх нь илүү зохистой. Маягтаар гарахгүй.</p>

⁴³ Ibid, p 34

№	Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томъёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томъёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
6	III	01032	<p>Хайхрамжгүйгээс санамсаргүй үйлдсэн хүн амины хэрэг.</p> <p><u>ГХСОУА-д:</u></p> <p>Хохирогчийн эсрэг санаатайгаар чиглээгүй, хайхрамжгүй буюу санамсаргүй үйлдлийн улмаас хүний аминд хүрэхийг⁴⁴ ойлгохоор байна.</p>	<p>Negligent manslaughter.</p> <p>Хайхрамжгүй хандах гэж үзэх юм бол 0103-т нийт болгоомжгүй үйлдсэн энэ төрлийн гэмт хэргийн тоог, түүнээс 01031 болон 01032-т тус тус хамаарах тоог ялгаж тоолж гаргасан тохиолдолд нөхөх боломжтой.</p> <p>Агуулга нь ЭХ-ийн 2.3.3-т заасан “хохирол, хор уршиг учрах боломжтойг урьдчилан мэдэх ёстой, мэдэх боломжтой байсан боловч мэдэлгүй үйлдсэний улмаас хохирол, хор уршиг учирсан” байх юм.</p> <p>Хайхрамжгүй хандсаны улмаас хүний амь нас хохирсон гэх нэршлээр ойлгож, хэрэглэх нь зохистой.</p>
7	IV	010321	<p>Тээврийн хэрэгслээр хүний амь хороох.</p> <p><u>ГХСОУА-д:</u></p> <p>Аллага, нэр төрийн аллага, үхэлд хүргэсэн ноцтой халдлага, террорист үйл ажиллагаатай холбоотой үхэл, инжтэй холбоотой аллага, эмэгтэй хүнийг алах аллага, нялхсын аллага, санамсаргүй үйлдсэн хүн амины хэрэг, шүүн таслах ажиллагааны гадуурх аллага, хууль сахиулах ажилтан, төрийн албан хаагчийн хүч хэтрүүлэн хэрэглэснээс үүдсэн аллага зэргийг хамааруулж ойлгохоор агуулгатай байна.</p>	<p>Vehicular homicide.</p> <p>Энэхүү ангиллын агуулгыг судлан үзэхэд нэр томъёоны хувьд НҮБ-аас орчуулсан хувилбар нь Хүн амины гэмт хэрэг мэтээр ойлгогдох талтай байна. Ангилалд дурдсан гэмт хэрэг нь хүн амины гэмт хэргийг үйлдэхдээ тээврийн хэрэгсэл ашигласан гэмт хэргээс ялгаатай тул тээврийн хэрэгсэл жолоодож явахдаа хүний амь нас хохироосон агуулгаар нь нэр томъёог буулгах нь дүйцүүлэн нөхөх ажлыг хариуцсан алба хаагчид болон ГХСОУА-ыг сонирхон судлагч нарт илүү оновчтой хийгээд агуулгын хувьд зөв ойлгож хэрэглэх боломжийг бүрдүүлэхээр байна.</p>

⁴⁴ Ibid, p 34

Хавсралт 1-ийн үргэлжлэл

№	Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томъёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томъёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
			<p><u>МУ-ын ЭХ-д:</u></p> <p>27.10 дугаар зүйл. Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих</p> <p>27.10.3. Энэ гэмт хэргийн улмаас хүний амь нас хохирсон</p> <p>27.10.4.2. Энэ гэмт хэргийн улмаас хоёр, түүнээс олон хүний амь нас хохирсон</p> <p>ЭХ-ийн 27.10.3 дугаар хэсэг болон 27.10.4.2 дахь заалтад заасан гэмт хэрэгт дүйцүүлэх боломжтой байна.</p>	<p>Иймд Тээврийн хэрэгслийн улмаас хүний амь нас хохирсон гэх нэршлээр ойлгож, хэрэглэх нь зохистой.</p> <p><u>ЭХ-ийн 27.10.3, 27.10.4-т заасан гэмт хэргийн нийлбэр дүнг энэ хэсэгт дүйцүүлэн нөхөхөөр байна.</u></p>
8	IV 010322	<p>Тээврийн хэрэгслийн оролцоогүй хүний амь хороох.</p> <p><u>ГХСОУА-д:</u></p> <p>Энэ ангилал нь 01032-т хамаарах 010321-д тоологдсоноос бусад тохиолдлыг тоолох агуулгатай байна.</p> <p>Ингэхдээ болгоомжгүй үйлдэгдсэн гэмт хэрэг буюу Хайхрамжгүй хандсаны улмаас хүний амь нас хохирсон тохиолдлуудыг тоолж гаргах агуулгатайгаар ойлгогдож байна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u></p> <p>20.6 дугаар зүйл. Галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрг дэлбэрэх бодис хамгаалахад хайнга хандах</p> <p>20.6.2. Энэ гэмт хэргийн улмаас хүний эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, хохилогч нас барсан</p>	<p>Non-vehicular homicide</p> <p>Энэ ангиллын агуулга нь 01032-т заасан Хайхрамжгүй хандсаны улмаас хүний амь нас хохирсон гэмт хэргээс Тээврийн хэрэгслийн улмаас хүний амь нас хохирсон гэмт хэргийг хасаад үлдсэн тохиолдлыг энэ ангилалд хамааруулж гаргах байдлаар ойлгогдож байна. Иймд Тээврийн хэрэгслийн улмаас хүний амь нас хохирсноос бусад байдлаар хүний амь нас хохирсон гэмт хэрэг гэх нэршлээр ойлгож, хэрэглэх нь зохистой байна.</p> <p><u>ЭХ-ийн 20.6.2 болон 20.15.2-т заасан зөвхөн “хохилогч нас барсан” үр дагаварт хамаарах хэсгийн дүнгээр дүйцүүлэн нөхөхөөр байна.</u></p>	

№	Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томъёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томъёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
			<p>20.15 дугаар зүйл. Орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгах</p> <p>20.15.2. Энэ гэмт хэргийн улмаас хүний эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, хохилогч нас барсан</p> <p>Зөвхөн “Хохирогч нас барсан” гэж хуульчлагдсан гэмт хэргээс тоог нөхөх шаардлага үүсэж байгаа юм. Хэрэв дээр дурдсан ЭХ-ийн 20.6.2, 20.15.2 дахь хэсэг ГХСОУ-ын өөр ангилалд дүйцэхээргүй⁴⁵ бол энэ ангилалд дүйцүүлж болох юм.</p>	
9	II	0104	<p>Амиа хорлоход туслах, өдөөн турхирах бусад үйлдэл.</p> <p><u>ГХСОУА-д:</u> ГХСОУА-ын энэ үзүүлэлт нь амиа хорлоход туслах, эсвэл өдөөн турхирах үйлдэл байна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u> 10.4 дүгээр зүйл. Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх Энэхүү ангиллыг ЭХ-ийн 10.4-т заасан гэмт хэрэгтэй дүйцүүлж болох юм.</p>	<p>Assisting or instigating suicide.</p> <p>ЭХ-д амиа хорлоход хүргэх гэсэн үйлдэл хуульчлагдсан. ГХСОУА-д заасан туслах, эсвэл өдөөн турхирах үйлдэл нь үгийн шууд утгаараа дүйцэхгүй байдлаар уншигдаж байгаа хэдий ч ГХСОУА-ын бусад ангилалд ЭХ-ийн 10.4 дүгээр зүйд заасан гэмт хэрэг нь дүйцэхээргүй бол ГХСОУА-ын энэхүү ангилалд дүйцүүлэх нь агуулгын хувьд хамгийн нийцтэй хувилбар болох юм.</p>

⁴⁵ 01 дүгээр ангиллаас гадна 02-11 гэсэн олон төрлийн ангилал байгаа бөгөөд тэдгээрт энэ ангилалтай ойролцоо агуулга, үр дагавар бүхий ангилал гарахгүй тохиолдолд 1-р түвшний 01 дүгээр ангиллын 010322 дугаар ангилалд ЭХ-ийн 20.6.2, 20.15.2 дахь хэсгүүд хамаарах нь гарцаагүй юм.

Хавсралт 1-ийн үргэлжлэл

№	Хамаарах түүвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томъёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томъёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
10	III	01041	<p>Амиа хорлоход туслах.</p> <p>Үхэх хүсэлтэй хүнийг санаатайгаар үхэхэд нь туслах, эрэгтэй, эмэгтэй хүн өөрийгөө хорлох, хохирооход бусад хүн дэмжлэг үзүүлэх, эсвэл мэдлэг, мэдээллээр хангах, аль аль аргаар нь хангахыг⁴⁶ ойлгохоор байна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u></p> <p>Амиа хорлохтой холбоотойгоор 10.4 дүгээр зүйлээс өөр гэмт хэрэг ЭХ-д хуульчлагдаагүй тул энэ ангилалд нөхөх гэмт хэрэг одоогоор байхгүй.</p>	<p><u>Иймд энэхүү ангилалд ЭХ-ийн 10.4-т заасан гэмт хэргийг дүйцүүлэн нөхөхөөр ойлгогдож байна.</u></p> <p>Амиа хорлоход туслах үйлдэл нь “Эдгэшгүй өвчин туссан хүнийг үхүүлэх” үйлдлээс ялгаатай ойлголт байгааг анхаарах шаардлагатай.</p> <p>Нэр томъёоны хувьд Амиа хорлоход туслах, хүргэх гэх нэршлээр ойлгож, хэрэглэх нь зохистой.</p> <p>Assisting suicide.</p> <p>-</p>

⁴⁶ ICCS_English_2016_web.pdf. p 35

№	Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томъёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томъёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
11	III	01049	<p>Амиа хорлоход туслах, өдөөн турхирах бусад үйлдэл. <u>ГХСОУА-д:</u> Энэ ангиллын агуулга нь 01041-д хамаарах туслах үйлдлээс бусад туслах болон өдөөн турхирах үйлдэл байна. Агуулгыг тодорхой болгох шаардлагатай. МУ-ын ЭХ-д: 10.4 дүгээр зүйл. Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх</p>	<p>Other acts of assisting or instigating suicide. Энэ ангилал нь 0104 дүгээр ангиллын задаргаа 4-р түвшний ангилал юм. Иймд ЭХ-ийн 10.4 дүгээр зүйлд заасан гэмт хэргийг энэ ангилалд дүйцүүлэн нөхөх боломжтой. Нэр томъёоны хувьд Амиа хорлоход туслах болон амиа хорлоход хүргэсэн бусад үйлдэл гэх нэршлээр ойлгож, хэрэглэх нь зохистой.</p>
12	II	0105	<p>Эдгэшгүй өвчин туссан хүнийг үхүүлэх. <u>ГХСОУА-д:</u> Энэ ангиллын агуулга нь эдгэшгүй өвчин туссан болон эрүүл мэндийн хувьд үүнтэй дүйцэхүйц байдалд байгаа хүнийг өвдөлт зовуурьгүйгээр үхүүлэх (унтуулах) үйлдэл байдаг. <u>МУ-ын ЭХ-д:</u> ЭХ-д ийм төрлийн гэмт хэрэг хуульчлагдаагүй тул дүйцүүлэх гэмт хэрэг байхгүй.</p>	<p>Euthanasia. -</p>

№	Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томъёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томъёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
13	II	0106	<p>Хууль бус үр хөндөлт.</p> <p><u>ГХСОУА-д:</u></p> <p>Үндэсний хууль тогтоомжоор хууль бус үр хөндөлтийг үр хөндөлтийн гэмт хэрэг гэж тодорхойлсон, төрөлтийг нуун дарагдуулах, бие махбодыг нууцаар захиран зарцуулах, санаатай зулбалт, амьгүй ураг төрүүлэх, хууль бус үр хөндөлтөөр үйлчлэх, үр хөндөлтийн хууль, тогтоомжийг зөрчин ургийг хөндөх, хүчээр үр хөндөх зэргийг ойлгохоор байна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u></p> <p>15.5 дугаар зүйл. Хууль бусаар үр хөндөх</p> <p><u>ЭХ-ийн 15.5 дугаар зүйлд заасан гэмт хэргээс 15.5.3-т хамаарах хэсгээс бусад хэсэг, заалтад хамаарах гэмт хэрэгтэй энэхүү ангиллыг дүйцүүлэх боломжтой байна.</u></p>	<p>Illegal feticide.</p> <p><u>ЭХ-ийн 15.5 дугаар зүйлийн 15.5.3 дахь хэсгээс бусад хэсэгт заасан гэмт хэрэг буюу 15.5.1, 15.5.2 дахь хэсгийн нийлбэр дүнг дүйцүүлэн нөхөхөөр байна.</u></p> <p>Учир нь 15.5.3 дахь хэсэг нь “хохирогч нас барсан” үр дагавартай бөгөөд ГХСОУА-ын 0103 дугаар ангилалд дүйцсэн тул ижил түвшний 0105 дугаар ангилалд давхар дүйцүүлэх боломжгүй гэдгийг анхаарах шаардлагатай.</p> <p>Нэр томъёоны хувьд ЭХ-д заасан Хууль бусаар үр хөндөх гэх нэршлээр ойлгож, хэрэглэх нь зохистой.</p>
14	II	0107	<p>Зэвсэгт мөргөлдөөнтэй холбоотой хууль бус аллага.</p> <p><u>ГХСОУА-д:</u></p> <p>Энэ ангилал нь Зэвсэгт мөргөлдөөний улмаас хууль бусаар амь үрэгдэх, үхэлд хүрэх агуулгатай байна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u></p> <p>ЭХ-ийн 19.5 дугаар зүйлд “Зэвсэгт үймээн дэгдээх” гэсэн гэмт хэрэг хуульчлагдсан боловч энэ гэмт хэрэгт хохирогч нас барсан, амь хохирсон үр дагавар бүхий гэмт хэрэг хуульчлагдаагүй. <u>Иймд энэ ангиллын хувьд ЭХ-д заасан дүйцүүлэх гэмт хэрэг байхгүй.</u></p>	<p>Unlawful killing associated with armed conflict</p> <p>-</p>

№	Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томъёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томъёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
15	II	0109	<p>Үхэлд хүргэсэн, эсвэл үхэлд хүргэхийг завдсан бусад хэрэг. <u>ГХСОУА-д:</u> Тусламж үзүүлж чадаагүйгээс хүний амь хохирсон тохиолдлуудыг хамааруулах агуулгатай байна. Мөн үйлдэж төгссөн болон завдсан гэмт хэргүүд аль аль нь хамаарахаар ойлгогдож байна. <u>МУ-ын ЭХ-д:</u> 15.1 дүгээр зүйл. Эмнэлгийн тусламж үзүүлэхгүй байх (15.1.3) 15.2 дугаар зүйл. Аюултай байдалд орхих, тусламж үзүүлэхгүй байх (15.2.2.2) <u>ЭХ-ийн 15.1.3 болон 15.2.2.2-т заасан үйлдэж төгссөн болон завдсан бүх гэмт хэргийг энэ ангилалд дүйцүүлж болохоор байна.</u></p>	<p>Other acts leading to death or intending to cause death ГХСОУА-ын тайлбар хэсэгт дурдсанаар тусламж үзүүлээгүйгээс үхэлд хүргэсэн агуулга нь энэхүү ангиллыг бусад ангиллаас ялгах гол шинж болж байна. ЭХ-ийн 15.1.3 болон 15.2.2.2-т заасан хохирогч нас барсан үр дагавар бүхий гэмт хэргийг ГХСОУА-ын 0103 дугаар ангилалд дүйцүүлэхээс илүүтэйгээр 0109 ангилалд дүйцүүлэн нөхөх нь агуулгын хувьд илүү нийцэж байна. <u>Иймд энэхүү ангиллыг ЭХ-ийн 15.1.3 болон 15.2.2.2-т заасан гэмт хэргийн нийлбэр дүнгээр дүйцүүлэн нөхөхөөр байна.</u> Нэр томъёоны хувьд Амь насыг хохироосон болон хохироохыг завдсан бусад гэмт хэрэг гэх нэршлээр ойлгож, хэрэглэх нь зохистой.</p>

ХАВСРАЛТ 2

ГХСОУ-ЫН 02 АНГИЛЛЫГ МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ДАХЬ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ДҮЙЦҮҮЛСЭН ХУВИЛБАР

№	Хамаарах тувшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томъёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томъёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
1	I	02	<p>Хувь хүнд хохирол, гэмтэл учруулсан, учруулахыг завдсан хэрэг. 0201-0211, 0219</p> <p><u>ГХСОУА-д:</u></p> <p>1-р түвшний энэ ангилал нь ГХСОУ-ын нийт 12 төрлийн багц ангиллын хамгийн эхний 02 дугаартай ангилал юм.</p> <p>Уг ангиллын гарчгаас харахад хүний биед гэмтэл, хохирол учруулах хэргүүд хамаарахаар харагдаж байгаа ч түүний агуулгаас үзэхэд гэмтэл хохирол учруулаагүй боловч хүний халдашгүй, чөлөөтэй байх, эрүүл мэнд, хүүхдийн эрхэд халдах гэх мэт хэргүүд хамаарч байна. Иймд уг ангилалд зөвхөн хувь хүнд хохирол, гэмтэл учруулсан гэмт хэрэг хамаарахгүй нь гэж ойлгоно.</p> <p>Энэхүү ангиллын агуулгаас харахад гэмт хэргийн төгсгөлд бодит гэмтэл шаардах хэргээс гадна хүний бие махбодыг гэмтээгээгүй хэдий ч хэлбэрийн байдлаар хохирол учруулсан хэргүүд мөн хамаарахаар байна.</p>	<p>Acts causing harm or intending to cause harm to the person</p> <p>1-р түвшний 02 дугаар ангилал нь дотроо 0201-0211, 0219 гэсэн багц ангиллуудаас бүрддэг. Судалгааны явцад тэдгээр ангилал тус бүрийг ЭХ-ийн холбогдох зүйл, хэсэг, заалттай дүйцүүлэх тайлбарт аль ангиллыг бүрэн хэмжээнд, аль ангиллыг зарим хэсгээр дүйцүүлж байгаа талаар тэмдэглэсэн болно.</p> <p>02 дугаар ангилалд хүний эрүүл мэндэд хүнд гэмтэл, хүнд хохирол учруулсан, гэм буруугийн санаатай болон болгоомжгүй хэлбэрээр учруулсан, учруулахаар завдаж болох хэргүүд бүгд хамаарч байна. Энэ ангилалд ЭХ-ийн хэд хэдэн бүлэг түүнд холбогдох зүйл, хэсэг, заалт хамаарч байна.</p> <p><u>Нэр томъёоны хувьд:</u></p> <p>Юуны өмнө 02 дугаар ангиллын орчуулга болон оноосон нэр томъёоны хувьд мэргэжлийн үүднээс хандахыг анхааруулж байна. НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газраас боловсруулсан “Гэмт хэргийн статистикийн олон улсын ангилал”-д 02 дугаар ангиллыг орчуулахдаа “Хувь хүнд хохирол, гэмтэл учруулсан, учруулахыг завдсан” хэмээн орчуулжээ.</p>

№	Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НУБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томьёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томьёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
			<p><u>МУ-ын ЭХ-д:</u> <u>ЭХ-ийн дээр дурдсан зүйл, хэсэг, заалтад заасан гэмт хэрэгтэй бүрэн хэмжээнд болон зарим хэсгээр дүйцүүлж болохоор байна.</u> 11.1.1, 11.2.1, 11.3.1, 11.4.1, 11.5.1, 11.6.1, 11.7.1, 13.1.1, 13.2.1, 13.4.1, 13.4.2, 13.4.4.2, 13.5.1, 13.8.1, 13.9.1, 13.10.1, 13.10.2.1, 13.11.1, 13.12.1, 13.13.1, 13.14.1, 14.1.1, 14.8.1, 15.1.1, 15.2.1, 15.6.1, 16.2.2, 16.10.1, 16.11.1, 17.2.1, 19.9.1, 23.5.1, 26.1.1, 27.8.2.3, 27.9.1, 27.10.1, 27.10.2.1, 27.10.2.3, 27.10.4.1, 27.11.1, 29.5.1.</p>	<p>Гэтэл англи эхэд нь “Acts causing harm or intending to cause harm to the person”⁴⁷ хэмээн бичсэн байх ба энэ нь монгол хэлнээ “хувь хүнд хохирол бий болгох, хохирол учруулах нөхцөлийг бүрдүүлэх” хэмээн орчуулж болохоор байна. Англи хэлнээ завдалтыг “Attempt” хэмээх ба ийм ухагдахуун уг ангилалд алга байна. Гэтэл орчуулахдаа завдалт гэсэн ухагдахуун оруулснаар хувь хүнд хохирол учруулсан бүх гэмт хэргийн завдалт уг ангилалд орох нөхцөлийг бий болгосон ба энэ нь ноцтой зөрүү үүсгэхээр байна. Мөн нэр томьёоны хувьд Хүний эрүүл мэндэд гэмтэл учруулах болон хохирол учруулах хэмээн хэрэглэсэн байна. Гэвч уг хоёр ухагдахуун нь анагаахын шинжлэх ухааны үүднээс өөр өөр ухагдахуун учир ялгаатай хэрэглэх нь зүйтэй. Уг ангилалд зөвхөн “harm” буюу хохирол учруулсан байдлыг авч үзсэн ба үүн дотроо бодит хохирол шаардах гэмтэл болон бодит хохирол үл шаардах бусад гэмт хэргийг багтаажээ.</p>
2	II	0201	<p>Танхай болон заналхийлэх. <u>ГХСОУА-д:</u> Хүч хэрэглэн хохирол, гэмтэл учруулсан, эсвэл хохирол, гэмтэл учруулахаар заналхийлэх гэмт хэргийг хамааруулах агуулгатай байна. <u>МУ-ын ЭХ-д:</u> Уг ангилалд хамаарах гэмт хэрэг алга байна.</p>	<p>Assaults and threats Уг ангиллын агуулгаас харахад танхайрах болон заналхийлэх явцдаа хүний биед гэмтэл, хохирол учруулах гэмт хэргүүд хамаарахаар байна. МУ-ын ЭХ-ийн 11.1.2.1-д онц харгис, хэрцгий аргаар хүний биед гэмтэл учруулж болохоор заасан. Гэвч энэ нь танхайрах болон заналхийлэх үйлдлээс нийгмийн хор аюулын хувьд их учир уг гэмт хэрэгт хамаарахгүй юм.</p>

⁴⁷ ICCS_English_2016_web.pdf. p 37

№ Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томъёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томъёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
			<p>ЭХ-ийн 13.5, 15.3, 17.6 гэх мэт гэмт хэрэгт заналхийлэх гэх ухагдахууныг хуульчилсан байдаг ч энэ нь тусдаа гэмт хэргийн шинж бус, харин тухайн гэмт хэргийг үйлдэх аргыг илэрхийлдэг. Иймд уг ангилалд оруулах боломжгүй.</p> <p><u>Нэр томъёоны хувьд:</u></p> <p>Үг зүйн болон агуулгын хувьд уг ангилалд Танхай болон заналхийлэх аргын гэмт хэргүүд хамаарахгүйг анхаар. ГХСОУА-ын англи эхэд уг ангиллыг “Assaults and threats”⁴⁸ хэмээсэн байна. Assaults гэх нэр томъёо нь монгол хэлнээ довтолгоо⁴⁹ хэмээн орчуулагдах ба агуулгын хувьд идэвхтэй үйлдэл буюу довтолгоогоор хүний биед хохирол учруулсан гэмт хэргийг илэрхийлэх юм. Харин threats гэх англи үг нь монгол хэлнээ айлган сүрдүүлэх, заналхийлэх⁵⁰ хэмээн орчуулагдах ба дээрх аргаар хүний биед хохирол учруулсан гэмт хэргүүдийг хамаарах агуулга илэрхийлнэ.</p> <p>Иймд Танхайрах явцдаа хүний биед хүнд гэмтэл учруулсан хэмээн томъёолж болох юм. Гэхдээ 2015 оны ЭХ-аар Танхай гэх гэмт хэрэг байхгүй болсон.</p>

⁴⁸ Ibid, p 37

⁴⁹ Нарангэрэл С. Хууль зүйн англи-монгол эх толь. УБ., 2012. 88 дахь тал

⁵⁰ Нарангэрэл С. Хууль зүйн англи-монгол эх толь. УБ., 2012. 530 дахь тал

№	Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томьёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томьёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
3	III	02011	<p>Танхайрах</p> <p><u>ГХСОУА-д:</u> Санаатай болон болгоомжгүй хүч хэрэглэсэн идэвхтэй үйлдлээр хүний бие махбодод халдах агуулгыг илэрхийлнэ.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u> 11.1 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах (11.1.1) 11.2 дугаар зүйл. Санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах (11.2.1) 11.3 дугаар зүйл. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол болгоомжгүйгээр учруулах (11.3.1) 11.4 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах (11.4.1) 11.5 дугаар зүйл. Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол болгоомжгүйгээр учруулах (11.5.1) 11.6 дугаар зүйл. Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах (11.6.1) 11.7 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх (11.7.1) 13.4 дүгээр зүйл. Хүнийг хүчээр алга болгох (13.4.4.2) 16.2 дугаар зүйл. Хүүхдийг согтуурах, мансуурах, донтох байдалд татан оруулах (16.2.2)</p>	<p>Assault</p> <p>ЭХ-ийн 11.1.1, 11.2.1, 11.3.1, 11.4.1, 11.5.1, 11.6.1, 11.7.1-д заасан гэмт хэргүүдийг бүрэн хэмжээгээр, харин 13.4.4.2, 16.2.2, 19.3.1, 29.5.1-д заасан хэргүүдийг үйлдэл, үр дагавраар нь зарим хэсгээр дүйцүүлж болохоор байна.</p> <p>13.4.4.2, 16.2.2, 29.5.1-д хүч хэрэглэсэн гэсэн нөхцөл байхгүй хэдий ч тухайн гэмт хэрэг нь хүч хэрэглэх аргаар мөн явагдаж болох учир уг ангилалд дүйцүүлж болохоор байна.</p> <p><u>Нэр томьёоны хувьд:</u> ГХСОУА-ын англи эхэд уг ангиллыг “Assaults”⁵¹ хэмээсэн байна. Assaults гэх нэр томьёо нь монгол хэлнээ довтолгоо хэмээн орчуулагдах ба агуулгын хувь идэвхтэй үйлдэл буюу довтолгоогоор хүний биед хохирол учруулсан нийт гэмт хэргийг илэрхийлэх юм.</p>

⁵¹ ICCS_English_2016_web.pdf. p 37

№ Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томъёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томъёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
		<p>19.3 дугаар зүйл. Төрийн өндөр албан тушаалтны амь биед халдах (19.3.1)</p> <p>29.5 дугаар зүйл. Төрлөөр устгах (29.5.1)</p>	
4	IV 020111	<p>Танхайн ноцтой хэлбэр</p> <p><u>ГХСОУА-д:</u></p> <p>Хүч хэрэглэсэн довтолгооны улмаас хүний биед хүнд гэмтэл учруулсан хэргүүдийг уг ангилалд хамааруулна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u></p> <p>11.1 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах (11.1.1.)</p> <p>11.2 дугаар зүйл. Санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах (11.2.1)</p> <p>11.4 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах (11.4.1)</p> <p>13.4 дүгээр зүйл. Хүнийг хүчээр алга болгох (13.4.4.2)</p> <p>16.2 дугаар зүйл. Хүүхдийг согтуурах, мансуурах, донтох (16.2.2)</p> <p>19.3 дугаар зүйл. Төрийн өндөр албан тушаалтны амь биед халдах (19.3.1)</p> <p>27.8 дугаар зүйл. Агаарын хөлгийг авч зугтаах (27.8.2.3)</p> <p>29.5 дугаар зүйл. Төрлөөр устгах (29.5.1)</p>	<p>Serious assault</p> <p>11.1.1, 11.4.1, 13.4.4.2-т заасан хэргүүдийг уг ангилалтай бүрэн хэмжээгээр, 11.2.1, 16.2.2, 19.3.1, 27.8.2.3, 29.5.1-д заасан хэргүүдийг үйлдэл, үр дагаврын шинжээр нь зарим хэсгээр дүйцүүлэн хамааруулж болохоор байна.</p> <p>11.2.1, 16.2.2, 27.8.2.3, 29.5.1-д заасан хэргүүдийн заалтад хүч хэрэглэх гэсэн нөхцөл онцгойлон байхгүй хэдий ч эдгээр хэрэг нь хүч хэрэглэсэн үйлдлээр үйлдэгдэн хүнд, хүндэвтэр хохирлыг хохирогчид учруулах боломжтой.</p> <p><u>Нэр томъёоны хувьд</u></p> <p>ГХСОУА-ын англи эхэд уг ангиллыг “Serious assault”⁵² буюу хүч хэрэглэсэн довтолгоо гэсэн байна. Иймээс “Танхайн ноцтой хэлбэр” хэмээн бие даасан гэмт хэргийн оноосон нэрээр бус хүчтэй довтолгоо гэх үйлдлийн агуулгаар ойлгож, хүчтэй довтолгооны улмаас хүнд гэмтэл учруулсан үйлдлийг хамааруулах нь зүйтэй.</p>

⁵² Ibid, p 37

№	Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томъёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томъёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
5	IV	020112	<p>Танхайн хөнгөн хэлбэр</p> <p><u>ГХСОУА-д:</u> Хүч хэрэглэсэн хөнгөн довтолгооны улмаас хүний биед хөнгөн гэмтэл, эсвэл хохирол учруулаагүй хэргүүдийг уг ангилалд хамааруулна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u> 11.6 дугаар зүйл. Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах (11.6.1) 11.7 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх (11.7.1)</p>	<p>Minor assault</p> <p>11.6-д заасан гэмт хэргийг уг ангилалд бүрэн хэмжээгээр, 11.7.1-д заасан гэмт хэргийг зарим хэсгээр дүйцүүлэн хамааруулж болохоор байна. 11.7.1-д заасан “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэрэг нь өөртөө хөнгөн гэмтэл учруулах болон гэмтэл учраагүй байх үр дагаврыг агуулж байдаг. ЭХ-д хөнгөн довтолгоогоор үйлдэгдэх явцдаа хөнгөн гэмтэл болон гэмтэл учруулахаар хуульчлагдсан хэргүүд байдаг хэдий ч тэдгээр нь хөнгөн гэмтэл учруулсан тохиолдолд хөнгөн гэмтэлтэй давхар зүйлчлэгдэх ба гэмтэл учруулаагүй бол тухайн хэргийн арга болж дангаар зүйлчлэгдэх учир уг ангилалд бус, харин бусад холбогдох ангилалд хамаарах юм.</p> <p>Нэр томъёоны хувьд ГХСОУА-ын англи эхэд уг ангиллыг “Minor assault”⁵³ буюу ялимгүй⁵⁴ хэлбэрийн довтолгоо гэсэн байна. Агуулгын хувьд энэ нь хүний биед хөнгөн хохирол буюу хохирол учруулаагүй үйлдлээр довтолсон хэргүүдийг агуулна.</p>

⁵³ Ibid, p 37

⁵⁴ Нарангэрэл С. Хууль зүйн англи-монгол эх толь. УБ., 2012.374 дахь тал

№ Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томъёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томъёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
6	III	02012 Сүрдүүлэх, заналхийлэх <u>ГХСОУА-д:</u> Хувь хүнд хохирол учруулахаар заналхийлэх аливаа гэмт хэрэг уг ангилалд хамаарна. <u>МУ-ын ЭХ-д:</u> 13.5 дугаар зүйл. Заналхийлэх (13.5.1)	Threat МУ-ын ЭХ-д хүний бид хохирол, гэмтэл учруулахаар тодорхой хуульчилсан гэмт хэрэг байхгүй. Харин 13.5.1-д өөрт нь, түүний ойр дотнын хүнд хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн гэсэн нөхцөл байх ба үүнд биед нь хохирол, гэмтэл учруулахаас эхлээд бүх хэлбэрийн заналхийлэл багтах учир уг зүйл ангийг дүйцүүлэх боломжтой. Мөн ЭХ-д заналхийлэх замаар үйлдэж болох тодорхой гэмт хэргүүд байх хэдий ч үүнээс хүний биед хохирол учруулахаар заналхийлэх хэрэг байхгүй ба хүчиндэх гэх мэт өөр үр дагаварт чиглэсэн байна. Нэр томъёоны хувьд ГХСОУА-ын англи эхэд уг ангиллыг “Threat” ⁵⁵ буюу заналхийлэх ⁵⁶ гэсэн агуулгаар тусгасан байна. Агуулгын хувьд сүрдүүлэх болон заналхийлэх ухагдахуун ялгаатай юм.

⁵⁵ ICCS_English_2016_web.pdf. p 37

⁵⁶ Нарангэрэл С. Хууль зүйн англи-монгол эх толь. УБ., 2012.530 дахь тал

№	Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томъёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томъёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
7	IV	020121	<p>Ноцтой заналхийлэх</p> <p><u>ГХСОУА-д:</u> Үхэлд хүргэх болон хүнд гэмтэл учруулахаар санаатай заналхийлсэн үйлдэл уг ангилалд хамаарна</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u> 13.5 дугаар зүйл. Заналхийлэх (13.5.1)</p>	<p>Serious threat</p> <p>МУ-ын ЭХ-д үхэлд болон хүнд гэмтэл учруулахаар заналхийлэх хэмээн заналхийлэх хэргийг заналхийллийн хэлбэрээр нь нарийвчлан хуульчилсан гэмт хэрэг байхгүй. Харин 13.5.1-д өөрт нь, түүний ойр дотнын хүнд хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн гэсэн ерөнхий нөхцөл байх ба үүнд үхэлд хүргэх болон хүнд гэмтэл учруулахаар заналхийлэх үйлдэл багтах учир тус зүйл ангийг дүйцүүлэх замаар уг ангилалд багтаах боломжтой. Мөн ЭХ-д заналхийлэх замаар үйлдэж болох тодорхой гэмт хэргүүд байх ба хүчиндэх гэх мэт өөр үр дагаварт чиглэсэн байх учир уг ангилалд хамаарахгүй.</p> <p>ГХСОУА-ын англи эхэд буй “Serious threat”⁵⁷-ыг хүнд хэлбэрийн заналхийлэл хэмээн орчуулж болохоор байна. Агуулгын хувьд хүнийг алах, эсвэл хүнд гэмтэл учруулна хэмээн заналхийлэх хэргийг илэрхийлнэ.</p>

⁵⁷ ICCS_English_2016_web.pdf. p 38

№	Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томъёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томъёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
8	IV	020122	<p>Хөнгөн хэлбэрийн заналхийлэл</p> <p><u>ГХСОУА-д:</u></p> <p>Хөнгөн хэлбэрийн гэмтэл учруулахаар санаатай заналхийлсэн үйлдэл уг ангилалд хамаарна</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u></p> <p>13.5 дугаар зүйл. Заналхийлэх (13.5.1)</p>	<p>Minor threat</p> <p>МУ-ын ЭХ-д ялгүй байдлаар заналхийлэх хэмээн заналхийлэх хэргийг хэлбэрээр нь нарийвчлан хуульчилсан гэмт хэрэг байхгүй. Харин 13.5.1-д өөрт нь, түүний ойр дотнын хүнд хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн гэсэн ерөнхий нөхцөл байх ба ялимгүй заналхийлэх үйлдэл багтах учир уг зүйл ангийг дүйцүүлэх замаар уг ангилалд багтаах боломжтой. Мөн ЭХ-д заналхийлэх замаар үйлдэж болох тодорхой гэмт хэргүүд байх ба хүчиндэх гэх мэт өөр үр дагаварт чиглэсэн байх учир уг ангилалд хамаарахгүй.</p> <p>ГХСОУА-ын англи эхэд буй “Minor threat”⁵⁸-г ялимгүй хэлбэрийн заналхийлэл хэмээн орчуулж болохоор байна. Агуулгын хувьд ялимгүй (тухайлбал, алгодна гэх мэт) хохирол учруулахаар санаатай заналхийлсэн хэргийг илэрхийлнэ.</p>
9	III	02019	<p>Танхайрах болон заналхийлэх бусад хэлбэр</p> <p><u>ГХСОУА-д:</u></p> <p>Уг ангилалд хүний биед гэмтэл, хохирол учруулж довтолсон болон учруулахаар заналхийлсэн бусад үйлдлийг багтаана.</p>	<p>Other assaults and threats</p> <p>МУ-ын ЭХ-д хүний биед хохирол, гэмтэл учруулах, учруулахаар заналхийлсэн үйлдлийг нарийвчилсан бус, ерөнхий байдлаар хуульчилсан учир уг ангилалд хамаарах гэмт хэрэг алга байна.</p>

⁵⁸ Ibid, p 38

№	Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НУБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томъёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томъёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
10	II	0202	<p>Эрх чөлөөний эсрэг хэрэг</p> <p><u>ГХСОУА-д:</u> Хүний биеийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарласан хэргүүд хамаарна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u> 13.2 дугаар зүйл. Хүн хулгайлах (13.2.1) 13.4 дүгээр зүйл. Хүнийг хүчээр алга болгох (13.4.1)</p>	<p>Acts against liberty</p> <p>Хүний шилжилт хөдөлгөөнийг түүний хүсэл зоригоос гадуур хязгаарласан үйлдэл ЭХ-ийн 13.2.1, 13.4.1-д байх бөгөөд уг ангилалд бүрэн хэмжээгээр дүйцүүлж болно.</p> <p>МУ-ын ЭХ-д хүний шилжилт хөдөлгөөнийг түүний хүсэл зоригоос гадуур хязгаарласан үйлдэл нь дээрх хоёр зүйл ангиас өөр зүйл ангид байгаа боловч тэдгээр нь тусдаа бие даасан гэмт хэрэг биш, харин өөр гэмт хэргийг үйлдэх арга учир энэ ангилалд хамаарахгүй юм. (Тухайлбал, хүн худалдаалах зорилгоор хүнийг хулгайлах)</p> <p>Нэр томъёоны хувьд ГХСОУА-ын англи эхэд уг ангиллыг “ Acts against liberty”⁵⁹ хэмээсэн байх ба үүнийг монгол хэлнээ эрх чөлөөний эсрэг хэрэг хэмээн орчуулж болно. Гэвч ийнхүү орчуулах нь уг ангиллын агуулгад нийцэхгүй юм. Учир нь уг ангилалд зөвхөн биеийн шилжилт хөдөлгөөнтэй холбоотой эрх чөлөөний эсрэг үйлдлүүдийг багтаасан байна. Тэгэхээр уг ангиллыг ерөнхийд нь эрх чөлөөний эсрэг хэмээн орчуулж болохгүй ба ийнхүү орчуулах тохиолдолд бүх эрх чөлөөний эсрэг үйлдэл (тухайлбал, бэлгийн эрх чөлөө) хамаарах агуулгатай болно. Иймд уг ангиллын гарчгийг “биеийн шилжилт хөдөлгөөний эрх чөлөөний эсрэг үйлдэл” хэмээн орчуулах нь зохимжтой болов уу.⁶⁰</p>

⁵⁹ Ibid, p 38

⁶⁰ Adolf Schünke / Horst Schröder. Strafgesetzbuch Kommentar. 25.Auf., C.H. Beck,sche Verlagsbuchhandlung München 1997. S. 1656; Wolfgang Joecks. Strafgesetzbuch Studienkommentar. 7.Auf., Verlag C.H. Beck München. 2007. S. 211

№ Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томъёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томъёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
11	III	<p>02021 Насанд хүрээгүй хүүхдийг хулгайлах <u>ГХСОУА-д:</u> 18 насанд хүрээгүй хүнийг асран хамгаалагч болон харгалзан дэмжигчээс нь хууль бусаар авч явах, нуух, тодорхой орон зайд хүчээр байлгах агуулгыг илэрхийлнэ. <u>МУ-ын ЭХ-д:</u> 13.2 дугаар зүйл. Хүн хулгайлах (13.2.1)</p>	<p>Abduction of a minor МУ-ын ЭХ-д хулгайлж байгаа хүнийх нь насны онцлогоос хамаарч хүүхэд болон насанд хүрсэн хүнийг хулгайлах хэмээн нарийвчлан хуульчилсан зүйл анги байхгүй ба ерөнхийдөө 13.2.1-д хүн хулгайлах хэмээн зааж бүх насны хүнийг хамаарахаар хуульчилсан учир уг ангилалд 13.2.1-ийг зарим хэсгээр дүйцүүлэн хамааруулах боломжтой. Нэр томъёоны хувьд насанд хүрээгүй хүүхэд гэх ухагдахуун байхгүй учир 18 насанд хүрээгүй хүнийг, эсвэл хүүхдийг хулгайлах хэмээн оноох нь зүйтэй. Учир нь, хүүхэд хэмээх ухагдахуун нь угаас насанд хүрээгүй агуулгыг илэрхийлдэг.</p>
12	IV	<p>020211 Эцэг, эх нь хулгайлах <u>ГХСОУА-д:</u> Асран хамгаалах эрхгүй эцэг, эх 18 насанд хүрээгүй хүүхдээ хулгайлах агуулга хамаарна. <u>МУ-ын ЭХ-д:</u> 13.2 дугаар зүйл. Хүн хулгайлах (13.2.1)</p>	<p>Parental abduction МУ-ын ЭХ-д хулгайлж байгаа хүн болон хохирогчийн насны онцлогтой холбоотой асран хамгаалах эрхгүй эцэг, эх 18 насанд хүрээгүй хүүхдээ хулгайлах хэргийг нарийвчлан хуульчилсан зүйл анги байхгүй. Ерөнхийдөө 13.2.1-д хүн хулгайлах хэмээн зааж аливаа хүн ямар ч хүнийг хулгайлж болохоор хуульчилсан учир уг ангилалд 13.2.1-ийг зарим хэсгээр дүйцүүлэн хамааруулах боломжтой.</p>
13	IV	<p>020212 Гэр бүлийн өөр гишүүндээ хулгайлуулах <u>ГХСОУА-д:</u> 18 насанд хүрээгүй хүнийг эцэг, эх болон асран хамгаалах эрх аваагүй хүнээс бус гэр бүлийн хамаарал бүхий хүн хулгайлах</p>	<p>Abduction by another family member -</p>

№	Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томьёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томьёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
14	IV	020213	Хууль ёсны асран хамгаалагчдаа хулгайлуулах <u>ГХСОУА-д:</u> Эцэг эх, асран хамгаалагч, гэр бүлийн хамаарал бүхий бусад хүмүүс бус хууль ёсны харгалзан дэмжигч нь 18 насанд хүрээгүй хүнийг хулгайлах агуулгатай.	Abduction by a legal guardian -
15	IV	020219	Насанд хүрээгүй хүүхдийг хулгайлах өөр бусад хэлбэр <u>ГХСОУА-д:</u> Насанд хүрээгүй хүүхдийг хулгайлах 020211- 020213 дугаар ангилалд хамаараагүй өөр бусад хэлбэр. <u>МУ-ын ЭХ-д:</u> Уг ангилалд хамаарах гэмт хэрэг алга байна.	Other abduction of a minor -
16	III	02022	Эрх чөлөөгүй болгох <u>ГХСОУА-д:</u> Хүний хүсэл зоригоос гадуур түүнийг хорих, баривчлах хэргүүд уг ангилалд хамаарна. <u>МУ-ын ЭХ-д:</u> 13.2 дугаар зүйл. Хүн хулгайлах (13.2.1) 13.4 дүгээр зүйл. Хүнийг хүчээр алга болгох (13.4.1) 13.9 дүгээр зүйл. Хууль бусаар баривчлах, саатуулах (13.9.1)	Deprivation of liberty ГХСОУА-ын англи эхэд уг ангиллыг “Deprivation of liberty” ⁶¹ хэмээн бичсэн ба үүнийг монгол хэлнээ эрх чөлөөгүй болгох хэмээн орчуулах нь агуулгын алдаанд хүргэх магадлалтай. Учир нь уг ухагдахуун агуулгын хувьд “Хүний хүсэл зоригийн эсрэг хаалттай орон зайд тогтоон барих утгыг илэрхийлж байна.” ⁶² Иймд уг ангиллыг “хүний чөлөөтэй байх эрхийг хязгаарлах” хэмээн томьёолох нь оновчтой.

⁶¹ ICCS_English_2016_web.pdf. p 39

⁶² Carl Creifelds. Rechtswörterbuch. 21 Aufl., . Verlag C.H.Beck München 2014. S.484

№ Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томъёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томъёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
17 IV 020221		<p>Хүн хулгайлах</p> <p><u>ГХСОУА-д:</u> Эд хөрөнгийн ашиг болон ямар нэгэн материаллаг ашиг бий болгох, эсвэл ямар нэгэн үйлдэл хийлгэх, хийлгэхгүй байх зорилгоор хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлж хүнийг өөрийнх нь хүсэл зоригоос гадуур баривчлах, хулгайлах үйлдэл хамаарна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u> 13.2 дугаар зүйл. Хүн хулгайлах (13.2.1)</p>	<p>Kidnapping</p> <p>МУ-ын ЭХ-ийн 13.2.1-д заасан Хүн хулгайлах гэмт хэрэг нь хүнийг эрхшээлдээ оруулах буюу хулгайлах үйлдлээр гүйцэтгэгдэж байдаг учир энэ ангилалд зарим хэсгээр дүйцүүлэн хамааруулж болно. Зарим хэсгээр дүйцүүлэн хамааруулах үндэслэл нь МУ-ын ЭХ-д заасан хүн хулгайлах гэмт хэрэг нь уг ангилалд заасан тодорхой ашиг бий болгох, үйлдэл хийлгэх, эсвэл үйлдэл хийлгэхгүй байх зорилгыг агуулдаггүй.</p>
18 IV 020222		<p>Хууль бусаар хорих</p> <p><u>ГХСОУА-д:</u> Хүний хүсэл зоригоос гадуур хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хууран мэхлэх аргаар тодорхой орон зайд хорих болон оршин байгаа газраас өөр газар руу тээвэрлэх хэрэг уг ангилалд хамаарна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u> 13.4 дүгээр зүйл. Хүнийг хүчээр алга болгох (13.4.1)</p>	<p>Illegal restraint</p> <p>МУ-ын ЭХ-ийн 13.4.1-д заасан Хүнийг хүчээр алга болгох гэмт хэрэг нь хүнийг хууль бусаар хорих агуулгатай байдаг учир уг ангилалд бүрэн хэмжээгээр дүйцүүлэн хамааруулна.</p>

№	Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томъёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томъёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
19	IV	020223	<p>Булаан эзлэх</p> <p><u>ГХСОУА-д:</u> Тээврийн хэрэгслийг жолооч болон зорчигчийн хамтаар хүч хэрэглэж болон хүч хэрэглэхээр заналхийлж булаан авах хэргүүд хамаарна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u> 17.2 дугаар зүйл. Дээрэмдэх (17.2.1)</p>	<p>Hijacking</p> <p>МУ-ын ЭХ-д тээврийн хэрэгслийг дээрэмдэх гэсэн нарийвчилсан зүйл анги байхгүй ба харин 17.2.1-д “Дээрэм” гэсэн зүйл анги бий. Үүнд нийт эд хөрөнгө тэр дундаа тээврийн хэрэгсэл хамаарах учир уг ангилалд зарим хэсгээр дүйцүүлэн хамааруулах боломжтой.</p> <p>Нэр томъёоны хувьд ГХСОУА-ын англи эхэд уг ангиллыг “Hijacking”⁶³ буюу тээврийн хэрэгслийн дээрэм хэмээн бичсэн байна.⁶⁴ Иймд “булаан эзлэх” бус “тээврийн хэрэгслийн дээрэм” хэмээн томъёолох нь зүйтэй.</p>
20	IV	020229	<p>Эрх чөлөөг хасах бусад үйлдэл</p> <p><u>ГХСОУА-д:</u> Уг ангилалд тус бүлэгт тусгайлан заагаагүй эрх чөлөөг хязгаарласан бусад гэмт хэрэг хамаарах юм.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u> 13.9 дүгээр зүйл. Хууль бусаар баривчлах, саатуулах (13.9.1)</p>	<p>Other deprivation of liberty</p> <p>ГХСОУА-д Эрх бүхий албан тушаалтан хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж баривчилсан үйлдлийг тусгайлан заагаагүй юм. Харин МУ-ын ЭХ-ийн 13.9.1-д уг үйлдлийг хуульчилсан ба энэ нь эрх чөлөөг хасах бусад үйлдэлд хамаарахаар байна.</p>
21	III	02029	<p>Эрх чөлөөний эсрэг бусад хэрэг</p> <p><u>ГХСОУА-д:</u> Эрх чөлөөний эсрэг 02021-02022-д тодорхойлж, ангилаагүй хэрэг.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u> Уг ангилалд хамаарах гэмт хэрэг алга байна.</p>	<p>Other acts against liberty</p> <p>-</p>

⁶³ ICCS_English_2016_web.pdf. p 40

⁶⁴ Нарангэрэл С. Хууль зүйн англи-монгол эх толь. УБ., 2012. 374 дэх тал

Хавсралт 2-ын үргэлжлэл

№	Хамаарах түүшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томъёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томъёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
22	IV	020291	<p>Хууль бус үрчлэлт</p> <p><u>ГХСОУА-д:</u></p> <p>Хүүхдийг хууль бусаар үрчлэн авах, эсвэл хууль бусаар үрчлэн авах зорилгоор хүүхэд үрчлэн авах ажиллагааг зохион байгуулсан, зуучилсан үйлдэл энэ бүлэгт хамаарна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u></p> <p>Уг ангилалд хамаарах гэмт хэрэг байхгүй.</p>	<p>Illegal adoption</p> <p>-</p>
23	IV	020292	<p>Хүчээр гэр бүл болгох</p> <p><u>ГХСОУА-д:</u></p> <p>Гэрлэгчийн зөвшөөрөлгүй гэрлэлт, айлган сүрдүүлж, хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлж, мансууруулах болон согтууруулах ундаа хэрэглүүлж, эрх мэдэл, эмзэг байдлыг нь ашиглаж зөвшөөрсөн гэрлэлт хамаарна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u></p> <p>Уг ангилалд хамаарах гэмт хэрэг алга байна.</p>	<p>Forced marriage</p> <p>-</p>
24	IV	020299	<p>Эрх чөлөөний эсрэг бусад хэрэг</p> <p><u>ГХСОУА-д:</u></p> <p>Эрх чөлөөний эсрэг хэрэгт тодорхойлж, ангилаагүй бусад хэлбэр 020291-020292</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u></p> <p>Уг ангилалд хамаарах гэмт хэрэг алга байна.</p>	<p>Other acts against liberty</p> <p>-</p>

№	Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НУБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томьёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томьёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
25	II	0203	<p>Боолчлол ба мөлжлөг</p> <p><u>ГХСОУА-д:</u> Санхүүгийн болон бусад ашиг хонжоо олохын тулд хүн хулгайлахаас гадна мөлжлөгийн зорилгоор хүний эрх чөлөөг хязгаарлах гэмт хэрэг уг ангилалд хамаарна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u> 13.13 дугаар зүйл. Албадан хөдөлмөрлүүлэх (13.13.1) 16.10 дугаар зүйл. Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх (16.10.1)</p>	<p>Slavery and exploitation</p> <p>Уг ангиллын агуулгаас харахад хүн худалдаалахаас бусдаар хүний эрх чөлөөг хязгаарлан боолчилсон, албадан хөдөлмөрлүүлсэн хэрэг хамаарахаар байна.</p> <p>Уг ангилалд ЭХ-ийн 13.13.1-д заасан гэмт хэрэг бүрэн дүйцэх бол 16.10.1-д заасан хэргийг зарим хэсгээр дүйцүүлэх боломжтой байна. Дүйцүүлэх учир нь 16.10.1-д заасан хэргийн хохирогч нь хүүхэд байх бөгөөд өөрөө хөдөлмөр эрхлэхийг зөвшөөрсөн байж болдог.</p>
26	III	02031	<p>Боолчлол</p> <p><u>ГХСОУА-д:</u> Хүнийг өмчлөх замаар эрхшээлдээ байлгаж хууль бусаар хөдөлмөрлүүлэх зорилгоор цаашаа худалдах, үүнтэй холбоотой бусад үйлдэл уг ангилалд хамаарна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u> Уг ангилалд хамаарах зүйл анги байхгүй.</p>	<p>Slavery</p> <p>-</p>
27	III	02032	<p>Албадан хөдөлмөр</p> <p><u>ГХСОУА-д:</u> Хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж хүсэл зоригоос гадуур ажил, үйлчилгээ хийлгэх үйлдэл хамаарна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u> 13.13 дугаар зүйл. Албадан хөдөлмөрлүүлэх (13.13.1)</p>	<p>Forced labour</p> <p>МУ-ын ЭХ-ийн 13.13.1-д заасан хэргийн нөхцөл нь уг ангиллын агуулгатай таарч байх тул бүрэн хэмжээгээр дүйцүүлэн хамааруулна.</p>

№	Хамаарах түүшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томъёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томъёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
28	IV	020321	<p>Гэрийн үйлчилгээний албадан хөдөлмөр</p> <p><u>ГХСОУА-д:</u></p> <p>Гуравдагч этгээдийн эзэмшилд гэрийн үйлчилгээний төрлийн хөдөлмөрийг албадан хийлгэх үйлдэл хамаарна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u></p> <p>Уг ангилалд хамаарах зүйл анги байхгүй.</p>	<p>Forced labour for domestic services</p> <p>-</p>
29	IV	020322	<p>Үйлдвэр, үйлчилгээний албадан хөдөлмөр</p> <p><u>ГХСОУА-д:</u></p> <p>Аж үйлдвэрт ажиллах, үйлчилгээ үзүүлэх байдлаар албадан хөдөлмөрлүүлэх үйлдэл хамаарна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u></p> <p>Уг ангилалд хамаарах зүйл анги байхгүй.</p>	<p>Forced labour for industrial services</p> <p>-</p>
30	IV	020323	<p>Төр болон зэвсэгт хүчний албадан хөдөлмөр</p> <p><u>ГХСОУА-д:</u></p> <p>Төрийн байгууллага болон зэвсэгт хүчинд албадан хөдөлмөрлүүлсэн үйлдэл уг ангилалд хамаарна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u></p> <p>Уг ангилалд хамаарах зүйл анги байхгүй.</p>	<p>Forced labour for the State or armed forces</p> <p>-</p>

№	Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томьёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томьёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
31	IV	020329	<p>Албадан хөдөлмөрийн бусад хэлбэр</p> <p><u>ГХСОУА-д:</u> Албадлагын хөдөлмөр эрхлэлтийн 020321-020323-д тодорхойлж ангилаагүй бусад хэлбэр.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u> Уг ангилалд хамаарах зүйл анги байхгүй.</p>	<p>Other forced labour</p> <p>-</p>
32	III	02039	<p>Боолчлол ба мөлжлөг бусад хэлбэр</p> <p><u>ГХСОУА-д:</u> Боолчлол ба мөлжлөгийн 02031-02032-д тодорхойлж, ангилаагүй бусад хэлбэр.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u> Уг ангилалд хамаарах зүйл анги байхгүй.</p>	<p>Other acts of slavery and exploitation</p> <p>-</p>
33	II	0204	<p>Хүн худалдаалах</p> <p><u>ГХСОУА-д:</u> Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж хүнийг эрхшээлдээ оруулсан; тээвэрлэсэн; орогнуулсан; дамжуулсан аливаа үйлдэл уг ангилалд хамаарна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u> 13.1 дүгээр зүйл. Хүн худалдаалах (13.1.1)</p>	<p>Trafficking in persons (TIP)</p> <p>Уг ангилалд аливаа зорилгоор хүнийг худалдах нийт гэмт хэрэг хамаарна.</p> <p>МУ-ын ЭХ-ийн 13.1.1-д заасан гэмт хэргийг уг ангилалд бүрэн хэмжээгээр дүйцүүлэн хамааруулж болно.</p>

№	Хамаарах түүвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томъёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томъёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
34	III	02041	<p>Бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах <u>ГХСОУА-д:</u> Уг ангилалд бэлгийн мөлжлөгт оруулах зорилгоор хүнийг хулгайлсан аливаа хэрэг хамаарна. <u>МУ-ын ЭХ-д:</u> 13.1 дүгээр зүйл. Хүн худалдаалах (13.1.1)</p>	<p>TIP for sexual exploitation МУ-ын ЭХ-д хүн худалдаалах гэмт хэргийг зорилго тус бүрээр нь нарийвчлан бие даасан гэмт хэрэг болгон хуульчлаагүй ба нийтэд нь 13.1.1-д хуульчилсан юм. ЭХ-ийн 13.1.1-д “бэлгийн мөлжлөгт” оруулах зорилгоор гэсэн нөхцөл байх ба үүгээр нь зарим хэсгээр дүйцүүлэн уг ангилалд хамааруулах боломжтой.</p>
35	III	02042	<p>Үйлчилгээний зорилгоор албадан хөдөлмөр эрхлүүлэх хүн худалдаалах <u>ГХСОУА-д:</u> Албадан хөдөлмөрлүүлэх болон мэргэшсэн ажил үйлчилгээ эрхлүүлэх зорилгоор хүнийг худалдах үйлдэл уг ангилалд хамаарна. <u>МУ-ын ЭХ-д:</u> 13.1 дүгээр зүйл. Хүн худалдаалах (13.1.1)</p>	<p>TIP for forced labour or services МУ-ын ЭХ-д хүн худалдаалах гэмт хэргийг зорилго тус бүрээр нь нарийвчлан бие даасан гэмт хэрэг болгон хуульчлаагүй ба нийтэд нь 13.1.1-д хуульчилсан юм. ЭХ-ийн 13.1.1-д “албадан хөдөлмөрлүүлэх” зорилгоор гэсэн нөхцөл байх ба үүгээр нь зарим хэсгээр дүйцүүлэн уг ангилалд хамааруулах боломжтой. Нэр томъёоны хувьд уг ангиллыг “үйлчилгээ үзүүлэх зорилгоор хүн худалдаалах, албадан хөдөлмөр эрхлүүлэх” хэмээн хоёр тусдаа ухагдахуун үүсгэн орчуулсан байна. Гэвч энэ нь учир дутагдалтай бөгөөд ГХСОУА-ын англи эхэд уг ангиллыг “TIP for forced labour or services”⁶⁵ буюу “Албадан хөдөлмөрлүүлэх болон мэргэшсэн ажил үйлчилгээ эрхлүүлэх зорилгоор хүнийг худалдах” гэсэн нэг ухагдахууныг илэрхийлсэн байна.</p>

⁶⁵ ICCS_English_2016_web.pdf. p 42

№	Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НУБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томъёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томъёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
36	III	02043	<p>Эрхтэн шилжүүлэх зорилгоор хүн худалдаалах ГХСОУА-д: Эд эрхтнийг нь авах зорилгоор хүнийг худалдаалсан аливаа хэрэг хамаарна. <u>МУ-ын ЭХ-д:</u> 13.1 дүгээр зүйл. Хүн худалдаалах (13.1.1)</p>	<p>TIP for organ removal МУ-ын ЭХ-д хүн худалдаалах гэмт хэргийг зорилго тус бүрээр нь нарийвчлан бие даасан гэмт хэрэг болгон хуульчлаагүй ба нийтэд нь 13.1.1-д хуульчилсан юм. ЭХ-ийн 13.1.1-д “эд, эрхтнийг авах” зорилгоор гэсэн нөхцөл байх ба үүгээр нь зарим хэсгээр дүйцүүлэн уг ангилалд хамааруулах боломжтой. ГХСОУА-ын англи эхэд уг ангиллыг “TIP for organ removal”⁶⁶ буюу “эрхтэн авах зорилгоор хүнийг худалдаалах” хэмээн бичсэн байна. Иймд уг агуулгаар хэрэглэх нь зүйтэй ба “шилжүүлэх” гэсэн нэмэлт ухагдахуун оруулж болохгүй. Учир нь хүний эрхтнийг авахдаа өөр этгээдэд шилжүүлэх зорилготой байж болох ч бүх эрхтэн авах хэрэг нь өөр этгээдэд шилжүүлэх зорилгогүй ба зарим тохиолдолд цуглуулах зорилготой ч байдаг.</p>

⁶⁶ Ibid, p 43

№ Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томъёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томъёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
37 III	02044	<p>Өөр бусад зорилгоор хүн худалдаалах</p> <p><u>ГХСОУА-д:</u></p> <p>Мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах 02041-02043 дугаарт тодорхойлж, ангилаагүй бусад хэлбэр уг ангилалд хамаарна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u></p> <p>13.1 дүгээр зүйл. Хүн худалдаалах (13.1.1)</p>	<p>TIP for other purposes</p> <p>МУ-ын ЭХ-д хүн худалдаалах гэмт хэргийг зорилго тус бүрээр нь нарийвчлан бие даасан гэмт хэрэг болгон хуульчлаагүй ба нийтэд нь 13.1.1-д хуульчилсан. ЭХ-ийн 13.1.1-д “биеийг үнэлүүлэх, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил нөхцөлд байлгах” зорилгыг хуульчилсан ба эдгээр нь уг ангиллын өөр бусад гэсэн ангилалд хамаарна.</p>
38 II	0205	<p>Албадлага</p> <p><u>ГХСОУА-д:</u></p> <p>Хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлж зарим нэг мэдээллийг олж авах, илчлэх, нэр төрийг нь гутаана хэмээн сүрдүүлэх замаар тодорхой ажиллагаа хийхийг шаардах хэрэг хамаарна</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u></p> <p>13.5 дугаар зүйл. Заналхийлэх (13.5 .1)</p>	<p>Coercion</p> <p>МУ-ын ЭХ-д Албадлага гэсэн гэмт хэрэг байхгүй ч 13.5.1-д “Бусдыг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг шаардаж өөрт нь, түүний ойр дотнын хүнд хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь хохирол учруулж болохуйц баримт, мэдээлэл тараахаар сүрдүүлсэн” гэсэн нөхцөл байдаг учир уг нөхцөлөөр нь дүйцүүлэх боломжтой.</p>
39 III	02051	<p>Дарамтлах эсвэл айлган сүрдүүлэх</p> <p><u>ГХСОУА-д:</u></p> <p>Тодорхой шаардлагыг амаар болон бичгээр тавьж айлган сүрдүүлсэн болон дарамталсан хэргүүд уг ангилалд хамаарна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u></p> <p>13.5 дугаар зүйл. Заналхийлэх (13.5.1)</p>	<p>Extortion or blackmail</p> <p>МУ-ын ЭХ-д Албадлага гэсэн гэмт хэрэг байхгүй ч 13.5.1-д “Бусдыг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг шаардаж өөрт нь, түүний ойр дотнын хүнд хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь хохирол учруулж болохуйц баримт, мэдээлэл тараахаар сүрдүүлсэн” гэсэн нөхцөл байдаг учир уг нөхцөлөөр нь дүйцүүлэх боломжтой.</p>

№	Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томьёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томьёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
40	III	02059	Албадлагын бусад хэлбэр <u>ГХСОУА-д:</u> 02051-д тодорхойлж, ангилаагүй албадлагын бусад хэлбэр <u>МУ-ын ЭХ-д:</u> Уг ангилалд хамаарах гэмт хэрэг байхгүй байна.	Other acts of coercion -
41	II	0206	Анхаарал, хайхрамжгүй байдал <u>ГХСОУА-д:</u> Болгоомжгүйгээр болон болгоомжгүй байдлаас үүдэн хүний бие махбодод гэмтэл учруулах хэргүүд хамаарна. <u>МУ-ын ЭХ-д:</u> 16.11 дүгээр зүйл. Хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх (16.11.1)	Negligence МУ-ын ЭХ-ийн 16.11.1-д заасан гэмт хэргийг гэм буруугийн болгоомжгүй хэлбэрээр үйлдэгдсэн гэж үзнэ. Иймд үүнийг уг ангилалд зарим хэсгээр дүйцүүлэн хамааруулж болно. ГХСОУА-ын англи эхэд уг ангиллыг “Negligence” ⁶⁷ буюу “болгоомжгүй байдал” хэмээн бичсэн байна. Иймд уг агуулгаар хэрэглэх нь зүйтэй ба анхаарал хайхрамжгүй гэх ухагдахуун эрүүгийн эрх зүйд байхгүй юм.
42	III	02061	Асрамжид байгаа хүнд хайхрамжгүй хандах <u>ГХСОУА-д:</u> Хуулиар асран хамгаалах болон харгалзан дэмжих үүрэг хүлээсэн этгээд асран хамгаалалтад байгаа этгээдэд болгоомжгүй хандаж бие махбодод нь гэмтэл, хор хөнөөл учруулах үйлдэл хамаарна. <u>МУ-ын ЭХ-д:</u> Уг ангилалд хамаарах гэмт хэрэг алга байна.	Negligence in situations of persons under care ГХСОУА-ын англи эхэд уг ангиллыг “Negligence in situations of persons under care” ⁶⁸ буюу “үүрэг хүлээсэн этгээдийн болгоомжгүй байдал” хэмээн бичсэн байна. Иймд уг агуулгаар хэрэглэх нь зүйтэй.

⁶⁷ Ibid, p 43

⁶⁸ Ibid, p 44

№ Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томъёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томъёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
43 IV 020611		<p>Асрамжид байгаа хүүхдэд хайхрамжгүй хандах</p> <p><u>ГХСОУА-д:</u></p> <p>Хуулиар асран хамгаалах болон харгалзан дэмжих үүрэг хүлээсэн этгээд асран хамгаалалтад байгаа хүүхдэд болгоомжгүй хандаж бие махбодод нь гэмтэл, хор хөнөөл уруулах үйлдэл хамаарна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u></p> <p>Уг ангилалд хамаарах гэмт хэрэг байхгүй.</p>	<p>Negligence in situations of children under care</p> <p>МУ-ын ЭХ-ийн 16.11.1-д “Хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх” гэх гэмт хэргийг хуульчилсан хэдий ч уг хэрэг нь асран хамгаалах үүргээ биелүүлээгүй санаатай үйлдлийн улмаас болгоомжгүй хохирол үүссэн гэм буруугийн холимог хэлбэртэй байна. Гэтэл уг ангилал нь болгоомжгүй үйлдлийн улмаас асран хамгаалж буй хүүхдэд хохирол учруулах агуулгатай учир дээрх гэмт хэрэг уг ангилалд хамаарахгүй юм.</p> <p>ГХСОУА-ын англи эхэд уг ангиллыг “Negligence in situations of children under care”⁶⁹ буюу “асран хамгаалж байгаа хүүхдэдээ болгоомжгүй хандах” хэмээн бичсэн байна. Иймд уг агуулгаар хэрэглэх нь зүйтэй.</p>
44 IV 020612		<p>Асрамжид байгаа бусад хүмүүст хайхрамжгүй хандах</p> <p><u>ГХСОУА-д:</u></p> <p>Хуулиар харгалзан дэмжих үүрэг оногдуулсан, эвсэл асран хамгаалах үүрэг бүхий этгээд уг үүрэгтээ болгоомжгүй хандсаны улмаас насанд хүрсэн этгээдийн бие махбодод гэмтэл учрах, эсвэл хор хөнөөлд хүргэх</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u></p> <p>Уг ангилалд хамаарах гэмт хэрэг алга байна</p>	<p>Negligence in situations of other dependent persons under care</p> <p>МУ-ын ЭХ-д ийм гэмт хэрэг байхгүй бөгөөд харгалзан дэмжиж асран хамгаалж байгаа этгээдэд болгоомжгүй хандаж биед нь гэмтэл учруулах тохиолдол нь гэмтлийн зэргээс хамаарч Хүний биед гэмтэл учруулах хэрэгт хамаарна.</p> <p>Нэр томъёоны хувьд ГХСОУА-ын англи эхэд уг ангиллыг “Negligence in situations of other dependent persons under care”⁷⁰ буюу “асран хамгаалж байгаа бусад этгээдэд болгоомжгүй хандах” хэмээн бичсэн байна. Иймд уг агуулгаар нь явах нь зүйтэй.</p>

⁶⁹ Ibid, p 44⁷⁰ Ibid, p 44

№	Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НУБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томъёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томъёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
45	IV	020619	<p>Асрамжид байгаа этгээддээ бусад нөхцөл байдалд хайхрамжгүй хандах</p> <p><u>ГХСОУА-д:</u></p> <p>Хуулиар хүлээсэн харгалзан дэмжих болон асран хамгаалах үүрэгтээ болгоомжгүй хандсаны улмаас хүний бие махбодод гэмтэл болон хор хөнөөл бий болгосон 020611-020612 дугаар ангилалд хамаараагүй бусад хэлбэр.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u></p> <p>Уг ангилалд хамаарах гэмт хэрэг алга байна.</p>	<p>Other negligence in situations of persons under care</p> <p>-</p>
46	III	02062	<p>Албан ажилдаа хайнга хандах</p> <p><u>ГХСОУА-д:</u></p> <p>Албан тушаалтан албан үүргээ биелүүлээгүйн улмаас хүний биед гэмтэл, хор хөнөөл учрах үйлдэл хамаарна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u></p> <p>15.1 дүгээр зүйл. Эмнэлгийн тусламж үзүүлэхгүй байх (15.1.1)</p> <p>23.5 дугаар зүйл. Хайнга хандах (23.5.1)</p>	<p>Professional negligence</p> <p>Уг ангилалд албан үүргээ биелүүлээгүй нийт гэмт хэрэг хамаарах юм. Гэхдээ “negligence” буюу хайнга хандах хэмээн бичсэнээс үзвэл болгоомжгүй үйлдэл хамаарна хэмээн дүгнэж болохоор байна. Харин санаатай хэрэг нь шууд бусдын биед гэмтэл учруулах хэргийн тохирох зүйл ангид хамаарах учиртай.</p> <p>Уг ангилалд ЭХ-ийн 23.5.1-д заасан гэмт хэрэг бүрэн хэмжээгээр дүйцэх бол 15.1.1-д заасан гэмт хэргийн “зохих ёсоор биелүүлээгүй” гэсний болгоомжгүй хэлбэрийг зарим хэсгээр дүйцүүлэн хамааруулах боломжтой.</p>

№	Хамаарах түүвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томъёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томъёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
47	III	02063	<p>Тээврийн хэрэгслийг хайхрамжгүй жолоодох</p> <p><u>ГХСОУА-д:</u></p> <p>Тээврийн хэрэгсэл жолоодох үедээ анхаарал болгоомжгүй байснаас хүний биед гэмтэл, хохирол учруулах үйлдэл хамаарна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u></p> <p>27.10 дугаар зүйл. Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих (27.10.1,2,3)</p> <p>27.11 дүгээр зүйл. Авто тээврийн гэмт хэрэг үйлдсэн жолооч зугтаах (27.11.1)</p>	<p>Negligence related to driving a vehicle</p> <p>Тухайн ангилалд тээврийн хэрэгсэл жолоодох явцдаа анхаарал болгоомжгүй байснаас бусдын биед гэмтэл учруулах хэргүүд хамаарахаас гадна санаатай үйлдэл болох Авто тээврийн гэмт хэрэг үйлдсэн жолооч зугтах гэмт хэрэг мөн хамаарахаар байна.</p> <p>МУ-ын ЭХ-ийн 27.10.1, 27.10.2.3, 27.11.1-ийг уг ангилалд бүрэн хэмжээгээр дүйцүүлнэ.</p>
48	III	02069	<p>Бусад анхаарал, хайхрамжгүй үйлдэл</p> <p><u>ГХСОУА-д:</u></p> <p>Анхаарал болгоомжгүй байдлаас хүний бие махбодод гэмтэл, хохирол учруулах 02061-02063 дугаарт ангилагдаагүй бусад үйлдэл.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u></p> <p>15.2 дугаар зүйл. Аюултай байдалд орхих, тусламж үзүүлэхгүй байх (15.2.1)</p> <p>27.9 дүгээр зүйл. Замын байгууламжийн ашиглалт, засварын аюулгүй байдлын журам зөрчих (27.9.1)</p>	<p>Other acts of negligence</p> <p>ГХСОУА-д зааснаар уг ангилалд гэмтэж, бэртсэн хүнд тусламж үзүүлэх үүргээ биелүүлээгүй, явган зорчигчийн анхаарал болгоомжгүй байдлаас үүдэлтэй хэрэг хамаарахаар байна.</p> <p>МУ-ын ЭХ-д 15.2.1 болон 27.9.1-д заасан хэргүүдийг уг ангилалд бүрэн хэмжээгээр дүйцүүлэн хамааруулахаар байна.</p>

№	Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томьёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томьёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
49	II	0207	<p>Аюултай үйлдэл</p> <p><u>ГХСОУА-д:</u> Бусдын биед хохирол учруулах, аюултай гэдгийг мэдсээр байж хийсэн хэргийн улмаас бусдын биед гэмтэл, хохирол учруулсан үйлдэл хамаарна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u> 11.1 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах (11.1.1) 11.4 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах (11.4.1) 11.6 дугаар зүйл. Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах (11.6.1) 15.6 дугаар зүйл. Бусдын амь насанд аюул учруулж болзошгүй халдварт өвчин, дархлал хомсдолын вирус халдаах(15.6.1) 27.10 дугаар зүйл. Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих (27.10.2.1, 27.10.4.1)</p>	<p>Dangerous acts</p> <p>Уг ангиллын агуулгаас үзэхэд аюултай нөхцөл байдал үүсгэсэн хэргүүд уг ангилалд хамаарахаар харагдаж байна.</p> <p>МУ-ын ЭХ-ийн 15.6.1, 27.10.2.1, 27.10.4.1-д заасан хэргүүд уг ангилалд бүрэн хэмжээгээр дүйцэх бол 11.1.1, 11.4.1, 11.6.1-д заасан хэргүүдийг зарим хэсгээр дүйцүүлж болохоор байна.</p>

№	Хамаарах түүвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томъёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томъёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
50	III 02071	<p>Эрүүл мэндэд аюултай үйлдэл</p> <p><u>ГХСОУА-д:</u></p> <p>Аюултай аргаар бусдын эрүүл мэндэд гэмтэл, хохирол учруулсан үйлдэл хамаарна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u></p> <p>11.1 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах (11.1.1)</p> <p>11.4 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах (11.4.1)</p> <p>11.6 дугаар зүйл. Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах (11.6.1)</p> <p>15.6 дугаар зүйл. Бусдын амь насанд аюул учруулж болзошгүй халдварт өвчин, дархлал хомсдолын вирус халдаах(15.6.1)</p>	<p>Acts that endanger health</p> <p>МУ-ын ЭХ-ийн 15.6.1-д заасан гэмт хэрэг уг ангилалд бүрэн хэмжээгээр дүйцэх бол 11.1.1, 11.4.1, 11.6.1-д заасан хэргүүдийг зарим хэсгээр дүйцүүлж болно. Дүйцүүлэх үндэслэл нь 11.1.1, 11.4.1, 11.6.1-д заасан гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд зөвхөн “зэвсэг болон зэвсгийн чанартай зүйл” ашигласан тохиолдлыг хуульчилсан юм. Харин аюултай аргаар гэмтэл, хохирол учруулсан үйлдлийг онцгойлон хуульчлаагүй учир ердийн бүрэлдэхүүндээ орох юм.</p>	
51	III 02072	<p>Сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон үйлдэл</p> <p><u>ГХСОУА-д:</u></p> <p>Сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож бусдын биед гэмтэл, хохирол учруулах.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u></p> <p>27.10 дугаар зүйл. Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих (27.10.2.1, 27.10.4.1)</p>	<p>Operating a vehicle under the influence of psychoactive substances</p> <p>Уг ангилалд сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож бусдын биед гэмтэл, хохирол учруулах үйлдэл хамаарна. Агуулгын хувьд сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох нь орчин тойрондоо аюултай байдал үүсгэж байгаа учир аюултай аргаар үйлдсэн гэмт хэрэг гэж үзнэ.</p> <p>МУ-ын ЭХ-ийн 27.10.2.1, 27.10.4.1-д заасан гэмт хэргийн “мансуурсан” гэсэн нөхцөлийг уг ангилалд зарим хэсгээр дүйцүүлэн хамааруулж болно.</p>	

№	Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томьёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томьёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
52	IV	020721	<p>Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ жолоо барих</p> <p><u>ГХСОУА-д:</u> Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож бусдын биед гэмтэл, хохирол учруулах.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u> 27.10 дугаар зүйл. Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих (27.10.2.1, 27.10.4.1)</p>	<p>Operating a vehicle under the influence of alcohol</p> <p>Уг ангилалд Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож бусдын биед гэмтэл, хохирол учруулах үйлдэл хамаарна. Агуулгын хувьд Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох нь орчин тойрондоо аюултай байдал үүсгэж байгаа учир аюултай аргаар үйлдсэн гэмт хэрэг гэж үзнэ.</p> <p>МУ-ын ЭХ-ийн 27.10.2.1, 27.10.4.1-д заасан гэмт хэргийн “согтуурсан” гэсэн нөхцөлийг уг ангилалд бүрэн хэмжээгээр дүйцүүлж хамааруулна.</p>
53	IV	020722	<p>Мансууруулах бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл ашиглах</p> <p><u>ГХСОУА-д:</u> Мансууруулах бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож бусдын биед гэмтэл, хохирол учруулах.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u> 27.10 дугаар зүйл. Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих (27.10.2.1, 27.10.4.1)</p>	<p>Operating a vehicle under the influence of illicit drugs</p> <p>Уг ангилалд мансууруулах бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож бусдын биед гэмтэл, хохирол учруулах үйлдэл хамаарна. Агуулгын хувьд мансууруулах бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох нь орчин тойрондоо аюултай байдал үүсгэж байгаа учир аюултай аргаар үйлдсэн гэмт хэрэг гэж үзнэ.</p> <p>МУ-ын ЭХ-ийн 27.10.2.1, 27.10.4.1-д заасан гэмт хэргийн “мансуурсан ” гэсэн нөхцөлийг уг ангилалд зарим хэсгээр дүйцүүлэн хамааруулж болно.</p>
54	IV	020729	-	-

№	Хамаарах түүвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томъёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томъёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
55	III	02079	<p>Бусад аюултай үйлдэл</p> <p><u>ГХСОУА-д:</u></p> <p>Бусдад аюул учруулж болох нөхцөл байдалтайгаар биеэ авч явснаас бусдын биед гэмтэл, хохирол учруулсан 02071-02072-т ангилаагүй бусад үйлдэл.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u></p> <p>Уг ангилалд хамаарах гэмт хэрэг алга байна.</p>	<p>Other dangerous acts</p> <p>-</p>
56	II	0208	<p>Айдас, сэтгэл зүйн дарамт буй болгох үйлдэл</p> <p><u>ГХСОУА-д:</u></p> <p>Бусдад айдас, сэтгэл санааны зовуурь үүсгэсэн дарамтын шинжтэй үйлдэл болон үйл ажиллагаа уг ангилалд хамаарна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u></p> <p>13.14 дүгээр зүйл. Худал мэдээлэл тараах (13.14.1)</p>	<p>Acts intended to induce fear or emotional distress</p> <p>Уг ангиллын агуулгаас харахад ажлын байрны дарамт болон бусад хэлбэрээр дарамтлах буюу өөрт ашигтай ямар нэгэн үйлдлийг хийлгэх зорилгоор бусдыг гутаасан, гол төлөв зохиомол мэдээ сэлтийг тараах, задруулахаар айлган сүрдүүлсэн үйлдэл хамаарахаар байна.</p> <p>МУ-ын ЭХ-ийн 13.14.1-д заасан хэргийн “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан” гэсэн шинжээр нь уг ангилалд дүйцүүлэх боломжтой.</p>

№	Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НУБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томьёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томьёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
57	III	02081	<p>Дарамт</p> <p><u>ГХСОУА-д:</u> Хүний доромжилсон болон доромжлох зорилготой аливаа үйлдэл.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u> 13.14 дүгээр зүйл. Худал мэдээлэл тараах (13.14.1)</p>	<p>Harassment</p> <p>Уг ангилалд дарамтлах буюу өөрт ашигтай ямар нэгэн үйлдлийг хийлгэх зорилгоор бусдыг гутаасан, гол төлөв зохиомол мэдээ сэлтийг тараах, задруулахаар айлган сүрдүүлсэн,⁷¹ нэр төрд халдах гэсэн үйлдэл хамаарна.</p> <p>МУ-ын ЭХ-ийн 13.14.1-д заасан хэргийн “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан” гэсэн шинжээр нь уг ангилалд дүйцүүлэх боломжтой.</p>
58	IV	020811	<p>Ажлын байрны дарамт</p> <p><u>ГХСОУА-д:</u> Ажлын орчинд, эсвэл ажил эрхлэлттэй холбоотой хамтран ажиллагч, удирдах ажилтан, өөр бусад албан тушаалтны дарамтын шинжтэй үйлдэл уг ангилалд хамаарна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u> Уг ангилалд хамаарах гэмт хэрэг байхгүй.</p>	<p>Harassment in the workplace</p> <p>-</p>
59	IV	020819	<p>Бусад дарамт</p> <p><u>ГХСОУА-д:</u> Ажлын бус орчинд, эсвэл ажил эрхлэлттэй холбоогүй этгээдийн зүгээс ирэх дарамт</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u> Уг ангилалд хамаарах гэмт хэрэг байхгүй.</p>	<p>Other harassment</p> <p>-</p>

⁷¹ Нарангэрэл С. Эрх зүйн эх толь бичиг. Уб., 2015. 168 дахь тал

№	Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томъёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томъёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
60	III	02082	<p>Мөрдөж, мөшгөх</p> <p><u>ГХСОУА-д:</u> Хувь хүнтэй түүний хүсэл зоригоос гадуур харилцаа үүсгэх, мөрдөн мөшгөх үйлдэл хамаарна</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u> 13.12 дугаар зүйл. Хууль бусаар мөрдөж мөшгөх (13.12.1)</p>	<p>Stalking</p> <p>Уг ангиллын агуулгаас харахад хүний бие махбодод халдахгүйгээр түүнтэй харилцаж эсвэл мөрдөн мөшгөсөн үйлдэл уг ангилалд орохоор байна.</p> <p>МУ-ын ЭХ-ийн 13.12.1-д заасан хэрэг уг ангилалд бүрэн хэмжээгээр дүйцнэ.</p>
61	III	02089	<p>Сэтгэл санааны зовлон, айдасг хүргэх бусад үйлдэл</p> <p><u>ГХСОУА-д:</u> 02081-02082-т тодорхойлж, ангилаагүй бусад хэлбэрийн биеэ авч явах байдал, үүнээс улбаатай айдас, сэтгэл санааны зовуурь үүсгэх хэрэг уг ангилалд хамаарна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u> Уг ангилалд хамаарах гэмт хэрэг байхгүй.</p>	<p>Other acts intended to induce fear or emotional distress</p> <p>-</p>
62	II	0209	<p>Нэр төр гутаах, доромжлох</p> <p><u>ГХСОУА-д:</u> Хүний өөртөө итгэх итгэлийг бууруулсан, дайсагнасан эсвэл тийм мэдрэмж өдөөсөн аман болон бусад хэлбэрээр нэр төр, алдар хүнийг гутаан доромжилсон үйлдэл хамаарна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u> 14.1 дүгээр зүйл. Ялгаварлан гадуурхах (14.1.1) 14.8 дугаар зүйл. Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах (14.8.1) 19.9 дүгээр зүйл. Үндэсний эв нэгдлийг бусниулах (19.9.1)</p>	<p>Defamation or insult</p> <p>ГХСОУА-д зааснаар уг ангилалд Хов жив, гүтгэлэг, доромжлох, гүжирдэх, тохуурхах зэрэг үйлдэл хамаарахаар байна.</p> <p>МУ-ын ЭХ-д заасан 14.1.1, 14.8.1, 19.9.1-д заасан хэргүүд уг ангилалд хамаарна.</p>

№	Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томьёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томьёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
63	III	02091	<p>Хохирогчийн шинж чанараас хамаарч нэр төрийг нь гутаах, доромжлох</p> <p><u>ГХСОУА-д:</u> Хохирогчийн өвөрмөц шинж чанарын улмаас нэр төрийг нь доромжлох, нэр төрийг гутаах.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u> Уг ангилалд хамаарах гэмт хэрэг байхгүй.</p>	<p>Defamation or insult due to the victim's characteristics or ascribed attributes</p> <p>-</p>
64	III	02092	<p>Хохирогчийн итгэл үнэмшил, үнэт зүйлсийг нь гутаан доромжлох</p> <p><u>ГХСОУА-д:</u> Хохирогчийн өвөрмөц шинж чанар буюу шашин шүтлэг, улс төр, эдийн засгийн ба нийгмийн үзэл бодлоор нь доромжлох, нэр төрийг гутаах, доромжлох хэрэг хамаарна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u> 14.8 дугаар зүйл. Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах (14.8.1)</p>	<p>Defamation or insult due to the victim's ascribed beliefs or values</p> <p>Уг ангилалд хохирогчийн хувийн шинж байдалтай холбоотойгоор нэр төр, алдар хүндийг нь гутаасан хэрэг хамаарна.</p> <p>МУ-ын ЭХ-ийн 14.8.1 “Сонгуульд оролцогч улс төрийн нам, намуудын эвсэл, нэр дэвшигчийн нэр хүндэд халдаж, илт худал мэдээлэл тараасан” гэсэн онцлог шинжээр нь уг ангилалд хамааруулах боломжтой.</p>
65	III	02099	<p>Нэр төр гутаан доромжлох бусад хэлбэр</p> <p><u>ГХСОУА-д:</u> Нэр төр гутаах, доромжлох 02091-02092-т ангилагдаагүй хэргүүд хамаарна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u> Уг ангилалд хамаарах гэмт хэрэг байхгүй.</p>	<p>Other defamation or insult</p> <p>-</p>

№	Хамаарах түүвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томъёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томъёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
66	II	0210	<p>Ялгаварлан гадуурхах</p> <p><u>ГХСОУА-д:</u> Хувь хүн буюу бүлгийн арьсны өнгө, нас, хүйс, хэл, шашин шүтлэг, үзэл бодол, үндэсний буюу угсаатны гарал үүслээр нь ялгаварлан гадуурхах, хасах, хязгаарлах, хууль бусаар авч үзэх, эсвэл давуу эрхтэй болгох үйлдэл хамаарна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u> 14.1 дүгээр зүйл. Ялгаварлан гадуурхах (14.1.1.) 19.9 дүгээр зүйл. Үндэсний эв нэгдлийг бусниулах (19.9.1)</p>	<p>Discrimination</p> <p>Агуулгын хувьд уг ангилалд хүний итгэл үнэмшил, үнэт зүйлс болон атрибут шинж чанараар нь алагчлах, хэсэг бүлгээр нь алагчлах үйлдэл хамаарна.</p> <p>МУ-ын ЭХ-ийн 14.1.1, 19.9.1-д заасан хэргүүд уг ангилалд бүрэн хэмжээгээр дүйцнэ.</p>
67	III	02101	<p>Хувь хүнийг ялгаварлан гадуурхах</p> <p><u>ГХСОУА-д:</u> Уг ангилалд хүнийг алагчлах болон хүнийг хууль бусаар авч үзэх үйлдэл хамаарна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u> 14.1 дүгээр зүйл. Ялгаварлан гадуурхах (14.1.1)</p>	<p>Personal discrimination</p> <p>Агуулгын хувьд уг ангилалд хүнийг хөдөлмөр эрхлэлт, цалин хөлс, орон сууцны байдлаар нь ялгаварлан гадуурхах үйлдэл хамаарна.</p> <p>МУ-ын ЭХ-ийн 14.1.1-д заасан хэргийн “эрхэлсэн ажил. нөхцөл байдлаар ялгаварлан гадуурхаж эрх, эрх чөлөөг нь хязгаарласан бол” гэх хэсэг уг ангилалд хамаарах учир зарим хэсгээр дүйцүүлэх боломжтой.</p>
68	III	02102	<p>Хэсэг бүлгээр ялгаварлан гадуурхах</p> <p><u>ГХСОУА-д:</u> Хамт олон хэсэг бүлгээр нь ялгаварлан гадуурхах ба хууль бусаар харьцах үйлдэл хамаарна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u> 19.9 дүгээр зүйл. Үндэсний эв нэгдлийг бусниулах (19.9.1)</p>	<p>Group discrimination</p> <p>Уг ангиллын агуулгаас үзэхэд хүний хувийн шинж чанараас бус хэсэг бүлэг хүмүүсийн нийтлэг ижил зүйлээр нь ялгаварлан гадуурхах үйлдэл хамаарахаар байна.</p> <p>МУ-ын ЭХ-ийн 19.9.1 дүгээр зүйлд “Хүмүүсийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, шашны номлол, үзэл бодлоор дайсагнуулах, эвдрэлцүүлэх, салан тусгаарлахыг ухуулсан, уриалсан, ялгаварлан гадуурхсан” гэсэн нөхцөл байх ба уг шинжээр нь уг ангилалд зарим хэсгээр дүйцүүлэн хамааруулна.</p>

№	Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томъёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томъёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
69	III	02109	<p>Бусад ялгаварлан гадуурхалт <u>ГХСОУА-д:</u> Алагчлах, хууль бусаар авч үзэх 02101-02102 дугаар ангилалд хамааруулаагүй үйлдэл хамаарна. <u>МУ-ын ЭХ-д:</u> 14.1 дүгээр зүйл. Ялгаварлан гадуурхах (14.1.1)</p>	<p>Other discrimination Уг ангилалд тухайн бүлэг заагаагүй бусад хэлбэрээр ялгаварлан гадуурхах үйлдэл хамаарах ба МУ-ын ЭХ-ийн 14.1.1-д заасан “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, эрүүл мэндийн нөхцөл байдлаар ялгаварлан гадуурхаж эрх, эрх чөлөөг нь хязгаарласан” үйлдэл хамаарна.</p>
70	II	0211	<p>Хүний эсрэг хууль зөрчсөн үйлдэл <u>ГХСОУА-д:</u> Хувь хүний нууц болон бусад хувийн харилцааны эрхэд халдсан үйлдэл хамаарна. <u>МУ-ын ЭХ-д:</u> 13.8 дугаар зүйл. Зөвшөөрөлгүй гэрэл зураг авах, дуу, дүрс бичлэг хийж дамжуулах, тараах (13.8.1) 13.10 дугаар зүйл. Хувь хүний нууцад халдах (13.10.1) 13.11 дүгээр зүйл. Хувь хүний нууцыг задруулах (13.11.1) 26.1 дүгээр зүйл. Цахим мэдээлэлд хууль бусаар халдах (26.1.1)</p>	<p>Acts that trespass against the person Уг ангиллын агуулгаас харахад хувь хүний нууц болон бие хүний хувийн эрхэд халдсан үйлдэл хамаарна. МУ-ын ЭХ-ийн 13.8.1, 13.10.1, 13.11.1-д заасан хэргүүд уг ангилалд бүрэн хэмжээгээр дүйцэх бол 26.1.1-ийн тохирох хэсгийг зарим хэсгээр дүйцүүлэн хамааруулна.</p>

№ Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томъёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томъёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
71 III	02111	<p>Хувийн нууцад халдах</p> <p><u>ГХСОУА-д:</u> Хувь хүний нууцад халдсан үйлдэл уг ангилалд хамаарна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u> 13.10 дугаар зүйл. Хувь хүний нууцад халдах (13.10.1, 13.10.2.1) 26.1 дүгээр зүйл. Цахим мэдээлэлд хууль бусаар халдах (26.1.1)</p>	<p>Invasion of privacy</p> <p>Уг ангиллын агуулгаас харахад хувийн нууцын эрх, захидал харилцааны нууцын эрхийг зөрчсөн, утас чагнах, ганцаараа байх хүсэл, хувийн асуудалд нь халдах, хувийн компьютерын файлд болон захидал харилцаанд халдсан үйлдэл уг ангилалд хамаарна.</p> <p>МУ-ын ЭХ-ийн 13.10.1-д “Хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг хууль бусаар олж авсан, бусдад дамжуулсан” гэсэн нөхцөл байх ба уг нөхцөлөөр дээрх зүйл анги нь тус ангилалд бүрэн хэмжээгээр дүйцнэ. Мөн тус зүйл ангийн 2.1-т заасан “харилцаа холбоо, цахим хэрэгсэл ашиглаж” үйлдсэн хэрэг уг ангилалд бүрэн хэмжээгээр дүйцэхээр байна.</p> <p>МУ-ын ЭХ-ийн 26.1.1-д “Оршин суугчийн зөвшөөрөлгүйгээр орон байранд, эсхүл гадна талаас орон байрны доторх орчны гэрэл зураг авч, эсхүл дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийж олон нийтэд тараасан, эсхүл бусдад дамжуулсан бол” гэсэн нөхцөл заасан. Ийнхүү зураг авахдаа өөрийг нь оруулсан болон хувийн орон зай болох гэрийн дотор байдлыг харуулсан тохиолдолд уг ангилалд зарим хэсгээр дүйцүүлэх боломжтой.</p>
72 III	02119	<p>Хувь хүний эсрэг хууль зөрчсөн бусад үйлдэл</p> <p><u>ГХСОУА-д:</u> Хувийн нууцад хууль бусаар болон хувийн байдалд зүй бусаар халдсан 02111-д ангилаагүй бусад үйлдэл хамаарна.</p>	<p>Other acts that trespass against the person</p> <p>Уг ангиллын агуулгаас харахад хүүр зэрэмдэглэх, эд эрхтнийг салган авах зорилгоор бие махбодыг хэсэгчлэн худалдах, оршуулга, булш сүйтгэх, хүүрийг хууль бусаар ашиглах гэх мэт нас барсны дараах хувь хүний эрхтэй холбоотой үйлдэл хамаарна.</p>

№	Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан доорх нэр томъёогоор)	Судлаачдаас дэвшүүлж буй нэр томъёоны тодорхойлолт, тайлбарын хувилбар
			<p><u>МУ-ын ЭХ-д:</u> Уг ангилалд хамаарах гэмт хэрэг байхгүй.</p>	<p>2002 оны эрүүгийн хуулийн 129 дүгээр зүйлд Булш сүйтгэх гэсэн гэмт хэрэг байсан хэдий ч 2015 оны шинэ эрүүгийн хуулиар уг гэмт хэргийг эрүүгийн хуулиас хассан.</p>
73	II	0219	<p>Хүнд хохирол учруулсан, хохирол учруулахыг завдсан бусад үйлдэл</p> <p><u>ГХСОУА-д:</u> Хувь хүнд хохирол учруулсан, учруулахыг завдсан 0201-2011 дугаар ангилалд бичигдээгүй бусад үйлдэл үүнд хамаарна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u> Уг ангилалд хамаарах гэмт хэрэг байхгүй.</p>	<p>Other acts causing harm or intending to cause harm to the person</p> <p>НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газраас боловсруулсан “Гэмт хэргийн статистикийн олон улсын ангилал”-ын монгол орчуулгад “хүнд хохирол учруулсан, хохирол учруулахыг завдсан бусад үйлдэл” хэмээн орчуулсан байна. Гэтэл англи эхэд нь “Other acts causing harm or intending to cause harm to the person” хэмээн бичсэн байх ба үүнийг монгол хэлнээ “хүнд хохирол учруулсан болон хохирол учрахад хүргэсэн бусад үйлдэл” хэмээн орчуулж болохоор байна. Англи хэлнээ завдалтыг “Attempt” хэмээх ба ийм ухагдахуун уг ангилалд алга байна. Гэтэл орчуулахдаа завдалт гэсэн ухагдахуун оруулснаар хувь хүнд хохирол учруулсан бүх гэмт хэргийн завдалт уг ангилалд орох нөхцөлийг бий болгосон. Энэ нь ноцтой зөрүү үүсгэж, агуулгын хувьд томоохон алдаанд хүргэж мэдэхээр байна. Тус ангиллын агуулга нь дээрх 2 дугаар ангилалд байхгүй өөр хохирол учруулсан эсвэл учруулах үндсийг бий болгосон төгссөн гэмт хэргийг уг ангилалд хамааруулах санааг илэрхийлсэн байна.</p>

ХАВСРАЛТ 3

ГХСОУ-ЫН 03 АНГИЛЛЫГ МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ДАХЬ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ДҮЙЦҮҮЛСЭН ХУВИЛБАР

№	Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (ГХСОУА-ын доорх нэр томьёо нь НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан хэлбэрээр)	Дүйцүүлсэн хувилбарыг хэрхэн нөхөх талаар судлаачдаас дэвшүүлж буй тайлбар болон заавар
1	I	03	<p>Бэлгийн шинж чанартай хохирол учруулсан үйлдэл. 0301, 0302, 0309</p> <p><u>ГХСОУА-д:</u> 1-р түвшний энэхүү ангилал нь 2-р түвшний Бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг, хүний биед хохирол учруулсан бэлгийн шинжтэй бусад гэмт хэргийг хамаарч дүйцэхээр ойлгогдож байна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u> 12 дугаар бүлэг. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг. 16 дугаар зүйл. Хүүхдийн эсрэг гэмт хэрэг</p>	<p>Injurious acts of a sexual nature. ГХСОУ-ын 03 дугаар ангилалд Бэлгийн шинжтэй хохирол учруулсан буюу хүчин, бэлгийн дарамт, бэлгийн мөлжлөг, бэлгийн шинжтэй бусад гэмт хэргүүд хамаарч байна.</p> <p>03 дугаар ангилалд дурдсан гэмт хэргийг МУ-ын ЭХ-д дүйцүүлэхдээ 08 дугаар ангилалд дурдсан зарим ойролцоо төрлийн гэмт хэргээс хэрхэн зааглан ангилж⁷² дүйцүүлэх болон нөхөх асуудал чухал байна.</p> <p>Нэр томьёоны хувьд Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг гэх нэршлээр ойлгож, хэрэглэх нь зохистой.</p>

⁷² 08 дугаар ангиллыг судалсны дараа 03 дугаар ангилалд дурдсан зарим гэмт хэргийн дүйцэлд өөрчлөлт орох талтай. Учир нь тус судалгааны ажлын хүрээ нь 01-03 дугаар ангиллын хүрээгээр хязгаарлагдаж буй. Энэхүү судалгааны ажил нь ГХСОУ-ын 01-11 дүгээр ангиллыг судалж буй үргэлжилсэн ажлын хамгийн эхний ажил болж буй тул тодорхой үе шаттайгаар, 11 төрлийн багц ангилал судлагдаж дууссаны дараа ойролцоо төрлийн агуулгатай ангиллуудыг дүйцүүлсэн хувилбар бүрэн дууссаны дараа тус хүснэгтэд дахин өөрчлөлт орж болзошгүй юм.

№	Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (ГХСОУА-ын доорх нэр томъёо нь НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан хэлбэрээр)	Дүйцүүлсэн хувилбарыг хэрхэн нөхөх талаар судлаачдаас дэвшүүлж буй тайлбар болон заавар
2	II	0301	<p>Бэлгийн хүчирхийлэл. 03011, 03012, 03019</p> <p><u>ГХСОУА-д:</u> ГХСОУ-ын 2-р түвшний энэхүү ангилал нь Хүчин, үүн дотроо хүч хэрэглэн эсвэл хүч хэрэглэхгүйгээр хүчиндэх, насанд хүрээгүй хүүхдийг хүчиндэх, бусад төрлийн хүчингийн гэмт хэргийг хамааруулсан агуулгатай байна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u> 12.1. Хүчиндэх ЭХ-ийн 12.1.1, 12.1.2 дахь хэсэгт заасан мөн 12.1.3 дахь хэсэг, 12.1.4 дэх хэсгээс зөвхөн “ энэ гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн” хамаарах гэмт хэргийг ГХСОУ-ын энэхүү ангилалд дүйцүүлж болохоор байна.</p>	<p>Sexual violence.</p> <p>Тодорхой төрлийн гэмт хэрэг нь ЭХ-ийн зүйл, хэсгийн дүнгээр гарч хэвшсэн тул нөхөхөд хүндрэл үүсэхгүй, нэмэлт үзүүлэлт, дата шаардлагагүй.</p> <p>Тайлан, мэдээллийн маягтын 12.1.1 болон 12.1.2 дахь хэсэг, 12.1.3 дахь хэсэг бүрэн хэмжээнд, 12.1.4 дэх хэсгийг зарим хэсгээр дүйцүүлэн нөхнө.</p>
3	III	03011	<p>Хүчин. 030111, 030112, 030113, 030119</p> <p><u>ГХСОУА-д:</u> 3-р түвшний энэхүү ангилалд Хүч хэрэглэн хүчиндэх, Хүч хэрэглэхгүйгээр хүчиндэх, Насанд хүрээгүй хүүхдийг хүчиндэх, мөн Бусад төрлийн хүчингийн гэмт хэргүүдийг хамааруулан ойлгохоор байна.</p>	<p>Варе.</p> <p>ЭХ-ийн 12.1 нь ерөнхий агуулгаараа энэ ангилалд дүйцэхээр байгаа ч бүхэлдээ энэ ангилалд дүйцэж, нөхөгдөхөөргүй байгааг анхаарах шаардлагатай.</p> <p>Тухайлбал, 12.1.1-д заасан агуулгаас “...эсхүл бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн” гэх үйлдэлд хамаарах агуулга нь энэхүү ангилалд бус 03019 дүгээр ангиллын агуулгад илүү дүйцэж байх тул 12.1.1-ийн агуулгаар бүхэлд нь дүйцүүлэн нөхөх боломжгүй байна.</p>

№ Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (ГХСОУА-ын доорх нэр томьёо нь НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан хэлбэрээр)	Дүйцүүлсэн хувилбарыг хэрхэн нөхөх талаар судлаачдаас дэвшүүлж буй тайлбар болон заавар
		<p>Ангиллын дээрх агуулгаас харахад Хүчин гэсэн гэмт хэрэгт хамаарах үйлдлийг хүч хэрэглэсэн, эсвэл хэрэглээгүй гэдэг шинжээр нь ялгаж ангилж байгаа нь анхаарал татаж байна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u></p> <p>12.1. Хүчиндэх</p> <p>12.1.1 (зарим хэсгээр), 12.1.2.1, 12.1.2.2, 12.1.2.3, 12.1.2.4, 12.1.2.5, 12.1.2.6, 12.1.2.7, 12.1.2.8, 12.1.2.10, 12.1.3, 12.1.4(зарим хэсгээр).</p> <p>ЭХ-ийн 12.1 дүгээр зүйлийн дээр дурдсан хэсэг, заалтууд хамаарах бөгөөд ингэхдээ зарим зүйл, хэсэг, заалт нь ЭХ-д заасан бүрэн агуулгаараа бус аль нэг үйлдэл, хэм хэмжээний тодорхой нөхцөлд хамаарах агуулгаар нь тусад нь салгаж байж энэхүү ангилалд дүйцүүлэхээр байна.</p>	<p>Иймд тоон мэдээллийг нөхөх үедээ 3-р түвшний энэхүү ангиллын задаргаа ангилал болох 030111, 030112, 030119 ангиллын нийлбэр дүнгээр нөхөх нь логик хамаарал болоод арга зүйн хувьд илүү оновчтой байна.</p> <p>Нэр томьёоны хувьд Хүчиндэх гэмт хэрэг гэх нэршлээр ойлгож, хэрэглэх нь зохистой байна.</p>

№ Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (ГХСОУА-ын доорх нэр томъёо нь НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан хэлбэрээр)	Дүйцүүлсэн хувилбарыг хэрхэн нөхөх талаар судлаачдаас дэвшүүлж буй тайлбар болон заавар
4	IV 030111	<p>Хүч хэрэглэн хүчиндэх.</p> <p><u>ГХСОУА-д:</u> Хохирогчийн зөвшөөрөлгүй хүч хэрэглэн бэлгийн харьцаанд орохыг ойлгохоор заасан байна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u> 12.1. Хүчиндэх 12.1.1. Хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл сэтгэцийн өвчтэй, согтуурсан, мансуурсан, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, бусад өвчний улмаас биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй, эсхүл эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгааг далимдуулан хүчээр бэлгийн харьцаанд орсон ... 12.1.2. Энэ гэмт хэргийг: 12.1.2.2. бүлэглэж; 12.1.2.3. гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндэж; 12.1.2.4. хохирогчийг жирэмсэн болгож; 12.1.2.5. хохирогчид бэлгийн замын халдварт өвчин халдааж; 12.1.2.6. хоёр, түүнээс олон хүнийг хүчиндэж; 12.1.2.7. урьд нь энэ бүлэгт заасан гэмт хэргийг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн;</p>	<p>Rape with force.</p> <p>ЭХ-ийн дараах зүйл, хэсэг, заалтын нийлбэр дүнгээр энэ ангиллыг дүйцүүлэн нөхөхөөр байна. Үүнд: ЭХ-ийн 12.1.1 дүгээр хэсэг. (зарим хэсгээр) ЭХ-ийн 12.1.2 дахь хэсгээс 12.1.2.2, 12.1.2.3, 12.1.2.4, 12.1.2.5, 12.1.2.6, 12.1.2.7, 12.1.2.8, 12.1.2.10 дахь заалтууд (бүрэн хэмжээнд) ЭХ-ийн 12.1.1 дэх заалтад “... эсхүл бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн” гэх үйлдлийг заасан байна. Энэ нь бэлгийн харьцаанд ороогүй ч хүч хэрэглэсэн бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл хийсэн байх агуулгаар ойлгогдож байна. Иймд энэ үйлдэл нь 030111 ангиллын “хүчиндэх” агуулгатай дүйцэхээс илүүтэйгээр 03019 ангилал буюу “Бэлгийн хүчирхийллийн бусад төрөл”-д хамаарч болох юм. Иймд 12.1.1 дэх хэсэг нь зарим хэсгээр энэхүү ангилалд дүйцэн нөхөгдөх боломжтой байна.</p>

№ Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (ГХСОУА-ын доорх нэр томьёо нь НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан хэлбэрээр)	Дүйцүүлсэн хувилбарыг хэрхэн нөхөх талаар судлаачдаас дэвшүүлж буй тайлбар болон заавар
		<p>12.1.2.8. харгис хэрцгий аргаар;</p> <p>12.1.2.10. хохирогчийг тохуурхан доромжилж үйлдсэн;</p> <p>12.1.3. Энэ гэмт хэргийн улмаас ураг зулбасан, эсхүл арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон; гэр бүлийн хамаарал бүхий арван зургаан насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн.</p> <p>Энэ ангилалд ЭХ дахь дээр дурдсан гэмт хэргийг дүйцүүлэх боломжтой байна.</p> <p>Харин 12.1.1-д заасан “... эсхүл бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн”⁷³ гэх үйлдлийг хэрхэн ойлгож, тодорхойлохоос хамаараад энэ үйлдэл ГХСОУ-ын аль ангилалд хамаарах нь тодорхой болохоор байна.</p>	

⁷³ Үгийн шууд утгаас харахад энэ үйлдэл нь ГХСОУ-ын 030111 ангилалд хамаарахгүй байх тул хүснэгтэд ЭХ-ийн холбогдох хэсгийг дүйцүүлэхдээ энэхүү үйлдлийг 12.1.1 дэх хэсгийн бичвэрээс хассан болно.

№ Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (ГХСОУА-ын доорх нэр томъёо нь НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан хэлбэрээр)	Дүйцүүлсэн хувилбарыг хэрхэн нөхөх талаар судлаачдаас дэвшүүлж буй тайлбар болон заавар
5	IV 030112	<p>Хүч хэрэглэхгүйгээр хүчиндэх.</p> <p><u>ГХСОУА-д:</u></p> <p>ГХСОУ-ын энэ ангилал дахь агуулгыг харахад ер нь хохирогчийг төөрөлдүүлэх замаар, эсвэл мансуурсан үед, эсвэл харилцан тохиролцсон эсэхээс үл хамаараад хүч хэрэглэхгүйгээр бэлгийн харилцаанд орсон үйлдлийг хамааруулахаар заасан байна. Мөн түүнчлэн “бага насны хүүхдийг хүчиндэх” гэмт хэрэг нь энэ ангилалд хамаарахгүй талаар тайлбар хэсэгт дурдсан байгааг анхаарах шаардлагатай байна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u></p> <p>12.5 дугаар зүйл. Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох</p> <p>12.5-д заасан гэмт хэрэг нь хүч хэрэглэхгүйгээр бэлгийн харилцаанд орох агуулгатай тул энэ зүйлд заасан гэмт хэргийг энэ ангилалд дүйцүүлэх боломжтой байж болох юм.</p>	<p>Rape without force.</p> <p>Энэ ангилалд “бага насны хүүхдийг хүчиндэх” гэмт хэрэг хамаарахгүй гэсэн тайлбар⁷⁴ байх тул ЭХ-ийн 12.5-д заасан гэмт хэргийг энэ ангилалд дүйцүүлж нөхөх боломжгүй байна.</p> <p>Харин практикт ЭХ-ийн 12.5-д хамаарахгүй, хүч хэрэглэхгүйгээр бэлгийн харилцаанд орсон тохиолдолд гэмт хэрэг гэж үздэг эсэх, ийм тохиолдолд хэрхэн зүйлчилдэг талаар судлах шаардлагатай.</p>

⁷⁴ ICCS_English_2016_web.pdf. p 50

№ Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (ГХСОУА-ын доорх нэр томьёо нь НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан хэлбэрээр)	Дүйцүүлсэн хувилбарыг хэрхэн нөхөх талаар судлаачдаас дэвшүүлж буй тайлбар болон заавар
6	IV 030113	<p>Насанд хүрээгүй хүүхдийг хүчиндэх.</p> <p><u>ГХСОУА-д:</u></p> <p>Насанд хүрээгүй хүүхдийн зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүйгээр хүчиндсэн үйлдлийг ойлгохоор заасан байна.⁷⁵</p> <p>Дээрх тодорхойлолтоос нэг талаас харахад хүч хэрэглэсэн эсэх, нөгөө талаас хохирогч зөвшөөрсөн эсэхээс үл хамаараад хохирогчийн өөрийн шинж байдал болох насанд хүрээгүй байх шинжийг голлон энэхүү ангиллыг боловсруулж гаргасан байдлаар ойлгогдож байна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u></p> <p>12.1.2.1. арван дөрвөөс дээш арван найман насанд хүрээгүй хүнийг хүчиндэж;</p> <p>12.1.3. Энэ гэмт хэргийн улмаас ураг зулбасан, эсхүл арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон; гэр бүлийн хамаарал бүхий арван зургаан насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн;</p> <p>12.1.4. Энэ гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн, энэ гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан.</p>	<p>Statutory rape.</p> <p>ЭХ-ийн 12.1.2.1-д заасан шинж нь дангаараа насанд хүрээгүй хүнийг хүчиндэх гэмт хэрэг байх тул маягтад дурдсан энэ үзүүлэлтээс хасалт хийхгүйгээр ГХСОУ-ын энэ ангиллыг нөхөх боломжтой байна.</p> <p>Харин 12.1.3-т заасан “Энэ гэмт хэргийн улмаас ураг зулбасан” гэх үр дагавар нь агуулгаараа ГХСОУ-ын энэ ангилалд хамаарахгүй байх тул 12.1.3 дахь үзүүлэлтээс тусад нь “арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон; гэр бүлийн хамаарал бүхий арван зургаан насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн” гэх үйлдлийг буюу зөвхөн насанд хүрээгүй хүнд хамаарах хэсгийг тусад нь үзүүлэлт болгон нөхөх шаардлагатай байна.</p> <p>Мөн 12.1.4-т заасан “энэ гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан” гэх үр дагавар нь мөн л ГХСОУ-ын энэхүү ангиллын агуулгад хамаарахгүй байх тул зөвхөн “энэ гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн” гэх шинжийг буюу зөвхөн насанд хүрээгүй хүнд хамаарах хэсгийг тусад нь үзүүлэлт болгон нөхөх шаардлагатай.</p> <p>Дээр дурдсан МУ-ын ЭХ-ийн 12.1.2.1, 12.1.3, 12.1.4-т заасан гэмт хэргээс дээр дурдсан нөхөх тайлбарын дагуу гарган авсан тоон мэдээллийн нийлбэр дүнгээр ГХСОУ-ын энэхүү ангиллыг дүйцүүлэн нөхөх боломжтой.</p>

⁷⁵ Ibid, p 50

№	Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (ГХСОУА-ын доорх нэр томъёо нь НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан хэлбэрээр)	Дүйцүүлсэн хувилбарыг хэрхэн нөхөх талаар судлаачдаас дэвшүүлж буй тайлбар болон заавар
			<p>ЭХ-ийн 12.1 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөл байдал буюу 12.1.2.1, 12.1.3, 12.1.4 дэх хэсэгт зааснаар насанд хүрээгүй хүүхдийг хүчиндсэн гэмт хэргийг хуульчилж өгсөн байдаг. ГХСОУ-ын энэхүү ангиллыг эдгээр гэмт хэргүүдтэй дүйцүүлж болох юм.</p> <p>ЭХ-ийн 12.1.2.1 заалт нь бүхэлдээ дүйцэж байгаа бол 12.1.3 болон 12.1.4 дэх хэсгүүд нь тайлбартайгаар дүйцүүлэх, эсвэл ГХСОУ-ын энэ ангилалд хамаарах агуулгыг тусад нь үзүүлэлт болгон нөхөх шаардлагатай байна.</p>	<p>Нэр томъёоны хувьд Насанд хүрээгүй хүнийг хүчиндэх, эсхүл хүүхдийг хүчиндэх гэх агуулгаар томъёолох нь зохистой.</p>
7	IV	030119	<p>Бусад төрлийн хүчингийн гэмт хэрэг.</p> <p>-</p>	<p>Other rape.</p> <p>-</p>
8	III	03012	<p>Бэлгийн дарамт. 030121, 030122, 030129</p> <p><u>ЭХ-д энэ төрлийн үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй болсон тул дүйцүүлэх хувилбар байхгүй.</u></p>	<p>Sexual assault.</p> <p>2015 онд батлагдсан ЭХ-д энэ төрлийн үйлдлийг 12.4 дэх зүйл болгон гэмт хэрэгт тооцож хуульчилсан хэдий ч 2017 оны нэмэлт, өөрчлөлтөөр гэмт хэрэгт тооцохгүй⁷⁶ болсон. Иймд энэ төрлийн гэмт хэрэг нь маягтаар үзүүлэлт болон нөхөгддөггүй.</p>

⁷⁶ “Бэлгийн дарамт учруулах” үйлдлийг 2020 онд Зөрчлийн тухай хуулийн 6.26 дугаар зүйлд зөрчил болгон хуульчилсан. Энэхүү судалгаанд ЭХ-д заасан гэмт хэрэгт дүйцүүлэх хувилбар дурдагдаж буй тул зөрчлийн талаар үргэлжлүүлэн судлалгүй үлдээе.

№ Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (ГХСОУА-ын доорх нэр томъёо нь НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан хэлбэрээр)	Дүйцүүлсэн хувилбарыг хэрхэн нөхөх талаар судлаачдаас дэвшүүлж буй тайлбар болон заавар
		<p>Харин ГХСОУ-ын энэхүү ангиллын агуулгаас харахад бэлгийн дарамт учруулах үйлдлийг энэ төрлийн гэмт хэрэгт нэг ангилал болгон дугаарласан байх бөгөөд түүнийг бие махбодод, сэтгэл санаанд, бусад хэлбэрээр гэж задаргаа ангилалд хуваасан байна. Эндээс харахад Бэлгийн дарамтын улмаас хохирогчид учирсан хохирол, түүний үр дагаврыг Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хохирол, үр дагавартай ойролцоо байдлаар ангилж задалсан агуулга ажиглагдаж байна.</p>	<p>Гэсэн хэдий ч практикт энэ төрлийн үйлдэлд холбогдох гэмт хэрэг, зөрчлийн талаар гомдол, мэдээлэл ЦБ болон бусад байгууллагад хэр хэмжээнд гарч байгааг цаашид судлах нь энэ төрлийн гэмт хэргийг гэмт хэрэгт тооцох эсэхийг тодорхойлох, гэмт явдалтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлд ач холбогдолтой гэдгийг анхаарах шаардлагатай юм.</p>
9	IV 030121	<p>Бие махбодод бэлгийн дарамт учруулах.</p> <p>Энэ төрлийн үйлдлийг ЭХ-д гэмт хэрэгт тооцоогүй тул дүйцүүлэх хувилбар байхгүй.</p>	<p>Physical sexual assault.</p> <p>-</p>
10	IV 030122	<p>Сэтгэл санааны бэлгийн дарамт.</p> <p>Энэ төрлийн үйлдлийг ЭХ-д гэмт хэрэгт тооцоогүй тул дүйцүүлэх хувилбар байхгүй.</p>	<p>Non-physical sexual assault.</p> <p>-</p>
11	IV 030129	<p>Бусад төрлийн бэлгийн дарамт.</p> <p>Энэ төрлийн үйлдлийг ЭХ-д гэмт хэрэгт тооцоогүй тул дүйцүүлэх хувилбар байхгүй.</p>	<p>Other sexual assault not elsewhere classified.</p> <p>-</p>

№ Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (ГХСОУА-ын доорх нэр томъёо нь НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан хэлбэрээр)	Дүйцүүлсэн хувилбарыг хэрхэн нөхөх талаар судлаачдаас дэвшүүлж буй тайлбар болон заавар
12	III 03019	<p>Бэлгийн хүчирхийллийн бусад төрөл. <u>ГХСОУА-д:</u> 3-р түвшний 03011 болон 03012 дахь ангилалд хамаараагүй, энэ төрлийн бусад гэмт хэргийг энэ ангилалд хамааруулах агуулгатай байна.⁷⁷ <u>МУ-ын ЭХ-д:</u> 12.1.1. ...эсхүл бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн. ГХСОУ-ын энэ ангиллын агуулгыг хүчиндэх бодон бэлгийн дарамтад хамаарахгүй, бэлгийн хүчирхийллийн бусад төрлийн гэмт хэрэг гэж ойлговол энэхүү хүснэгтийн 03011 ангиллын дүйцүүлсэн хувилбар болон тайлбар хэсэгт дурдсанчлан энэ ангиллыг ЭХ-ийн 12.1.1-д заасан “...эсхүл бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн” үйлдэлд хамаарах гэмт хэрэгтэй дүйцүүлж болох юм.</p>	<p>Other acts of sexual violence. ЭХ-д зааснаар энэ үйлдэл нь “Хүчиндэх” гэмт хэрэгт хамаарч байгааг анхаарч, ЭХ-ийн 12.1.1-д заасан дээрх үйлдлийг хэрхэн ойлгох, тодорхойлох асуудлыг тодорхой болгох шаардлагатай байна. Практикт энэ үйлдэлд хамаарах тохиолдол хэр хэмжээнд гардаг, тэдгээрийг хэрхэн зүйлчилж байгаа зэргийг тодруулах, мөн ЭХ-ийн 12.1.1-д заасан дээрх үйлдлийг хэрхэн ойлгож, хэрэглэх талаар тайлбартай болох зэрэг ажил хийгдсэнээр энэ асуудал илүү тодорхой болохоор байна. Хэрэв энэ үйлдлийг бэлгийн харьцаанд ороогүй ч хүч хэрэглэн бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл хийсэн гэх агуулгаар ойлгож хэрэглэх бол энэ агуулга талаасаа ГХСОУ-ын энэхүү ангилалд дүйцүүлэн нөхөх боломжтой гэж үзэж байна.</p>

⁷⁷ ICCS_English_2016_web.pdf. p 51

№ Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (ГХСОУА-ын доорх нэр томьёо нь НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан хэлбэрээр)	Дүйцүүлсэн хувилбарыг хэрхэн нөхөх талаар судлаачдаас дэвшүүлж буй тайлбар болон заавар
13	II 0302	<p>Бэлгийн мөлжлөг. 03021, 03022, 03029</p> <p>ГХСОУА-д:</p> <p>Хохирогчид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, эд хөрөнгө, албан тушаал, биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан бусдын биеийг үнэлүүлэх, эсвэл бэлгийн шинж чанартай үйлдэл хийлгэх замаар санхүүгийн, эд хөрөнгийн, нийгмийн эсвэл улс төрийн ашиг олох.⁷⁸</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u></p> <p>12.3 дугаар зүйл. Бэлгийн мөлжлөг</p> <p>16.9 дүгээр зүйл. Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах</p> <p>ЭХ-ийн 12.3.1, 12.3.2, 12.3.3.1, 12.3.3.2, 12.3.4 болон 16.9-д заасан гэмт хэрэгтэй энэхүү ангиллыг дүйцүүлэх боломжтой байна.</p>	<p>Sexual exploitation.</p> <p>ЭХ-ийн 12.3.1, 12.3.2, 12.3.3, 12.3.4 болон 16.9-д заасан гэмт хэргийн нийлбэр дүнгээр дүйцүүлэн нөхөх боломжтой байна.</p>

⁷⁸ Ibid, p 52

№	Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (ГХСОУА-ын доорх нэр томъёо нь НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан хэлбэрээр)	Дүйцүүлсэн хувилбарыг хэрхэн нөхөх талаар судлаачдаас дэвшүүлж буй тайлбар болон заавар
14	III	03021	<p>Насанд хүрэгчдийн бэлгийн мөлжлөг.</p> <p><u>ГХСОУА-д:</u></p> <p>ЭХ-ийн 12.3-т заасан гэмт хэргээс зөвхөн “насанд хүрээгүй хүүхдийн бэлгийн мөлжлөг”-т хамаарах гэмт хэргээс бусад гэмт хэргийг энд дүйцүүлэх боломжтой байна.</p> <p>Иймд ЭХ-д заасан бэлгийн мөлжлөгт хамаарах гэмт хэрэг дотроос ГХСОУ-ын 03022 дугаар ангилалд дүйцүүлсэн гэмт хэргээс бусад төрлийн гэмт хэргийг энэ хэсэгт дүйцүүлэх агуулгатай юм.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u></p> <p>12.3 дугаар зүйл. Бэлгийн мөлжлөг</p> <p>12.3.1. Хохирогчид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан зорчих эрхийг хязгаарлахгүйгээр бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулсан;</p> <p>12.3.2. Энэ гэмт хэргийг хохирогчийн биеийг үнэлүүлж ашиг олох зорилгоор:</p> <p>12.3.2.2. урьд энэ бүлэгт заасан гэмт хэрэг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн;</p>	<p>Sexual exploitation of adults.</p> <p>ЭХ-ийн дараах зүйл, хэсэг, заалтын нийлбэр дүнгээр энэ ангиллыг дүйцүүлэн нөхөхөөр байна. Үүнд:</p> <p><u>ЭХ-ийн 12.3.1 бүхэлдээ;</u></p> <p><u>ЭХ-ийн 12.3.2 дахь хэсгээс 12.3.2.2, 12.3.2.3, 12.3.2.4, 12.3.2.5, 12.3.2.6 дахь заалтуудын нийлбэр дүнгээр;</u></p> <p><u>ЭХ-ийн 12.3.3.1 дэх заалтын дүнгээр;</u></p> <p><u>ЭХ-ийн 12.3.4 дэх хэсгээс 12.3.4.2 дахь заалтын дүнгээр;</u></p> <p><u>ЭХ-ийн дээр дурдсан зүйл, хэсэг заалтын нийлбэр дүнг энэ ангилалд дүйцүүлэн нөхөхөөр байна.</u> Өөрөөр хэлбэл, бэлгийн мөлжлөгт хамаарах нийт гэмт хэргээс 03022 ангилалд дурдсан гэмт хэрэг буюу насанд хүрээгүй хүнд хохирсон гэмт хэргийг хасаад насанд хүрсэн хүн хохирсон гэмт хэргийн тоог гаргах замаар энэ ангилалд хамаарах тоон үзүүлэлтийг дүйцүүлэн нөхөх боломжтой байна.</p>

№ Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (ГХСОУА-ын доорх нэр томьёо нь НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан хэлбэрээр)	Дүйцүүлсэн хувилбарыг хэрхэн нөхөх талаар судлаачдаас дэвшүүлж буй тайлбар болон заавар
		<p>12.3.2.3. хохирогчид мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглүүлж;</p> <p>12.3.2.4. хохирогчийг жирэмсэн болгож;</p> <p>12.3.2.5. хоёр, түүнээс олон хүний эсрэг;</p> <p>12.3.2.6. байнга тогтвортой үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>12.3.4. Энэ гэмт хэргийг хохирогчийн биеийг үнэлүүлж ашиг олох зорилгоор:</p> <p>12.3.4.2. зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн.</p> <p>Энэ ангилалд ЭХ дахь дээр дурдсан гэмт хэргийг дүйцүүлэх боломжтой байна.</p>	
15 III 03022		<p>Насанд хүрээгүй хүүхдийн бэлгийн мөлжлөг.</p> <p>12.3.2.1. арван дөрвөөс арван найман насанд хүрээгүй хүнийг албадан оруулж;</p> <p>12.3.3.2. арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон;</p> <p>12.3.4.1. бага насны хүүхдийг албадан оруулж</p> <p>16.9 дүгээр зүйл. Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах</p>	<p>Sexual exploitation of children.</p> <p>ЭХ-ийн 12.3.2.1, 12.3.3.2, 12.3.4.1 дэх заалтад насанд хүрээгүй хүнээс өөр бусад үйлдлийн арга, гэмт хэргийн шинжийг хуульчлаагүй, зөвхөн насанд хүрээгүй хүнд хамаарсан агуулгатай байх тул тоон үзүүлэлтээс хасалт хийх шаардлагагүй, эдгээрийн нийлбэр дүнгээр дүйцүүлэн нөхөх боломжтой байна.</p>

№ Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (ГХСОУА-ын доорх нэр томьёо нь НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан хэлбэрээр)	Дүйцүүлсэн хувилбарыг хэрхэн нөхөх талаар судлаачдаас дэвшүүлж буй тайлбар болон заавар
		<p>ЭХ-ийн 12.3 дахь зүйлд Бэлгийн мөлжлөг гэсэн гэмт хэргийг хуульчилсан бөгөөд энэ зүйлийн дээр дурдсан хэсгүүдэд насанд хүрээгүй хүнд энэ төрлийн гэмт хэрэгт хохирсон үйлдлүүдийг нарийвчлан заасан байна. Иймд хүснэгтэд байгаа 12.3 дугаар зүйлийн 12.3.2.1, 12.3.3.2, 12.3.4.1 дэх хэсгүүдтэй дүйцүүлэхээр байна.</p> <p>“Насанд хүрээгүй хүний бэлгийн мөлжлөг” гэсэн энэ ангилалд “хүүхдийн садар самууныг сурталчилсан дүрс бичлэгийг эзэмших, бүтээх, хүүхдийг биеэ үнэлэхэд элсүүлэх, уруу татах, тус дэм үзүүлэх, зуучлах, хүүхдийн биеэ үнэлэлтийг нуун дарах, зохион байгуулах, ивээн тэтгэх, биеийг үнэлүүлэх зорилгоор байр, бусад газрыг хөлслүүлэх, түрээслүүлэх” зэрэг үйлдлүүд хамаарахаар заасан байдаг.</p>	<p>Энэ ангилалд заасан хүүхэд гэдгийг тухайн улсын үндэсний хууль тогтоомжид заасан хүүхэд гэх ойлголтоор ойлгох талаар ГХСОУА-д онцлон дурдсан⁷⁹ байдаг.</p> <p>Мөн энэ ангиллыг 0802 буюу биеэ үнэлэх болон садар самууныг сурталчилсан дүрс бичлэг болон нийтийн бэлгийн хэм хэмжээний эсрэг гэмт хэрэг, 0203 буюу хүний биед хохирол учруулсан бэлгийн шинж агуулаагүй боолчлол болон мөлжлөг, 02041 буюу бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах, 11021 буюу насанд хүрээгүй байдлын улмаас үйлдсэн гэмт хэрэг зэргээс ялгаж, зөв нөхөх нь чухал.</p> <p>0802 дахь ангиллын тайлбараас харахад хүүхдийн бэлгийн мөлжлөг, биеэ үнэлэх зэрэг гэмт хэрэг нь 0802 ангилалд хамаарахгүй гэж дурдсан⁸⁰ байна.</p>

⁷⁹ Ibid, p 52

⁸⁰ Ibid, pp 74-75

№ Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (ГХСОУА-ын доорх нэр томьёо нь НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан хэлбэрээр)	Дүйцүүлсэн хувилбарыг хэрхэн нөхөх талаар судлаачдаас дэвшүүлж буй тайлбар болон заавар
16 IV 030221		<p>Хүүхдийн садар самуун бүхий дүрс бичлэг. 030221, 030222, 030223, 030229 <u>ГХСОУА-д:</u> Насанд хүрээгүй хүүхдийн бэлгийн мөлжлөг гэсэн гэмт хэргийн ангилалд “Хүүхдийн садар самуун бүхий дүрс бичлэг” гэх гэмт хэрэг багтжээ.</p> <p>Энэ ангилал нь хүүхдийн садар самуун бүхий дүрс бичлэг хийх зорилгоор хүүхдэд туслах, тохиролцох, боломжоор хангах, ийм дүрс бичлэгийг эзэмших, сурталчлах, телевизээр дамжуулах, үзүүлэх, худалдаалах агуулгатай байна.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u> 12.3 дугаар зүйл бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн болгон бага насны хүүхдийг энэ төрлийн гэмт хэрэгт хохироосон, холбогдуулсан үйлдлийг хуульчилж өгсөн бол Хүүхдийн эсрэг гэмт хэргийн бүлэгт “хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах”, “хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах” гэмт хэргүүдийг хуульчилсан байдаг.</p> <p>16.8 дугаар зүйл. Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах (хамаарахгүй)</p>	<p>Child pornography. Ангиллын тайлбар хэсгийг судлан үзэхэд ойролцоо төрлийн гэмт хэргүүд түүний дотор 0802 дугаар ангилал буюу олон нийтийн бэлгийн хэм хэмжээний эсрэг гэмт хэргээс ялгаж ойлгох шаардлагатай байна. Ялгах гол шинж нь насанд хүрээгүй хүнд хамаатай байх гэсэн агуулгаар ойлгогдож байна.</p> <p>16.9 дүгээр зүйл. Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах (зарим хэсгээр) ГХСОУА-ын агуулгаас харахад садар самуун бүхий дүрс бичлэг нь хүүхэд оролцсон байх агуулгаар ойлгогдож байх тул энэхүү ангиллыг ЭХ-ийн 16.9 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн агуулгатай дүйцүүлэн нөхөх боломжтой байна. Учир нь 0302221 буюу “Хүүхдийн садар самуун бүхий дүрс бичлэг” гэх ангилал нь 03022 гэсэн 3 дугаар түвшний “Насанд хүрээгүй хүүхдийн бэлгийн мөлжлөг” гэсэн ангиллын задаргаа ангилал тул энэ гэмт хэрэгт хүүхэд оролцсон байх агуулгатай байна.</p> <p>Харин нөхөхдөө 16.9 дүгээр зүйлийн дүнг бүхэлд нь нөхөх үү, эсвэл өөр ойролцоо төрлийн ангилалд хамаарах үйлдлүүдийг ялгаж хэсэгчилсэн байдлаар нөхөх үү гэдэг дээр эргэлзээ үүсэж болохоор байна. Учир нь 030223 ангилалд “Хүүхэдтэй бэлгийн чанартай холбоо тогтоох” гэсэн ойролцоо төрлийн агуулга бүхий ангилал байгааг анхаарах шаардлагатай.</p>

№ Хамаарах түвшин	Ангилал Дүйцэл болон тайлбар (ГХСОУА-ын доорх нэр томъёо нь НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан хэлбэрээр)	Дүйцүүлсэн хувилбарыг хэрхэн нөхөх талаар судлаачдаас дэвшүүлж буй тайлбар болон заавар
	<p>16.9 дүгээр зүйл. Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах (зарим хэсгээр)</p> <p>ЭХ-д заасан дээрх гэмт хэргүүд нь чиглэгдсэн этгээдээрээ ялгаатай байдлаар ойлгогдож байна. 16.8 нь зөвхөн хүүхдэд чиглэсэн бөгөөд хүүхдэд сурталчлах, хүүхдийг уруу татах тухай бол 16.9 нь хүүхэд оролцсон үйлдэл байх бөгөөд чиглэсэн этгээд нь зөвхөн хүүхэд бус, нийтийг хамарсан өргөн хүрээнд ойлгогдож байна.</p> <p>Энэхүү ангиллыг ЭХ-ийн 16.9 дүгээр зүйлд заасан гэмт хэрэгтэй дүйцүүлж болох юм. Ингэхдээ 16.9-д заасан гэмт хэргээс Хүүхдийн садар самуун бүхий зөвхөн дүрс бичлэгт хамаарах гэмт хэргийг энэхүү ангилалд дүйцүүлэх боломжтой байна.</p>	<p>Иймд 030221 ангилалд зөвхөн 16.9-д холбогдох дүрс бичлэгт хамаарах гэмт хэргүүдийг тусад нь үзүүлэлт болгон нөхөж, харин 030223 ангилалд 16.9-д холбогдох дүрс бичлэгт хамаарахаас бусад гэмт хэргийг 030223 ангилалд тоолж дүйцүүлэн нөхөх нь эдгээр ангиллыг хооронд нь ялган нөхөхөд ач холбогдолтой. Ийнхүү тусад нь тоолж нөхөхийн тулд маягтад үзүүлэлт нэмэх шаардлага үүснэ.</p>

№	Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (ГХСОУА-ын доорх нэр томьёо нь НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан хэлбэрээр)	Дүйцүүлсэн хувилбарыг хэрхэн нөхөх талаар судлаачдаас дэвшүүлж буй тайлбар болон заавар
17	IV	030222	<p>Хүүхдийн биеэ үнэлэлт. ГХСОУА-д:</p> <p>Энэхүү ангилалд “хүүхдийн биеэ үнэлэх үйлчилгээнд төлбөр төлөх, хүүхдийг биеэ үнэлэлтэд элсүүлэх, уруу татах, дэмжих, зуучлах, нуун дарагдуулах, зохион байгуулах, ивээн тэтгэх, мэдсээр байж байр эсвэл бусад газрыг түрээслүүлэх”⁸¹ зэрэг үйлдлүүдийг хамааруулжээ.</p> <p>МУ-ын ЭХ-д:</p> <p>12.3.2.1. арван дөрвөөс арван найман насанд хүрээгүй хүнийг албадан оруулж;</p> <p>12.3.3.2. арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон;</p> <p>12.3.4.1. бага насны хүүхдийг албадан оруулж.</p> <p>Энэхүү ангиллыг ЭХ-ийн 12.3.2.1, 12.3.3.2, 12.3.4.1 дүгээр хэсэгт заасан гэмт хэрэгтэй дүйцүүлж болох юм.</p>	<p>Child prostitution.</p> <p>030222 гэх 4-р түвшний энэхүү ангилал нь 2-р түвшний 0302 ангиллын задаргаа ангилал тул 0302 ангиллыг бүрдүүлж буй гэмт хэрэг, үйлдэл болох ЭХ-ийн 12.3.2.1, 12.3.3.2., 12.3.4.1 дэх хэсгүүдэд заасан гэмт хэргүүдийг энэ ангилалд дүйцүүлэн нөхөх боломжтой.</p> <p>Нэр томьёоны хувьд Хүүхдийн биеийг үнэлэх гэмт хэрэг гэх нэршлээр ойлгож, хэрэглэх нь зохистой байна.</p>

⁸¹ Ibid, p 53

№ Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (ГХСОУА-ын доорх нэр томъёо нь НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан хэлбэрээр)	Дүйцүүлсэн хувилбарыг хэрхэн нөхөх талаар судлаачдаас дэвшүүлж буй тайлбар болон заавар
18	IV 030223	<p>Хүүхэдтэй бэлгийн чанартай холбоо тогтоох.</p> <p>3-р түвшний 03022 ангилалд дүйцүүлсэн бүх гэмт хэргээс түүний задаргаа болох 4 дүгээр түвшний 030221, 030222 ангилалд хамаарах гэмт хэргүүдийг хасаад үлдэж буй гэмт хэрэг байгаа бол тэдгээрийг 0302223 гэсэн энэ ангилалд дүйцүүлэх агуулгаар ойлгогдож байна.</p> <p><u>ГХСОУА-д:</u></p> <p>Хүүхэдтэй холбоо тогтоож, бэлгийн шинж чанартай үйлдэл хийх зорилгоор уулзах үйлдэл хийхийг ойлгоно.⁸² Тухайлбал, интернэтээр хүүхэдтэй холбоо тогтоож, эсвэл биечлэн уулзаж садар самуун бүхий хэлбэрээр биеийг нь ил гаргуулах.</p> <p><u>МУ-ын ЭХ-д:</u></p> <p>ЭХ-ийн 12 дугаар бүлэг 12.1-12.6 дугаар зүйл, мөн 16 дугаар зүйл 16.9 дүгээр зүйлд тус тус заасан гэмт хэргүүдээс 030221, 030222 ангилалд тоологдоогүй үйлдсэн гэмт хэрэг байгаа бол энэ хэсэгт дүйцүүлэх боломжтой.</p> <p>030221 ангилалд дүйцсэн ЭХ-ийн 16.9-д дүрс бичлэгт хамаарах үйлдлээс бусад үйлдэлд хамаарах гэмт хэргийг 030223 ангилалд дүйцүүлэх боломжтой.</p>	<p>Sexual grooming of children.</p> <p>16.9 дүгээр зүйл. Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах (зарим хэсгээр)</p> <p>ЭХ-ийн 16.9 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн дүнгээс ГХСОУ-ын 030221 болон 030223 дугаар ангиллын агуулгыг тусад нь үзүүлэлт болгон задалж, маягтад нэмэлт үзүүлэлт оруулж байж энэ ангилалд хамаарах тоон мэдээлэл нөхөгдөх боломжтой болох юм.</p> <p>Иймд ЭХ-ийн 16.9 дүгээр зүйлд хамаарах гэмт хэргээс 030223 ангиллын агуулгыг тусад нь үзүүлэлт болгон энэхүү ангиллыг дүйцүүлэн нөхөхөөр байна.</p>

⁸² Ibid, p 53

Хавсралт 3-ын үргэлжлэл

№	Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (ГХСОУА-ын доорх нэр томьёо нь НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан хэлбэрээр)	Дүйцүүлсэн хувилбарыг хэрхэн нөхөх талаар судлаачдаас дэвшүүлж буй тайлбар болон заавар
19	IV	030229	Бусад төрлийн хүүхдийн бэлгийн мөлжлөг. -	Other sexual exploitation of children. -
20	III	03029	Бэлгийн мөлжлөгийн бусад төрөл. -	Other acts of sexual exploitation. МУ-ын ЭХ-д Хүүхдийн бэлгийн мөлжлөг гэсэн гэмт хэргийг тусад нь зүйл болгон хуульчлаагүй. Харин бэлгийн мөлжлөг гэсэн гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн болгон хэд хэдэн заалтаар насанд хүрээгүй хүн, бага насны хүүхдийн бэлгийн мөлжлөгт хамаарах гэмт хэрэг, үйлдлүүдийг хуульчилж өгсөн байдаг. Иймд хүүхдийн бэлгийн мөлжлөгт холбогдох дээр дурдсан гэмт хэргүүдээс өөр гэмт хэрэг одоогийн ЭХ-д байхгүй. Харин хуульд нэмэлт, өөрчлөлт орох, шинэчлэгдэн батлагдах үед хүүхдийн бэлгийн мөлжлөгт хамаарах шинэ төрлийн гэмт хэрэг, үйлдэл хуульчлагдсан тохиолдолд энэ ангилалд дүйцүүлэн нөхөх хувилбар боловсруулах шаардлага үүсэж болох юм.
21	II	0309	Хүний биед хохирол учруулсан бэлгийн шинжтэй бусад гэмт хэрэг. <u>ГХСОУА-д:</u> 1-р түвшний 03 ангилалд багтаж буй 2-р түвшний 0301, 0302, 0309 гэсэн 3 төрлийн багц ангиллаас 0301 буюу “Бэлгийн хүчирхийлэл”, 0302 буюу “Бэлгийн мөлжлөг” гэсэн ангилалд хамаараагүй бэлгийн шинж чанартай хохирол учруулсан бусад гэмт хэрэг, үйлдлийг энэ ангилалд дүйцүүлэхээр байна.	Other injurious acts of a sexual nature. ГХСОУ-ын 030222 ангилалд хүүхдийн биеэ үнэлэх гэмт хэргийг зааж өгсөн тул насанд хүрээгүй хүнд хамаарах биеэ үнэлэх гэмт хэргийн талаар тухайн ангиллыг судалсан хэсгээс харна уу. ЭХ-ийн 12.2 болон 12.6 дугаар зүйлд хамаарах маягтаар гарах тоон үзүүлэлтийн нийлбэр дүнгээр энэхүү ангиллыг дүйцүүлэн нөхөхөөр байна. Нэр томьёоны хувьд Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг бусад гэмт хэрэг гэх нэршлээр ойлгож, хэрэглэх нь зохистой.

Хавсралт 3-ын цргэлжлэл

№ Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (ГХСОУА-ын доорх нэр томъёо нь НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан хэлбэрээр)	Дүйцүүлсэн хувилбарыг хэрхэн нөхөх талаар судлаачдаас дэвшүүлж буй тайлбар болон заавар
			<p>Энэ ангиллыг ГХСОУА-ын 2-р түвшний 0802 буюу “Нийтээр тогтсон бэлгийн хэв журмын хэм хэмжээний эсрэг үйлдэл”-ээс хэрхэн ялгах асуудал нь тодорхойгүй, эргэлзээтэй байна. Тухайлбал, 0802 ангиллын тайлбараас харахад биеэ үнэлэх, бэлгийн харьцааны хууль бус хэлбэрт багтах гэмт хэргүүд хамаарах талаар заасан бол хамаарахгүй гэмт хэргийн хэсэгт тухайлбал, 020111 ангилал дахь эмэгтэй хүний бэлэг эрхтнийг зэрэмдэглэх үйлдэл багтах талаар дурдсан⁸³ мөн 08021 буюу “Биеэ үнэлэх хэрэг” гэсэн ангиллын агуулгыг “нийгмийн бэлгийн хэв журмын хэм хэмжээг зөрчин биеэ үнэлэх” гэж тодорхойлсон байх жишээтэй.</p> <p>МУ-ын ЭХ-д:</p> <p>12.2 дугаар зүйл. Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах.</p> <p>12.6 дугаар зүйл. Биеэ үнэлэхийг зохион байгуулах.</p>

⁸³ ICCS_English_2016_web.pdf. 37 дахь тал. 020111 ангиллын тайлбар хэсэгт дээрх үйлдлийг энэ ангиллын агуулгад хамааруулан дурдсан байна. Иймд энэ үйлдэл нь 020111 ангилалд хамаарч байх тул 0802 ангилалд хамаарахгүй гэсэн санааг тэдгээр ангиллуудын “хамааруулсан”, “хамааруулаагүй” гэсэн тайлбар (заавар) хэсгээс харж болохоор байна.

Хавсралт 3-ын үргэлжлэл

№ Хамаарах түвшин	Ангилал	Дүйцэл болон тайлбар (ГХСОУА-ын доорх нэр томьёо нь НҮБ-аас орчуулсан гарын авлагад дурдагдсан хэлбэрээр)	Дүйцүүлсэн хувилбарыг хэрхэн нөхөх талаар судлаачдаас дэвшүүлж буй тайлбар болон заавар
			<p>ЭХ-д заасан эдгээр гэмт хэрэг нь 1-р түвшний 03 дугаар ангилал дахь 2-р түвшний 0301 болон 0302 ангилалд хамаараагүй тул 0309 ангилалд хамаарч болох талтай. Иймд энэхүү ангиллын агуулгыг нарийвчлан судлах шаардлагатай. Гэвч дээр дурдсанчлан ЭХ-ийн эдгээр гэмт хэрэг нь 020111 болон 0802 дугаар ангилалд хамаарах агуулгатай байвал 0302 ангилалд давхар дүйцүүлэн нөхөхгүй⁸⁴ юм.</p> <p>ЭХ-ийн 12.2-т “бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан үйлдэлд “эмэгтэй хүний бэлэг эрхтнийг зэрэмдэглэх үйлдэл” хамаарах эсэхийг хэрхэн ойлгож, тодорхойлох нь ЭХ-ийн 12.2-т заасан гэмт хэргийг энэ ангилалд хамааруулах эсэхийг тодорхой болгож өгөхөөр байна.</p>

⁸⁴ ГХСОУА-ыг судлах явцад нэг гэмт хэрэг, үйлдэл ижил түвшний 2 болон түүнээс дээш ангилалд давхар тоологдохоос сэргийлэх зорилгоор “хамааруулсан”, “хамааруулаагүй” гэх тайлбар (зааврыг) тусгасан гэж ойлгож байна. ГХСОУА-д бүрэн утгаараа дүйцэж байгаа гэмт хэргийг шууд нөхөх, эсвэл хэсэгчилсэн байдлаар дүйцэж байна гэж үзвэл тайлбартайгаар нөхөх арга зүй байна. Иймд судалгааны ажлын явцад “хавсралт” хүснэгтэд тухайн ангиллыг шууд нөхөх үү, эсвэл тайлбар хийх үү, хасалт хийж нөхөх үү, тухайн ангиллын агуулга нь тодорхой эргэлзээгүй байна уу, эсвэл өмнө нь тодорхойлох асуудал байна уу гэх зэргээр судлаачид өөрсдийн байр суурийг илэрхийлэх агуулгыг тухай бүр тэмдэглэсэн болно.

НОМ ЗҮЙ

1. Adolf Schünke / Horst Schröder. Strafgesetzbuch Kommentar. 25.Auf., C.H. Beck,sche Verlagsbuchhandlug Мьнchen 1997
2. Black's Law Dictionary, Ninth edition, Bryan A.Garner editor in chief, USA., 2009
3. Carl Creifelds. Rechtswörterbuch. 21 Aufl., . Verlag C.H.Beck Мьнchen 2014
4. ICCS_English_2016_web.pdf.
5. United Nations Economic and Social Council. Social Commission. Criminal Statistics: Recommendations of the Secretary-General (8 January 1951). E/CN.5/233
6. United Nations Economic Commission for Europe. Conference of European Statisticians. Report of the UNODC/UNECE Task Force on Crime Classification to the Conference of European Statisticians. 2011. Available:www.unodc.org/documents/data-and-analysis/statistics/crime/Report_crime_classification_2012.pdf>. United Nations Economic Commission for Europe. Conference of European Statisticians. Report of the Conference of European Statisticians Sixtieth plenary session (6-8 June 2012). ECE/CES/83.
7. Wolfgang Joecks. Strafgesetzbuch Studienkommentar. 7.Auf., Verlag C.H. Beck Мьнchen. 2007
8. Гэмт хэргийн статистикийн олон улсын ангилал (ГХСОУА). Хувилбар 1.0. 2015 оны 3 дугаар сар. НҮБ-ын гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газар (НҮБ-ын ГХМБТГ)-аас боловсруулав. Үндсэн баримт бичгийг хөрвүүлсэн НҮБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газар
9. Золбоо Т., Сургалтын эрүүгийн хууль, УБ, 2020
10. Зөрчлийн тухай хууль (шинэчилсэн найруулга), 2017
11. Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2017, Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, УБ., 2018
12. Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2018, Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, УБ., 2019
13. Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал 2019 (албан хэрэгцээнд), ЦЕГ, УБ., 2020
14. Нарангэрэл С., Монголын эрх зүйн эх толь бичиг, 4 дэх хэвлэл, УБ., 2015
15. Нарангэрэл С., Хууль зүйн англи-монгол эх толь, УБ., 2012
16. Статистикийн тухай хууль (шинэчилсэн найруулга), 1997
17. Цэдэвсүрэн М., Гэмт хэргийн статистикийн олон улсын ангиллыг үндэсний онцлогт нийцүүлэх зарим асуудал. ЭРХ ЗҮЙ/NUM LAW REVIEW, 2019 №3 (47), 93-115 дахь тал
18. Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга), 2015